

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН  
2020 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2020.12.01

Сүхбаатар сум

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар:**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 11-р сард 1 удаа цахим хэлбэрээр хуралдаж 3 асуудал хэлэлцэн 4 тогтоол баталлаа. Үүнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хоёрдугаар хуралдаан зарлах тухай асуудлыг хэлэлцээд хуралдааныг 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдөр цахим хэлбэрээр хуралдуулахаар товыг тогтоолоо.

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын цалинг тогтоох тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

3.Аж үйлдвэрийн салбарт оруулсан хөдөлмөр зүтгэлийг нь үнэлж Сүхбаатар сумын ахмад настан Гаанжууржавын Зоригийг "Аж үйлдвэрийн гавьяат ажилтан" цолоор, эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим хүмүүсийг төрийн одон, медалиар шагнуулахаар уламжлав. Цэргийн гавьяаны одонгоор 1, Алтан гадас одонгоор 4, Хөдөлмөрийн хүндэт медалиар 14 хүнийг шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид уламжиллаа.

Мөн аймгийн ирэх оны төсвийг хэлэлцэн батлахтай холбогдуулан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албанаас 11-р сарын 28-ны өдөр нийт төлөөлөгчдөд Санхүү төрийн сангийн хэлтсээс цахим сургалт мэдээллийг өгүүллээ.

Цаг үеийн онцгой нөхцөл байдалтай байгаа үед аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч, Төлөөлөгчид өөрсдийн санаачилгаар аймгийн Онцгой комисст 3.7 сая төгрөгийг хандивлалаа.

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

Аймгийн Засаг даргаас гэнэтийн аюул осол, бусад шалтгааны улмаас орон гэргүй болсон 3 өрхөд дээвэр туурга бүрэн хэрэглэлтэй гэр, аймгийн Засаг даргын Тамгын газар, Сэлэнгэ аймаг дахь Улаан загалмайн хороо хамтран нийгмийн халамж дэмжлэг зайлшгүй шаардлагатай 2 өрхөд хувцас хэрэглэл, гэр ахуйн бараа бүтээгдэхүүнийг олголоо.

Төрийн албаны Зөвлөлийн Сэлэнгэ аймаг дахь Салбар зөвлөл Төрийн албаны ерөнхий шалгалтыг 11-р сарын 6, 7, 8-ны өдөр зохион байгуулж, шалгалтад 472 хүн бүртгүүлснээс 353 хүн оролцож, 105 хүн тэнцсэн. Сэлэнгэ аймгийн Хүдэр сумын иргэн Батбаярын Билгүүн төрийн албаны ерөнхий шалгалтын авбал зохих нийлбэр 100 онооноос "100 оноо" авсан нь Улсын хэмжээний анхдагч үзүүлэлт болсон.

**Аймгийн Онцгой комиссын үйл ажиллагааны талаар:** Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 178 дугаар Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай тогтоол, 2020 оны 11 дүгээр

сарын 15-ны өдрийн “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 181 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах чиглэлээр аймгийн Засаг даргын 2020 оны “Зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, бүх шатны боловсролын байгууллагын хичээл, сургалтын болон зарим төрлийн үйл ажиллагааг түр зогсоож, цагийн хязгаарлалт тогтоох тухай” А/306, “А/306 дугаар захирамжид нэмэлт өөрчлөлт оруулж, хугацаа сунгах тухай” А/310, Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр хугацаанд хориглох тухай А/311 дүгээр захирамж, “Сэлэнгэ аймгийн Коронавируст халдварт “Ковид-19”-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөө” боловсруулан гамшгаас хамгаалах алба, сумдын Засаг даргын Тамгын газар, аж ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлэн үүрэг чиглэлээр ханган ажиллаж байна.

Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан аймгийн Онцгой комиссын хуралдааныг /16 удаа/ тухай бүр зохион байгуулан үүрэг чиглэлээр ханган ажиллаж байна.

Улсын Онцгой комиссын шуурхай бүлгийн ажлын хэсгийн дарга Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяраар ахлуулсан ажлын хэсэг 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдрөөс 11 дүгээр сарын 29-ний өдрүүдэд Сэлэнгэ аймагт ажиллан Сүхбаатар, Мандал, Алтанбулаг сумын нөхцөл байдалтай газар дээр нь танилцан нэгдсэн удирдлага зохион байгуулалт, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажилласан.

2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөс Улсын Онцгой комиссын Шуурхай бүлгийн ажлын хэсгийн ахлагч, Батлан хамгаалахын ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар, Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газрын дарга, хурандаа Б.Мандахгэрэл нар Сэлэнгэ аймагт ажиллаж байна.

**Эрүүл мэндийн чиглэлээр:** 2020 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар Сэлэнгэ аймгийн хэмжээнд түргэвчилсэн болон PCR шинжилгээгээр 5 иргэнд хариу “Эерэг” гарч батлагдсан. Нийт батлагдсан 179 тохиолдлын 41 иргэнийг түргэвчилсэн болон PCR шинжилгээгээр, 138 иргэнийг ойрын хавьтлаас тандалт судалгаа, шинжилгээгээр илрүүлсэн.

Ойрын 1174, дам 862 хавьтал, нийт 2036 хавьтлыг тогтоон, тандалт судалгааны ажил үргэлжилж байна.

**Шинжилгээнд хамрагдсан иргэний тоог  
сум, сумаар нь мэдээлвэл (өссөн дүнгээр)**

Сар/ өдөр	Аймаг, сум	Батлагдсан тохиолдол	Шинжилгээнд хамрагдсан иргэний тоо		Нийт
			Түргэвчилсэн	PCR	
XI/30	Сүхбаатар	174	17927	3925	21852
	Мандал	3	6862	3762	10624
	Алтанбулаг	2	2242	69	2311
	Сайхан	-	670	68	738
	Баянгол	-	303	5	308
	Бусад	-	2189	-	2189
Бүгд		179	30309	7829	38138

**Тусгаарлах байрны мэдээлэл:** Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 20, “Номин” зочид буудалд 29, “Сэлэнгэ” зочид буудалд 20, “Дельфин” зочид буудалд 21, Төмөр замын буудалд 13, “Цэцэг” зочид буудалд 6, “Оргил” зочид буудалд 11, “Хайрхан” зочид буудалд 8, Ахмадын сувилалд 22, 1 дүгээр сургуулийн дотуур байранд 43, 4 дүгээр цэцэрлэгт 31, 3 дугаар цэцэрлэгт 28, Алтанбулаг сумын “Дельфин” зочид буудалд 7, “Чандмань” зочид буудалд 12, Мандал сумын Нэгдсэн эмнэлэгт 13, “Цант-Орхон” зочид буудалд 14, Зүүнбүрэн сумын Эрүүл мэндийн төвд 1, нийт 19 цэгт **299** иргэн тусгаарлах байранд байна.

**Гэрийн тусгаарлалт ажиглалтад:** Сүхбаатар суманд 7 цэгт 30, Алтанбулаг суманд 9 цэгт 37, Баянгол суманд 11 цэгт 37, Зүүнбүрэн суманд 2 цэгт 4, Сайхан суманд 1 цэгт 7, Мандал суманд 6 цэгт 25, нийт **36** цэгт **140** иргэн байна. Аймгийн хэмжээнд нийт **55** цэгт **439** иргэн тусгаарлалтад байна.

**Мандал сумын нөхцөл байдлын мэдээ:** Сэлэнгэ аймгийн Мандал суманд 11 дүгээр сарын 30-ны өдөр гамшгаас хамгаалах албад, мэргэжлийн ангийн нийт 231 ажилтан, алба хаагч, 48 тээврийн хэрэгсэлтэй үүрэг гүйцэтгэж байна.

Мандал суманд нийт тохиолдлын тоо 3, түргэвчилсэн оношлуурын шинжилгээнд хамруулсан 340, PCR шинжилгээнд хамруулсан 607, ойрын хавьтлын 64, дам хавьтлын 143-ыг тогтоож тандалт судалгааны ажил үргэлжилж байна.

Сумын хэмжээнд 2020 оны 11 дүгээр сарын 19-өөс 30-ны өдрүүдэд түргэвчилсэн оношлуураар 5886, PCR шинжилгээнд 3631 хүнийг хамруулж, **48,370.5** м.кв талбайд халдваргүйтгэлийн ажил хийгээд байна.

**Эргүүл хяналтын чиглэлээр:** Аймгийн Онцгой комиссын даргын баталсан Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт коронавирусын цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг чангатгах, эрчимжүүлэх ажиллагааны хүрээнд эргүүл, хяналт зохион байгуулах хуваарийн дагуу томилгоот алба хаагчид 08:00-22:00 цагийн хооронд 2 ээлжээр нийт 10 байгууллагын 161 алба хаагч үүрэг гүйцэтгэж ажиллаж байна.

ЦЕГ-ын даргын А/280 дугаар тушаалаар ЦЕГ-ын Нийтийн хэв журам хамгаалах олон нийтийн аюулгүй байдлыг хамгаалах албаны даргаар ахлуулсан Цагдаагийн түр хүрээ байгуулагдаж, Сүхбаатар, Алтанбулаг сумын гадна талаас орох, гарах зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд 13 цэгт 16 алба хаагч 3 тээврийн хэрэгсэлтэй, хөдөлгөөнт эргүүлээр 6 чиглэлд 28 алба хаагч 7 тээврийн хэрэгсэлтэй ажиллаж байна.

Улаанбаатар Сэлэнгэ чиглэлд төмөр замын цагдаагийн газраас 39 алба хаагч 25 өртөөнд үүрэг гүйцэтгэж байна.

Мандал сумын нутаг дэвсгэрт хөл хорионы дэглэм сахиулах гудамж, талбайд иргэдийн хөдөлгөөнийг хязгаарлах чиглэлээр цагдаагийн 11 алба хаагч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтсийн хаалттай 433 дугаар анги 10, төрийн захиргааны байгууллагын 50 ажилтан албан хаагч 2 ээлжээр автомашин, иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж ажиллаж байна.

**Ариутгал халдваргүйтгэлийн мэдээ /өссөн дүнгээр/:** Аймгийн хэмжээнд 2020 оны 11 дүгээр сарын 14-30-ны өдрүүдэд голомтын халдваргүйжүүлэлтийг 340 объектод 182615.6 м.кв талбайд Зоонозын өвчин судлалын төв, Мандал сумын нэгдсэн эмнэлэг, урьдчилан сэргийлэх зорилгоор

нийтийн эзэмшлийн зам талбайд 212720 м.кв талбайд Онцгой байдлын газар, байрны орц, хонгил, гадна талбайд 143325.8 м.кв талбайд Мал эмнэлгийн газар, хүнсний худалдааны газруудад 124947 м.кв талбайд тус тус халдваргүйжүүлэлтийг хийж, аймгийн хэмжээнд голомтын болон урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг **668608.4** м.кв талбайд хийхэд Мэргэжлийн хяналтын газраас хяналт тавьж ажиллалаа.

**Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:**

COVID -19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд ОХУ-аас Алтанбулаг боомтоор 11-р сарын 01-17-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 555 тээврийн хэрэгсэл нэвтэрч тухай бүр ариутгал халдваргүйжүүлэлтийг хийн цагдаагийн байгууллагын хяналт доор Улаанбаатар хот руу хүргүүлсэн.

ОХУ-ын Хиагт, Улаан-Үүд хотуудад цар тахлын халдвар нэмэгдэж ачаа тээврийн автомашинаар халдвар Монгол Улсад дамжин ирэх эрсдэл өндөр байгаатай холбогдуулан Улсын онцгой комиссын ажлын хэсэг Сэлэнгэ аймагт 3 хоног ажиллаж, эрсдэлийн үнэлгээ хийн улмаар нөхцөл байдлыг Улсын онцгой комиссоор хэлэлцэн асуудлыг Засгийн газарт танилцуулснаар Монгол Улсын Алтанбулаг боомтын үйл ажиллагааг 2021 оны 02-р сар хүртэлх хугацаанд бүрэн зогсоосон.

Монгол Улс дотооддоо халдвар илэрсэнтэй холбогдуулан Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоолоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын захирамжаар аймгийн хэмжээнд хатуу хөл хорио тогтоон автозамын хөдөлгөөнийг бүрэн, худалдаа үйлчилгээний газруудын үйл ажиллагааг хэсэгчлэн зогсоож иргэдээс түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авах, батлагдсан тохиолдлуудыг Улаанбаатар хот руу тээвэрлэх, дам хавьтлуудыг илрүүлэн тусгаарлах, гудамж талбай, аж ахуйн нэгжүүдэд ариутгал халдваргүйжүүлэлт хийх, эргүүл хяналт зохион байгуулах зэргээр 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн тасралтгүй үйл ажиллагаа явуулж байна.

11 дүгээр сарын байдлаар гамшиг ослын 11 удаагийн дуудлага ирснээс объектын гал түймэр 7, усны ослын 1, газар хөдлөлтийн чичирхийллийн 1 дуудлага ирсэн байна.

**Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар:**

1. Ариутгал халдваргүйтгэлийн мэдээ /өссөн дүнгээр/:

Аймгийн хэмжээнд 11 дүгээр сарын 14-26-ны өдрүүдэд голомтын халдваргүйжүүлэлтийг 258 объектод 131808.6 м2 талбайд Зоонозын өвчин судлалын төв, Мандал сумын нэгдсэн эмнэлэг, урьдчилан сэргийлэх зорилгоор нийтийн эзэмшлийн зам талбайд 212720 м2 талбайд Онцгой байдлын газар, байрны орц, хонгил, гадна талбайд 138977.8 м2 талбайд Мал эмнэлгийн газар, хүнсний худалдааны газруудад 117171 м2 талбайд Мал эмнэлгийн газрын халдваргүйтгэлийн баг халдваргүйжүүлэлтийг хийж Мэргэжлийн хяналтын газраас хяналт тавьж ажиллалаа. 11 дүгээр сарын 26-ны өдрийн 21 цагийн байдлаар аймгийн хэмжээнд голомтын болон урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлтийг 600677.4 м2 талбайд хийгээд байна.

11 дүгээр сарын 26-ны өдрийн 21 цагийн байдлаар 21 объектод голомтын халдваргүйжүүлэлтийг 11891 м2 талбайд Зоонозын өвчин судлалын төв, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг, хүнсний худалдааны газруудад 300 м.кв талбайд

халдваргүйжүүлэлтийг Мандал сумын Мал эмнэлгийн нэгж хийж Мэргэжлийн хяналтын газраас хяналт тавьж ажиллалаа. 2020 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр ЗӨСТ, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Мал эмнэлгийн нэгж нийт 12191 м.кв талбайд халдваргүйжүүлэлт хийсэнд Мэргэжлийн хяналтын газраас хяналт тавьж ажиллалаа.

2. Ажиглалтын байрны бэлтгэл хангуулсан байдал:

11 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар Сүхбаатар суманд Ерөнхий боловсролын 2 дугаар сургуульд 24, 3 дугаар сургуульд 57, Спортын ордонд 30, Спорт сургуульд 78, нийт 189 ор шинээр дэлгэн бэлтгэл бэлэн байдлыг хангуулахад халдвар хамгааллын дэглэмийг сахиулан хяналт тавьж ажиллаж байна.

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын 01/253 дугаар удирдамжийн хүрээнд Сүхбаатар сумын хэмжээнд 12 тусгаарлан ажиглах байрнаас гарч буй энгийн болон аюултай хог хаягдлыг цуглуулалт, тээвэрлэлтийн байдалд хяналт тавьж ажиллахад аймгийн Нэгдсэн эмнэлэг нь хувь хүнтэй гэрээ хийж ачааны машин түрээслэн ахуйн болон тусгай хог хаягдал зайлуулж байгаа боловч тус машин тээврийн хэрэгслийн аюулгүй байдал шаардлага хангахгүй, тусгай болон аюултай хог хаягдлыг ил задгай битүүмжлээгүй ачсан, хог хаягдлыг халдваргүйтгэл хийлгүй тээвэрлэсэн, хог хаягдал зайлуулах маршрут гаргаагүй, хог хаягдал хариуцсан ажилтан, жолооч нар хамгаалах хувцас хэрэгслийг бүрэн өмсөөгүй зэрэг зөрчил илэрсэн.

Тусгаарлан ажиглалтын 3 байрны хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахад, хоолны цэс батлуулан, хоолны дээжийг өдөр бүр авч бүртгэл хөтөлж хэвшсэн, хоол үйлдвэрлэлийн байр эрүүл ахуйн шаардлага хангасан, тогооч ажиллагсад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд бүрэн хамрагдсан, хоол үйлдвэрлэлийн байранд цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийж хэвшсэн байна.

Аймгийн хэмжээнд тусгаарлан ажиглах байрыг бэлдэх явцад илэрч буй зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор улсын байцаагчийн 14 заалттай зөвлөмжийг өгч бүх сумдын Засаг дарга нарт хүргүүлж, биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна.

3. Хүнсний зах, дэлгүүр, худалдааны төвийн хяналт шалгалтын мэдээ /гар ариутгалын бодис, амны хаалт, халуун хэмжигч, иргэдийн бүртгэлийн тоо/

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2020 оны 20 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу Сэлэнгэ аймгийн хэмжээнд 11-р сарын 13-26-ны өдрүүдэд хүнсний худалдааны 246 объектод төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийхэд, хяналт шалгалтад хамрагдсан 218 объект 11510 иргэн үйлчлүүлсэн бүртгэлийг хөтөлсөн байна.

Шалгалтын явцад 313 зөрчлийг илрүүлж, 153 зөрчлийг арилгуулж, шалгалтын явцад 146 заалттай 10 зөвлөмжийг өгч ажилласан. Зөвлөмжийн биелэлт 78 хувьтай байна. Хяналт шалгалтад хамрагдсан 246 объектын 75.3 хувьд үйлчлүүлэгчийн биеийн халуун үзэж бүртгэл хөтөлсөн, 24.7 хувьд үйлчлүүлэгчийн биеийн халууныг үзэх нөхцөл бүрдээгүй, үйлчлүүлэгч аж ахуйн нэгж байгууллагын ажилтан албан хаагчид амны хаалтыг 100 хувь хэрэглэдэг, үйлчлүүлэгчдийн хүн хоорондын зай барьж үйлчлүүлэх нөхцөлийг 81.4 хувь бүрдүүлсэн, түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалтын горим хугацаа, гарал

үүслийн баталгаажилтыг нийт хяналт шалгалтад хамрагдсан газруудын 15.8 хувь бүрдүүлсэн /гарал үүсэл, баталгаажилт дутуу/, ажлын байрны угаалга цэвэрлэгээ халдваргүйжүүлэлтийг 100 хувь хийж /халдваргүйжүүлэлтэд жавелин, белизна, жавельчин зэрэг бодисыг ашиглаж байна. Үйлчлүүлэгчдэд эрүүл ахуйн шаардлага хангасан гар угаах нөхцөлийг 179 объектод бүрдүүлсэн, 246 объектод гар халдваргүйжүүлэх нөхцөлийг 100 хувь бүрдүүлсэн, спирт суурьтай гар ариутгагч бодисыг хэрэглэж байна.

Хяналт шалгалтын явцад хэрэглэж дуусах хугацаа хэтэрсэн 35 нэр төрлийн 165 ширхэг 374.4 мянган төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг акт үйлдэн хураан авч зохих журмын дагуу шилжүүлэхээр шийдвэрлээд байна.

“Гурван мэргэд” ХХК-ий хүнсний зах, “Сэлэнгэ Олон улсын худалдааны төв”-ийн хүнсний ногооны тасгийн түрээслэгч 13, жимсний лангуу түрээслэгч 3 иргэн, автомашины хөдөлгөөнийг хориглосон тул бараа бүтээгдэхүүнээ өөрсдийн унаагаар зөөвөрлөх боломжгүй байна.

4. Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын даргын 2020 оны 01/3085 дугаар “Ундны ус, ариун цэврийн байгууламж, хог хаягдлын аюулгүй байдлыг хангаж ажиллах тухай” албан бичгийн дагуу Сүхбаатар сумын “Урсгал-Ус” ХХК-ий төвлөрсөн шугамд холбогдсон 11 ус түгээх байрнаас ундны усны чанар, аюулгүй байдлын үзүүлэлт тодорхойлох зорилгоор итгэмжлэгдсэн лабораторид дээж авч шинжилгээнд хамруулж ажиллалаа.

5. Эмийн сангийн үйл ажиллагаанд хяналт тавьсан мэдээ:

Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын даргын 01/249 дугаар удирдамжийн хүрээнд 11-р 13 -ны өдрөөс Сэлэнгэ аймагт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй 18 эмнэлэг, эмийн сан коронавируст халдварын үед эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх тухай, яаралтай тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийн бэлэн байдал, нөөцийн судалгаа хийх, нөөц бүрдүүлсэн байдал, денатурат спиртын худалдаалалт, гар ариутгах шингэн, маск, бээлийний нөөц бүрдүүлэлт, үнийн өсөлтөд анхаарч ажиллах, халдвараас урьдчилан сэргийлэх талаар улсын байцаагчийн зөвлөмж, зааварчилгааг цахим болон утсаар өгч хариуг баримт материалын хамт баталгаажуулан хяналт тавин ажиллаж байна.

6. Эмнэлгийн гаралтай хог хаягдлын мэдээ: /Өссөн дүнгээр/

11-р сарын 25-ны өдрийн байдлаар аймгийн Нэгдсэн эмнэлэг 1337.1 кг хог хаягдлыг Монгол Улсын ЭМС-ын 2020 оны А/269 тоот тушаалын 8-р хавсралтад тусгагдсаны дагуу аймгийн эмнэлгийн гаралтай хог хаягдлын барилга байгууламжид хүлээн авч автоклавт оруулан ариутгал, халдваргүйжүүлэлт хийж тусгайлан бэлтгэсэн цэгт тээвэрлэн шатааж, булшилж орчны хөрсөнд 0.5 хувийн гипо хлорид кальцийн сүүн уусмалыг бэлтгэн 1 м<sup>2</sup> талбайд 500 мл бодис байхаар тооцоолон халдваргүйжүүлэн, халдваргүйжүүлэлт хийх явцад халдвар хамгааллын дэглэмд Мэргэжлийн хяналтын газраас хөндлөнгийн хяналт тавьж ажилласан.

7. Бусад ажлын талаар:

1. Монгол Улсын Засгийн газрын “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2020 оны 20 дугаар тушаалаар баталсан “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээний удирдамж”-ийн дагуу Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын даргын баталсан 2020 оны 01/347 дугаар

“Ундны ус хангамж, бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд хүн амын ундны усны чанар, аюулгүй байдал, ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа, цэвэрлэгээний түвшинд шалгалт хийж, үнэлгээ дүгнэлт өгөх зорилгоор тус аж ахуйн нэгжийн лабораторийн эрхлэгч Б.Төртүвшин, ариутгах татуургын технологич М.Отгонбаяр нарыг байлцуулан 11-р сарын 12, 19, 25-ны өдрүүдэд шинжилгээ бүхий шалгалтыг хийж гүйцэтгэлээ.

Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах улсын байцаагчийн “Урсгал-Ус” ХХК-ий захирал А.Алтансүхэд 11-р сарын 25-ны өдрийн 18-03-034/360 дугаар бүхий албан шаардлага, итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнг үндэслэн гаргасан улсын байцаагчийн 11-р сарын 25-ны өдрийн 18-03-034/228, 18-03-034/229 дугаар бүхий дүгнэлт, шуурхай хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх тухай газрын даргын 11-р сарын 01/740 дугаар бүхий мэдэгдэл, газрын даргын аймгийн Онцгой комиссын даргад 11-р сарын 25-ны өдрийн 01/739 дугаар албан бичгийг тус тус хүргүүлэн ажиллалаа.

2. Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын даргын 2020 оны 01/3138 дугаар албан бичгийн дагуу аймгийн Нэгдсэн эмнэлэг, Сүхбаатар сумын тусгаарлан ажиглах байрнаас гарч буй эмнэлгийн гаралтай хог хаягдал болон ахуйн гаралтай хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах, тээвэрлэх, устгах үеийн халдвар хамгааллын дэглэмд тогтмол хяналт тавьж ажиллаж байна. Хяналт тавьж ажиллах явцад аймгийн Нэгдсэн эмнэлгийн аюултай хог хаягдал боловсруулах төвлөрсөн барилга байгууламжид хүлээж авч автоклавт оруулан ариутгаж байгаа боловч буталгаа хийж халдваргүйжүүлэх тоног төхөөрөмжийн хүчин чадал хүрэлцэхгүйгээс ашиглах боломжгүй, автоклавын хүчин чадлаас хамаарч 24 цагаар ажиллуулан ажиллагсад хог хаягдал боловсруулах төвлөрсөн байгууламжийн барилга нь ажиллагсдын амрах өрөөгүй улмаас халдваргүйжүүлэх хэсэгт буюу буталгааны тоног төхөөрөмж байршуулсан хэсэгт амрах өрөөг хийсэн, хог хаягдлын автоклавт 1210С-ийн хэмд 20 минутын хугацаанд ариутгадаггүй, аюултай хог хаягдал хүлээн авах автоклавт ариутгах халдваргүйжүүлж бутлах халдваргүйжүүлсэн хог хаягдлыг эцсийн устгалын цэг рүү тээвэрлэх хүртэл түр хадгалах технологи дамжлага алдагдсан зэрэг зөрчил дутагдлууд илэрсэн. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар газрын даргын 2020 оны 01/741 дугаар мэдэгдлийг аймгийн Нэгдсэн эмнэлэгт, аюултай хог хаягдал боловсруулах, устгах ажиллагаатай холбоотой үүссэн эрсдэлийн талаар аймгийн Онцгой комиссын даргад 01/742 дугаарын албан тоотоор тус тус хүргүүлэн ажиллалаа.

#### **Стандартчилал, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:**

Мандал, Баянгол, Сайхан, Баруунбүрэн сумдын 70 аж ахуйн нэгж, иргэний худалдаа үйлчилгээнд холбогдох стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж, 65 нэгжид тохирлын гэрчилгээ олгож, шинээр батлагдсан стандартуудаар 2 үнэлгээний хуудас шинээр боловсруулсан.

Стандартын салбар сангаас 16 аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 5 нэрийн 18 стандартын борлуулалт хийж, 3 иргэний хүсэлтийн дагуу 6 стандартын шүүлт хийж үйлчилгээ үзүүлсэн.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр: Мандал, Баянгол, Орхон, Орхонтуул, Сант, Хушаат, Сайхан, Жавхлант, Баруунбүрэн сумдын нийт 37 шатахуун түгээх газрын 127 ширхэг шингэн хэмжигчийг шалгалт баталгаажуулалтад хамруулсан.

Механикийн хэмжлийн төрлөөр: “СББ” ХХК-ий 2 ширхэг авто жин, мөн дээрх сумдад үйл ажиллагаа явуулж буй худалдаа, үйлчилгээний газруудын 110 электрон жинг ээлжит шалгалт баталгаажуулалтад хамруулсан.

Цахилгааны хэмжлийн төрлөөр: Хүдэр, Ерөө, Сүхбаатар сумдын 64 ширхэг цахилгааны тоолуур баталгаажуулалтад хамруулсан.

*Дулаан даралтын хэмжлийн төрлөөр:* Хилийн мэргэжлийн хяналтын албаны сорьц хяналтын лабораторийн шилэн термометр 1, Сант сумын Эрүүл мэндийн төвийн 5 термометр, 1 цусны даралтын аппаратыг ээлжит баталгаажуулалтад хамруулсан.

Шалгалт тохируулгын төрлөөр: “СББ” ХХК-ий болон мал эмнэлгийн сорилт шинжилгээний лабораторийн 23 шилэн хэмжүүрт, 7 электрон жин, 21 туухай, 2 сүүний хэмжүүр, 50 м3 шатахуун нөөцлөх 1 саванд онооны хүснэгт зохиож, шалгалт тохируулга хийж ажилласан.

### **Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

Өнгөрсөн сард 751 баримтаар 8.556,6 сая төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэж, аймгийн төсвийн гүйцэтгэлийн 10-р сарын нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хүргүүлэн ажиллалаа.

Мөн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн цахим сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулсан.

Аймгийн 10 дугаар сарын орлогыг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, мөн сарын тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт тавьж, 9, 10 дугаар сарын анхан шатны баримтуудыг үдэж хавтаслан архивлаж ажиллалаа.

#### **1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:**

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
<b>1. Орон нутгийн төсвийн нийт орлого</b>		<b>86,951,185.7</b>	<b>81,162,602.9</b>	<b>93.3</b>
1.1	<b>Орон нутгийн төсвийн орлого</b>	<b>24,381,676.0</b>	<b>22,595,617.9</b>	<b>92.7</b>
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	17,287,355.5	13,113,465.5	75.9
	Сумдын төсвийн орлого	7,094,320.5	9,482,152.3	133.7
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	4,908,006.2	4,908,006.2	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	46,624,923.2	44,753,811.0	96.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	5,724,215.9	5,452,190.1	95.2
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	1,728,732.9	1,728,732.9	100.0
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	1,724,244.9	1,724,244.9	100.0
1.7	Сум хөгжүүлэх сан /орлого/	1,859,386.6	639,169.2	34.4
<b>2. Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>		<b>86,951,185.7</b>	<b>68,665,897.8</b>	<b>79.0</b>
2.1	<b>Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>	<b>86,951,185.7</b>	<b>68,665,897.8</b>	<b>79.0</b>
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	17,649,483.0	12,471,334.8	70.7
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	2,762,812.8	1,668,700.1	60.4
	<b>Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын</b>	<b>14,098,232.7</b>	<b>10,243,789.0</b>	<b>72.7</b>



	<b>зарлага</b>			
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	1,854,784.5	947,173.7	51.1
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	3,797,501.2	2,547,549.1	67.1
	Халамжийн сан	162,175.0	108,010.3	66.6
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	<b>7,781,420.6</b>	<b>6,304,041.5</b>	<b>81.0</b>
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	502,351.4	337,014.4	67.1
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	51,513,836.6	43,382,034.5	84.2
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	926,820.6	900,039.4	97.1
	<b>3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг</b>	<b>64,906,951.0</b>	<b>60,423,016.4</b>	<b>93.1</b>
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	12,557,811.9	10,217,015.3	81.4
	<b>Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг</b>	<b>2,129,777.5</b>	<b>1,836,381.9</b>	<b>86.2</b>
3.2	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	117,785.0	117,785.0	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	
	Хөрөнгө оруулалтын зардалд	2,011,992.5	1,718,596.9	85.4
	<b>Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг</b>	<b>3,594,438.4</b>	<b>3,615,808.2</b>	<b>100.6</b>
3.3	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	3,253,281.6	3,376,151.4	103.8
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	319,500.0	218,000.0	68.2
	Усан хангамжийн татаас	21,656.8	21,656.8	100.0
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	45,753,635.7	43,882,523.5	95.9
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	871,287.5	871,287.5	100.0
	<b>Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/</b>	<b>46,624,923.2</b>	<b>44,753,811.0</b>	<b>96.0</b>
	- Ерөнхий боловсролын сургууль	25,756,071.3	24,944,371.8	96.8
	- Хүүхдийн цэцэрлэг	13,636,833.4	12,430,758.6	91.2
	- Эрүүл мэндийн байгууллага	6,231,518.2	6,231,518.2	100.0
	- Газрын кадастрын байгууллага	503,462.3	503,462.3	100.0
	- Хүүхдийн байгууллага	497,038.0	497,038.0	100.0
	<b>4. Тусгай сангуудын зарлага</b>	<b>1,859,386.6</b>	<b>639,169.2</b>	<b>34.4</b>
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	<b>1,859,386.6</b>	<b>639,169.2</b>	<b>34.4</b>

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2019 10- сар	2020 10- сар	2020- 10 2019-10 Х/төгрөгөөр/
<b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>				
<b>1</b>	<b>ТАЛХ, ГУРИЛ, БУДАА</b>			
	Гурил /савласан, кг/	1 200	1 200	100.0
	Талх /орон нутгийн, ш/	1 200	1 300	108.3
	Нарийн боов /кг/	2 500	2 600	104.0
	Будаа /кг/	2 400	2 600	108.3
	Элсэн чихэр /кг/	2 200	2 000	90.9
<b>2</b>	<b>МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН</b>			

	Хонины мах /кг/	7 800	7 000	89.7
	Үхрийн мах /кг/	8 500	8 000	94.1
	Адууны мах /кг/	7000	6 300	90.0
	Ямааны мах /кг/	6 500	6 000	92.3
	Дотор мах, цувдай /цусгүй/	4000	4 000	100.0
	Хиам /чанасан, кг/	10 000	11 000	110.0
<b>3</b>	<b>СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ</b>			
	Сүү /задгай, л/	1 000	900	90.0
	Сүү / савласан, л/	2 700	3200	118.5
	Тараг /задгай, л/	1 300	1 100	84.6
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	15 000	16 000	106.7
	Айраг /л/	3 500	4 000	114.3
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
<b>4</b>	<b>БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС</b>			
	Ургамлын тос /л/	3 800	4 500	118.4
	Өөхөн тос /кг/	2 000	2 500	125.0
	Шар тос /кг/	13 000	15 000	115.4
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
<b>5</b>	<b>ХҮНСНИЙ НОГОО</b>			
	Төмс /кг/	800	1000	125.0
	Лууван /кг/	1100	1 000	90.9
	Манжин /кг/	1500	1 200	80.0
	Байцаа /кг/	1200	1200	100.0
	Сонгино /кг/	1500	2 000	133.3
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	4 500	128.6
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 800	3 000	107.1
<b>7</b>	<b>ШАТАХУУН</b>			
	Бензин А - 80	1 750	1 420	81.1
	Бензин А - 92	1 840	1 470	79.9
	Дизелийн түлш	2 370	2090	88.2

### **Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

Авлигатай тэмцэх газарт Авлигын эсрэг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-т заасан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.2-т заасан төрийн алба хаасан хугацаанд тооцогдох эсэх талаар тодорхой хариуг авахаар аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01/895 дугаартай албан тоотыг Авлигатай тэмцэх газрын 70110251 дугаарт факсаар илгээж ажилласан.

Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаанаас сумын Засаг даргад томилуулахаар нэр дэвшүүлсэн 17 сумдын иргэдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянуулахаар холбогдох баримтыг бүрдүүлэн авч хянан, аймгийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01/896 дугаартай албан тоотоор Авлигатай тэмцэх газарт факсаар болон цахим хаягт тус тус хүргүүлэн ажилласан.

**Цагдаагийн газар:** Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 11 сард 374 холбогдогчтой 1148.1 сая төгрөгийн хохиролтой, 515 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 149 хэргээр буюу 22.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 49.5 хувьтай байгаа нь өмнөх оноос 0.4 хувиар өссөн байна.

**Улсын бүртгэлийн хэлтэс нь:** Улсын бүртгэлийн хэлтсээс 2020 оны 11-р сард эд хөрөнгийн бүртгэл 425, иргэний бүртгэл 308 бүртгэж үйлчиллээ. Аймгийн хэмжээнд коронавируст халдвар гарсантай холбоотойгоор 11 дүгээр сарын 11-ний өдрөөс өндөржүүлсэн бэлэн байдал зарласны улмаас улсын бүртгэлийн хэлтсийн 3-р байр бүрэн хамгаалалтад орж, иргэдэд үзүүлэх үйлчилгээ, олон нийтэд хийгдэх ажлууд хойшлогдсон.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хүрээнд шинэчилэн боловсруулагдаж байгаа багц журмын нэг болох “Төрийн архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ын төсөлд өгөх саналыг боловсруулж ажилласан. Журмын төсөлтэй нэг бүрчлэн танилцаж, тэдгээртэй холбогдуулан 14 зүйлээр санал боловсруулан Архивын ерөнхий газарт цахимаар хүргүүлж ажиллалаа.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулан ирүүлсэн “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-ын төслийг цахимаар хүлээн авч танилцан, түүнд өгөх саналыг боловсруулах ажил хийгдэж байна.

### **Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:**

#### **1. Боловсрол, соёл урлаг, спортын талаар:**

Боловсрол Шинжлэх Ухааны сайдын тушаал, аймгийн Засаг даргын захирамж, Боловсрол Соёл Урлагийн газрын даргын 11-р сарын 11-ний өдөр “Чиглэл хүргүүлэх тухай” 336 тоот албан бичиг, сургууль, цэцэрлэгүүдэд хүргүүлж, хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон.

Боловсрол Шинжлэх Ухааны яаманд боловсролын салбарын нөхцөл байдлын мэдээллийг хүргүүлж эхэлсэн бөгөөд салбарын байгууллагуудын өндөржүүлсэн бэлэн байдлын үеийн ажлын явцыг цахимаар хяналт тавин ажиллаж байна. Сүхбаатар, Алтанбулаг, Мандал сумдын багш, ажилтнууд, 1-ээс дээш насны хүүхэд бүрийг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулж байна.

Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төслөөс 11-р сарын 02, 03-нд Дархан-Уул аймагт зохион байгуулсан “СТЕМ” боловсролын лабораторийн тоног төхөөрөмжтэй ажиллах арга зүйн сургалт”-д физикийн 8, химийн 2, дизайн технологийн 3, мэргэжилтэн 2, нийт 15 багш хамрагдаж ур чадвараа дээшлүүлсэн.

Боловсролын үнэлгээний төвөөс чанарын үнэлгээний шалгалтыг зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэлийг ханган ажиллаж байна.

“Сэлэнгэ аймгийн Боловсрол, Соёл, Урлагийн газар” цахим хуудас болон багш нарын группээр дамжуулан эцэг эх, багш, сурагчдад теле хичээл, ахуйн осол, гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой зөвлөмжийг түгээн ажиллаж байна.

Теле хичээлд хамрагдаж байгаа, хамрагдаж чадахгүй байгаа хүүхдүүдийн судалгааг гаргасан бөгөөд ерөнхий боловсролын сурагчдын 91.9 хувь нь теле хичээлд хамрагдаж, багштайгаа эргэх холбоотой байгаа бол 8.1 хувь нь теле

хичээлд хамрагдаагүй, 43 цэцэрлэгийн хүүхдийн 82.5 хувь нь теле хичээлд хамрагдаж, 17.5 хувь нь теле хичээл хамрагдаагүй байна.

Хоол хүнсний дэмжлэг шаардлагатай өрхийн сурагч, цэцэрлэгийн хүүхдүүдийн судалгааг гаргаж, эрсдэлт бүлгийн, хоол хүнсний дэмжлэг шаардлагатай өрхийн хүүхдүүдэд тусламж үзүүлэх зорилгоор “Foodbank” сайн дурын ажлыг хүнсний дэлгүүрүүдэд зохион байгуулж, цугласан хүнсийг сумын Онцгой комисстой хамтран хүргэх ажлыг зохион байгуулж 12 сургуулийн 110 сурагчид хоол хүнсний тусламж үзүүлэн ажиллалаа.

Хүнсний нөөцийн судалгааг нэгтгэхэд 11-р сарын 17-ны өдрийн байдлаар 43 хүүхдийн цэцэрлэгийн хүнсний нөөцөд 76.471.8 мянган төгрөгийн үнэ бүхий хүнсний бараа бүтээгдэхүүн байгаагаас мах махан бүтээгдэхүүн 3752.7 кг, хүнсний ногоо 6263.9 кг, гурил 3127.4 кг, будаа 2668.2 кг, элсэн чихэр 1051.4 кг, давс 336.8 кг, гоймон 517.0 кг, цай 85.5 кг, сүү 132.0 кг, жимс, жимсгэнэ 735.1 кг, сүү, сүүн бүтээгдэхүүн 1150.2 кг байна. Ерөнхий боловсролын 35 сургууль, 20 дотуур байрны хүнсний нөөцөд 52350.7 мянган төгрөгийн үнэ бүхий хүнсний бараа бүтээгдэхүүн байгаагаас мах, махан бүтээгдэхүүн 3454.8 кг, төмс, хүнсний ногоо 4991.7 кг, гурил 2942.5 кг, будаа 1371.1 кг, элсэн чихэр 387 кг, давс 393.9 кг, гоймон 253.0 кг, цай 236.8 кг, сүү 55.0 кг, жимс, жимсгэнэ 352.1 кг, сүү, сүүн бүтээгдэхүүн 209.2 кг, сүү 37 литрийн нөөцтэй байна.

Аймгийн хэмжээнд “Гэртээ өөрийгөө хөгжүүлэе” цахим уралдааныг зарлаж, уралдаанд 640 сурагчдын оролцож “Сэлэнгэ аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар” хуудсанд байршуулан, ажиллаж байна.

Аймгийн Онцгой байдлын газартай хамтран “Бүсийн аварга” шалгаруулах тэмцээнийг 10-р сарын 30-аас 11-р сарын 01-ний өдрүүдэд 4 төрлөөр зохион байгуулж, 7 багийн 100 гаруй тамирчдыг хамрууллаа.

Улсын онцгой комисс болон Аймгийн онцгой комиссын шийдвэрийн дагуу бусад тэмцээн уралдаан хойшлогдсон.

## **2. Эрүүл мэндийн талаар:**

“Covid-19”-ийн халдварын голомт үүссэнтэй холбогдуулан аймгийн Нэгдсэн эмнэлгийн тасаг нэгжүүдийг 13 цэгт яаралтай нүүлгэн шилжүүлэх ажлыг 24 цагт багтаан гүйцэтгэлээ.

Эмнэлгийн тусламж үйлчилгээг тасалдуулахгүйн тулд аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн үзлэгийг хувийн эмнэлгүүдийн байранд, хүүхэд, дотрын тасгийн үйл ажиллагааг Шаамар суманд тус тус зохион байгуулж, эмнэлгийн тусламж авахад иргэдэд хүндрэлтэй байгааг харгалзан Сүхбаатар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутны дотуур байранд дахин шилжүүлэн ажиллуулж байна.

Аймгийн төв Сүхбаатар суманд халдварын голомтыг хумих мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэхээр Улсын Онцгой комиссын шийдвэрийн дагуу Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяраар ахлуулсан Эрүүл мэндийн яам, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн 2, тусламж үйлчилгээний 1, лабораторийн 1 баг ажиллаж байна.

Зоонозын өвчин судлалын үндэсний төв, аймгийн Нэгдсэн эмнэлгийн хамтарсан баг 24 цагаар “PCR” шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэж байна.

“Covid-19”-ийн халдварыг илрүүлэх зорилгоор явуулын болон суурин 25 цэгт 90 гаруй хүний бүрэлдэхүүнтэй шинжилгээ авч ажиллаж байна.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотрын тасагт “Covid-19”-ийн халдварыг эмчлэх эмчилгээний 45 ортой тасгийг шинээр нээж, тусламж үйлчилгээг үзүүлэхэд бэлэн болгосон.

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн сургалтын зөвлөх баг аймгийн Нэгдсэн эмнэлгийн ковидын тасагт ажиллах 20 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг ажлын байрны сургалтад хамруулж чадавхижууллаа.

Халдварын голомтыг хумих ажлын хүрээнд 10 зочид буудал, 2 цэцэрлэг, 4 дотуур байр, ахмадын сувилал, Аймгийн Нэгдсэн эмнэлгийн халдвартын тасаг нийт 18 ажиглалтын байрыг үүсгэж, 302 хүнийг ажиглалтад авч, 14 эмч эмнэлгийн ажилтан ажиллаж байна.

Алслагдсан багт эмийн сангийн тусламжийг хүргэх зорилгоор 4 эмийн сан баг бүр дээр 10:00-14:00 цагийн хооронд ажиллаж байна.

Нэн шаардлагатай зөвлөгөө өгөх утасны 3 дугаарыг нэмэлтээр ашиглалтад оруулсан. Тухайлбал:

- 95900103- Зөвхөн Covid-19 холбоотой зөвлөгөө өгөх дугаар
- 99072909- Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой зөвлөгөө өгөх
- 99014018- Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх

Сүхбаатар сумын хэмжээнд Ерөнхий боловсролын 2-р сургуульд 24, 3-р сургуульд 57, Спортын ордонд 30, Спорт сургуульд 78 нийт 189 ор шинээр бэлтгэн шаардлагатай нөхцөлд дэлгэн тавихад бэлэн болгосон байна.

11-р сарын 29-ний байдлаар ойрын 1237, дам 862 хавьтал, нийт 2099 хавьтлыг тогтоосон, тандалт судалгааны ажил үргэлжилж байна.

Сүхбаатар сумын хэмжээнд Зоонозын өвчин судлалын төв 22 объектод голомтын халдваргүйжүүлэлтийг 13,891 м.кв талбайд, Мал эмнэлгийн газрын халдваргүйтгэлийн баг хүнсний худалдааны газруудад 300 м.в талбайд, нийт 14191 м.кв талбайд халдваргүйжүүлэлтийг хийж Мэргэжлийн хяналтын газраас хяналт тавин ажиллаж байна.

### **3. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд:**

Тайлант хугацаанд халамжийн санд улсын төсвөөс 37459 иргэнд 14691274,3 мян.төгрөгийг зарцууллаа.

Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний ерөнхий газраас тендерт шалгарч Сэргээн засах үйлчилгээ явуулах эрх авсан “ЭБУС” ХХК, “Бум хараа” ХХК, “Энэрэлт үйлс” ХХК, “Хараа Алтан-Од” ХХК-уудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, Сүхбаатар, Мандал сумдад сэргээн засах үйлчилгээг 271 ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэн хүүхдийг хамрууллаа.

11-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй 371 байсан бол 457 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 127 ажлын байранд 90 хүнийг ажилд зуучилж, идэвхгүйн улмаас 114 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 624 болсон байна.

Өрхийн малжуулах арга хэмжээнд Баруунбүрэн, Сант, Зүүнбүрэн, Хушаат, Хүдэр, Ерөө сумд, Бугант, Хэрх тосгоны 30 өрхийг хамруулж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 141000.0 мянган төгрөгийг зарцуулж, 60 ажлын байрыг шинээр бий болголоо.

Улаанбаатар хотын “Эм Эс Девелопмент консалтинг” ХХК-ий дэргэдэх сургалтын төвтэй хамтран хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээний гэрээ байгуулан Баянгол, Мандал, Сайхан, Зүүнбүрэн, Сант зэрэг сумдын зорилтот бүлгийн 130 иргэнийг хамруулж 5850.0 мянган төгрөгийг зарцуулж, мэргэжлийн чиг баримжаа олгох, нийгэмшүүлэх, анхан шатны мэдлэг олгох сургалтад Сүхбаатар сумын хөгжлийн бэрхшээлтэй 26 иргэнийг хамруулж, 1820.0 мянган төгрөгийг тус тус зарцууллаа.

“Сэлэнгэ Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв”, “Зүүнхараа политехникийн коллеж”-той мэргэжил олгох сургалтын гэрээ байгуулж, Сант, Сайхан сумд, Бугант тосгоны ажилгүй 28 иргэнийг хүлэмж, оёдол эсгүүр, хүнд машин механизмын операторчин мэргэжлийн сургалтад хамруулж, 5632.0 мянган төгрөг, “Зүүнхараа политехникийн коллеж”-той хамтран Мандал сумын 18 иргэнийг оёдол эсгүүрийн сургалтад хамруулж 4212.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

11-р сарын байдлаар 24.8 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 11-р сарын 27-ны байдлаар өссөн дүнгээр 31.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 129.77 хувийн биелэлттэй ажиллаж байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 17743 тэтгэвэр авагчдад 68.239.601 мянган төгрөгийг тэтгэвэрт, тэтгэмжийн даатгалын сангаас 5531 хүнд 3.037.969 мянган төгрөгийг, хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 269 иргэнд 981243 мянган төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 382 иргэнд 888488 мянган төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгож ажиллалаа.

11-р сарын 27-ны байдлаар иргэд даатгуулагчдад нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн архивын лавлагааг 1650 цахим болон цаасан хэлбэрээр гарган түргэн шуурхай үйлчлэн ажиллалаа.

#### **4. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:**

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвөөс 27 дуудлага мэдээллийг хүлээн авч, хамтарсан багт шилжүүлж, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж ажиллалаа. Дуудлагыг агуулгаар нь ангилахад:

- Сэтгэл санааны хүчирхийлэл - 21
- Бие махбодын хүчирхийлэл - 3
- Үл хайхрах - 3

#### **Хүчирхийлэл үйлдэгдсэн орчин:**

- Гэр бүлийн орчинд - 27

#### **Эрсдэлийн түвшин:**

- Өндөр эрсдэлтэй 0, Дунд эрсдэлтэй 113, бага эрсдэлтэй 16 нийт 25 тохиолдлыг хяналтад авч, үүнээс 2 тохиолдлыг шийдвэрлэж ажиллалаа.

Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх

мэргэжлийн ангийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, бэлэн байдлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Эцэг, эх нь хөл хорионд орсон асран хамгаалагчгүй байгаа 14 өрхийн 34 хүүхдийг хөрш айлын болон ах дүү хамаатан саданд нь хүлээлгэн өгч, хоол хүнсний багц, ахуйн хэрэглээний дэмжлэг үзүүлж, сургуулийн захирал, анги удирдсан багш, хамтарсан багт мэдээллийг хүргүүлж, хяналтад авч ажиллах үүрэг чиглэлийг өглөө. “Food bank” явуулын хайрцгийг 3 хүнсний дэлгүүрт байршуулснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнтэй, өрх толгойлсон, олон хүүхэдтэй нийт 15 өрхөд дэмжлэг үзүүллээ.

“Хуримтлуулахад хялбар” аяны хүрээнд аймгийн Эрүүл мэндийн газар, Голомт банктэй хамтран Сүхбаатар сумын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны хүүхдүүдэд “Эрүүл зөв хооллолт”, “Өөртөө итгэх итгэл”, “Хэрхэн хуримтлалтай болох вэ?” сэдэвт сургалтуудыг зохион байгуулж, сэтгэл зүйн зөвлөгөө авах хүсэлтэй хүүхдүүдэд ганцаарчилсан зөвлөгөө өгч ажиллалаа.

Нийт 3 байгууллагын албан хаагчдад 4 сэдвээр сургалт, 6 сургуулийн нийт 28 сурагчдад сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөөг өгсөн.

Хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийг цахим хэлбэрт шилжүүлж, хүүхдүүдийн дунд шинэ дуу сурах, шатрын тэмцээн зохион байгууллаа.

#### **Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:**

##### **1. Мал эмнэлгийн үйлчилгээний талаар:**

Улсын Онцгой комисс, аймгийн Онцгой комисс болон Мал Эмнэлгийн Ерөнхий газраас цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шийдвэр, төлөвлөгөө, чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж, хугацаатай өгсөн үүрэг даалгавар, өдөр тутмын мэдээ мэдээллийг шуурхай дамжуулан ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу түргэвчилсэн оношлуурын шинжилгээнд газрын бүх ажилтан, албан хаагчид бүрэн хамрагдаж, сэжиг илэрсэн хүнгүй бүгд сөрөг үзүүлэлттэй гарсан байна.

Аймгийн онцгой комиссын шийдвэрээр Мэргэжлийн хяналтын газар, Зоонозыг өвчин судлалын төвтэй хамтран 6 хүний бүрэлдэхүүнтэй бүлэг ариутгалын тусгай тоноглогдсон ДУК 2 авто машинтайгаар Сүхбаатар сумын хүнсний худалдаа, үйлчилгээний төв, аж ахуйн нэгж, байгууллага, нийтийн эзэмшлийн талбайг Мал эмнэлгийн газар 237197.89 м<sup>2</sup>, сумдын Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн 60 малын эмч мэргэжилтнүүд 286722.8 м,кв, нийт 523920.69 м.кв талбайд хлорын шохой, HiCOP, Ваймекон, супер килл зэрэг ариутгал халдваргүйтгэлийн бодисоор халдваргүйтгэлийг хийн ажиллалаа.

Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын А/182 тоот тушаалаар батлагдсан “Бруцеллёзын дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” тушаалын дагуу үхэр, хонь, ямааны охин төлийг хамруулахаар батлагдсаны дагуу тугал 51440 толгой хамрагдахаас 51440 буюу 100 хувь, богийн төл 370300 толгой хамрагдахаас 370300 буюу 100 хувь нийт 421740 толгой төл мал буюу 100 хувь хамруулсан.

Орон нутагт эргүү, бэтэг болон бусад зооноз өвчнөөс сэргийлэх зорилгоор гэрийн тэжээвэр нохойн туулгалтыг технологийн дагуу давхардсан тоогоор энэ сард 1620 нохойг туулгалтанд хамруулж, баасыг халдваргүйжүүлэн шатааж булж устгах ажлыг зохион байгуулсан.

МЭЕГ, МЭАЦТЛ-ын баталсан удирдамжийн дагуу бруцеллэз өвчний халдварыг илрүүлэх тандалт шинжилгээнд Цагааннуур, Сант сумдын 80 өрхийн хонь 200, ямаа 200, үхэр 400 нийт 800 дээжийг цуглуулж ийлдсийг ялган хүргүүлэв.

Аймгийн бруцеллэзын вакцинжуулалтын дараах тандалт судалгааны дээжийг 17 сумын 45 малчин өрхийн 840 сорьц дээжийг санамсаргүй түүврийн аргаар цуглуулж, цус авснаас 24 цагийн дотор ийлдсийг ялган авч, “эерэг” гарсан дээжүүдийг баталгаажуулахаар УМЭАЦТЛ-т хүргүүлэн шинжлүүлсэн.

МЭЕГ-ын тушаалын дагуу боловсруулсан удирдамжийн дагуу Алтанбулаг, Зүүнбүрэн, Шаамар, Түшиг, Цагааннуур, Хүдэр, Сүхбаатар сумдаас үхрийн цээж өвчний шинжилгээнд 24 дээж, годрон өвчний шинжилгээнд 40 дээж, УМЭАЦТЛ-иос ирсэн удирдамжийн дагуу Гахайн сонгомол мялзан, Томуу, Гахайн үржил, амьсгалын замын хам шинж, Гахайн африк мялзан, Бруцеллэз, Уушигний микоплазм, Парвовирус, Ходоод, гэдэсний хам үрэвсэл, Шүлхий, Цирковирус, Коронавирус зэрэг өвчнүүдийг илрүүлэх тандалт шинжилгээнд Мандал, Алтанбулаг сумын гахайн сүргээс нийт 40 дээж цуглуулж УМЭАЦТЛ-т тус тус хүргүүлээд байна.

Мал эмнэлгийн ерөнхий газраас баримталж буй бодлого, шийдвэрийн хэрэгжилтэд 17 сумын Мал эмнэлгийн тасгийн дарга, улсын байцаагч нар хяналт тавьж, давхардсан тоогоор 4452 малчин, мал бүхий иргэдэд малын эмийн зохистой хэрэглээ, эмийн бодисийн хор уршиг, гэрээт малын эмчээр үйлчилгээ үзүүлэх, гарах үр дүнгийн талаар ухуулга таниулах яриа хийж, заавар зөвлөмжийг өгснөөр малчид, иргэдийн гар дээр замбараагүй хэрэглэгддэг явдал буурч, малын эмийн зохистой хэрэглээг хэвшүүлээд байна.

Мал, амьтны гаралтай бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгож 11 сард 539 иргэний адуу 257, үхэр 725, хонь 2102, ямаа 1525, гахай 14 бүгд 4623 толгой мал амьтан, 24020 кг мах, махан бүтээгдэхүүн, 160 кг сүү, сүүн бүтээгдэхүүн, 8 ширхэг арьс шир бүгд 24188 кг/ш бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ олгож баталгаажуулж ажиллалаа.

## **2. Хөдөө аж ахуйн талаар:**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоолоор улсын хэмжээнд коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээг эрчимжүүлэх, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуйн газраас дараах ажил арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа.

Улсын онцгой комиссын даргын 2020 оны “Хүнсний хангамжийн удирдлагын шуурхай штаб байгуулах тухай” 21 дүгээр тушаалын дагуу аймгийн Засаг даргын 2020 оны “Хүнсний хангамж, нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах тухай” А/309 тоот захирамжийг батлуулан сумдад хүргүүлэн хэрэгжилтийг зохион байгуулж, аймаг орон нутгийн иргэдийг хүнсний бүтээгдэхүүнээр хангах, нөөц бүрдүүлэлт, дэлгүүрүүдийн борлуулалтын мэдээг өдөр дутам авч, мэдээллийг өглөө 08:00-09:00, орой 18:00-19:00 цагийн хооронд аймгийн Онцгой комисст өгч байна.

Мөн тус захирамжийн хүрээнд “Идэш” арга хэмжээг зохион байгуулж, хөдөө орон нутгаас идэш бэлтгэх иргэд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын 70363500 дугаарт холбогдож өөрийн оршин суугаа хаяг, утасны дугаар, идэш



авах сум, малчин өрхийн хаяг, утасны дугаарыг бүртгүүлэн аймгийн Онцгой байдлын газраас зөвшөөрлийн хуудас авч, “Сэлэнгэ хөгжил тохижилт” ОНӨААТҮГ-ын мал нядалгааны цэгт авчирч малаа төхөөрүүлж байна. Энэ арга хэмжээний хүрээнд 41 үхэр, 6 адуу, 89 хонь, 37 ямааг нядалгаанд оруулж 10.4 тонн мах хүнсэнд бэлтгэсэн, Хүнс, хөдөө аж ахуйн газрын 70363500 дугаарт 79 иргэний захиалгыг авч, 70 иргэний зөвшөөрөл авах хүсэлтийг аймгийн Онцгой байдлын газарт хүргүүлж ажиллаж байна.

17 сумын хэмжээнд мах борлуулж буй 53 дэлгүүр, мухлаг, 26 иргэн нийт 16572 кг буюу 16.5 тонн мах борлуулсан ба үүнээс үхрийн мах 8043 кг, хонины мах 4158 кг, ямааны мах 846 кг, адууны мах 3495 кг, гахайн мах 2 кг, тахианы мах 8 кг тус тус борлуулсан байна. Сүхбаатар сумын хэмжээнд махны 15 дэлгүүр үйл ажиллагаа явуулж байгаагаас тус өдрүүдэд 5 дэлгүүр ажиллаж 1556 кг махны борлуулалт хийсэн байна. Борлуулсан махыг төрлөөр нь авч үзвэл үхрийн мах 728 кг, хонины мах 126 кг, адууны мах 600 кг, ямааны мах 100 кг, гахайн мах 2 кг байна.

Аймгийн хэмжээнд мах 21.3 тонн, гурил 1665.0 тонн, гурилан бүтээгдэхүүн 14.1 тонн, төрөл бүрийн будаа 79.2 тонн, хуурай сүү 5.1 тонн, өндөг 1.6 тонн, ургамлын тос 24.1 тонн, төмс 8320 тонн, хүнсний ногоо 5090 тонн, элсэн чихэр 37.0 тонн, давс 14.8 тонн, савласан цэвэр ус 22.7 тонн тус тус байна.

Дээрх мэдээллээс үзэхэд аймгийн хэмжээнд мах 2, гурил 192.0, гурилан бүтээгдэхүүн 1, төрөл бүрийн будаа 18, хуурай сүү 3, өндөг 1, ургамлын тос 12, төмс 799, хүнсний ногоо 226, элсэн чихэр 13, давс 34, савласан цэвэр ус 1 хоногийн нөөцтэй байна.

Сүхбаатар сум мах 1, гурил 776, гурилан бүтээгдэхүүн 3, төрөл бүрийн будаа 33, хуурай сүү 3, өндөг 1, ургамлын тос 4, төмс 54, хүнсний ногоо 13, элсэн чихэр 3, давс 26, савласан цэвэр ус 1 хоногийн нөөцтэй байна.

Монгол улсын Засгийн газрын 2020 оны “Хөдөө аж ахуйн салбарын 2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангах зарим арга хэмжээний тухай” 19 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын “2020-2021 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай” 02 тоот албан даалгавар, Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2020 оны 418, 428 тоот албан бичгээр цаг үеийн ажлыг эрчимжүүлэх тухай чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг хангах зорилгоор ажлын төлөвлөгөө гаргаж, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хүлээн авах, үр дүнг тооцох сумын ажлын хэсгийг байгуулж, хадлан тэжээл бэлтгэх ажлыг зохион байгуулах, бэлчээр ашиглалтыг сайжруулах үүрэг чиглэлийг сумдад өгч хэрэгжилтийг хангуулан ажиллаж, мал өвөлжилтийн бэлтгэлийн мэдээг 93.1 хувьтайгаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

Хадлан бэлтгэх ажилд аймгийн хэмжээгээр механикжсан салаа 45, хадлангийн бага оврын тракторын иж бүрдэл 450, ажиллах хүч 3200 ажиллаж, 191.5 мян.тн байгалийн хадлан, 40.8 мян.тн хүчит тэжээл, 10.2 мян.тн эрдэс тэжээл бэлтгэхээс 167.3 мян.тн өвс, 7.2 мян.тн сүрэл, 22.7 мян.тн ногоон тэжээл, 17.9 мян.тн үйлдвэрийн тэжээл, 28.6 мян.тн дарш, 788 тн гар тэжээл, 8.9 мян.тн эрдэс тэжээл бэлтгэсэн нь малчин, мал бүхий иргэдийн түвшинд бэлтгэх өвс, тэжээлийг 86.1 хувьтай мал өвөлжилтийн бэлтгэсэн байна.

Аймгийн хэмжээнд Орхон үүлдрийн 500, субфолк үүлдрийн 200 толгой нийт 700 толгой хонинд гүн хөлдөөсөн болон шингэлсэн үрээр зохиомол хээлтүүлэг хийж ажиллалаа.

### **3. Байгаль орчны талаар:**

Аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын албан хаагчидтай хамтран Сүхбаатар сумын 1, 5-р багт короновирусын тархалтыг зогсоох, иргэдийн хөл хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор 11-р сарын 18-ны өдрөөс эхлэн тус газрын 4 албан хаагч эргүүлд гарч ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын шийдвэрийн дагуу Сүхбаатар, Зүүнбүрэн, Шаамар, Орхон, Орхонтуул, Сайхан сумдын иргэдийн түлшний асуудлыг шийдвэрлэхээр сумын болон сум дундын Ойн анги, байгаль хамгаалагчидтай холбоо барьж иргэдийн түлшний модыг мэргэжлийн байгууллагаар бэлтгүүлэх, тээвэрлэх ажлыг зохион байгуулж байна.

Аймгийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад “Эх дэлхийгээ хайрлах, уламжлалт ёс заншлаа дээдлэх мэдлэг олгох, байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлэх” зорилгоор зохион байгуулсан “Ногоон паспорт-Ногоон дэлхий” сэдэвт зохион бичлэг, эссэ бичлэг, гар зургийн уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг шалгаруулж Сүхбаатар, Мандал, Зүүнбүрэн, Шаамар, Цагааннуур сумдын ЕБС-ийн 25 сурагчдад өргөмжлөл, дурсгалын зүйл, мөнгөн шагнал гардуулсан.

Орхон голын загасны судалгааг “Аргал судлалын төв” ТББ-аар гүйцэтгүүлэн ажиллаж байна.

“Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах зарим асуудал” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж, сумын болон сум дундын Ойн ангийн албан хаагчдыг хамрууллаа.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газартай хамтран “Хуш модны самар түүж, бэлтгэж буй өнөөгийн байдал, цаашид анхаарах асуудлууд” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлэгт Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ойн албаны дарга, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагчид, Мандал Хүдэр, Ерөө сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч нар оролцож Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2015 оны А/125, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А/166 тоот тушаалуудыг хэрэгжүүлэхэд гарч буй асуудлын талаар хэлэлцэн, цаашид хамтран ажиллах, дараагийн хэлэлцүүлэгт Цагдаагийн газрын Экологийн албыг хамруулахаар боллоо.

### **4. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар:**

Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2020 оны А/40 тоот тушаалаар “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем ажиллуулах журам” батлагдан хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан 2020 оноос сумдын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг уг системд оруулж баталсны үндсэн дээр иргэн хуулийн этгээдэд газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах ажлыг 2020 оноос эхлэн зохион байгуулсан.

Газар зохион байгуулалт хот төлөвлөлтийн цахим систем болон газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээний сургалтыг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газраас Дархан-Уул аймагт 2 өдрийн 28, 29-ны

өдөр зохион байгуулж тус сургалтад Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын 2 мэргэжилтэн 17 сумын 20 газрын даамал хамрагдсан.

Газрын даргын 2020 оны А/30 тоот тушаалаар “Салбарын хууль тогтоомжийг таниулан сурталчлах” зорилгоор Шаамар сумын газрын даамлын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээг хийх ажлыг зохион байгуулав.

Барилга, хот байгуулалтын Сайдын 2020 оны 38 дугаар тушаалаар батлагдсан “Хот байгуулалтын мэдээллийн сангийн журам”-ын хэрэгжилтийг хангуулах, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2019 оны А/96 тоот тушаалаар “Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан”-ийн өгөгдөл бүрдүүлэх инженерийн дэд бүтцийн цахилгаан хангамж, дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуурга, хот тохижилт, ногоон байгууламжийн авто зогсоол, усан оргилуур, явган болон дугуйн зам, хөшөө дурсгал, гудамж талбайн гэрэлтүүлгийн мэдээлэл бүртгэх маягт батлагдсан ба эдгээр маягтаар хөгжүүлсэн байрлалд суурилсан цахим мэдээллийн системд 364 барилгын мэдээлэл бүртгэгдсэн байна.

“Барилгын ажлын зөвшөөрлийг цахимаар олгох, ус хангамж, ариутгах татуурга, дулаан хангамжийн шугам сүлжээ, ногоон байгууламжийн өгөгдлийг мэдээллийн санд бүртгэх, иргэн хуулийн этгээд, олон нийтэд мэдээллийн санг сурталчлах, нэвтрүүлэхэд тулгарч байгаа асуудал, шийдвэрлэх арга замыг хэлэлцэх” сургалт зохион байгуулагдлаа.

Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг нийт барилгын их засвар болон угсралтын 4 ажилд олгосон.

- Хэрх Түнхэл тосгонд хатуу хучилттай зам тавих /Мандал сум/
- Зам засвар, Тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг /Алтанбулаг сум/
- Хүүхдийн тоглоомын талбай хийх ажил /Түшиг сум/
- Ундны усны худаг гаргах ажил /Шаамар сум/

#### **5. Орон нутгийн өмчийн талаар:**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын холбогдох мэргэжилтнүүдтэй хамтарч төрийн өмчийг ашиглах, өмч эзэмшлийн гэрээг дүгнэх ажлыг аймгийн төрийн өмчит 34 хуулийн этгээдийг хамруулан дүгнэлт гаргаж эдгээр байгууллагуудад бүртгэлтэй тээврийн хэрэгслийг үзэж баталгаажуулсан.

Улаанбаатар хотын "Худалдан авах ажиллагааны хөтөч" ТББ, Худалдан авах ажиллагааны газартай хамтран төрийн захиргаа, төрийн үйлчилгээний алба хаагч, иргэдийн төлөөллийг оролцуулсан 120 хүний сургалтыг 4 хоногийн хугацаанд зохион байгуулж сургалтад оролцогчдын 60 хувь нь шалгалтад тэнцэж сертификат олгосон.

#### **Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:**

##### **Алтанбулаг сум:**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид энэ сард цахимаар 1 удаа хуралдаж 1 асуудал хэлэлцэн “Түлээний модны хуваарь батлах тухай” тогтоолоор Алтанбулаг сумын иргэдийн хэрэгцээнд зориулан ойгоос цэвэрлэгээний огтлолтоор бэлтгэх 300 м3 нарсан түлээний модыг тогтоосон хэмжээнд баталлаа.

Аймгийн Засаг даргын А/304 тоот захирамж, сумын Засаг даргын А/136

дугаар захирамжийн дагуу “Маскаа зүүе, гараа угаая” 2 дугаар аяныг 10-р сарын 30-ны өдрөөс 12-р сарыг дуустал сумын хэмжээнд өрнүүлж, аяны хүрээнд сумын онцгой комисс төр, төсвийн байгууллагыг хамруулан сургалт сурталчилгааны баг томилж өдөр бүр иргэдэд цахимаар заавар зөвлөмж өгч ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын А/306 дугаар захирамж, Сумын Засаг даргын А/146 дугаар захирамжаар “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт” шилжиж 13 үндсэн чиглэл, 24 заалттай төлөвлөгөө батлан ажиллаж байна. 2020 оны 11-р сарын 11-ний өдрөөс 12 дугаар сарын 01-нийг хүртэл авто замын хяналтын цэгт, сумын төвийн иргэдийн хөдөлгөөний хязгаарлах хариуцлагатай жижүүр, сумын шуурхай штаб зэрэг эргүүл жижүүрт төр төсвийн байгууллагын ажилтан, албан хаагчид 77 /давхардсан тоогоор/ 24 цагаар ажиллаж байна. Сумын хэмжээнд ажиллаж буй 20 хүнсний дэлгүүрийг 12-р сарын 01-ний өдрийг хүртэл цагийн хуваарьт хязгаарлалт хийж өглөө 10:00-19:00 цаг хүртэл ажиллуулж, үнийн хөөрөгдөл, бүтээгдэхүүний хомсдол үүсэхэд хяналт тавин ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178 дугаар “Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт” шилжүүлэх тогтоол, аймгийн онцгой комиссын 2020 оны 184 тоот “Үүрэг хүргүүлэх тухай” албан даалгаврын дагуу иргэдийн түлээний модыг бэлтгүүлэх ажлыг мод бэлтгэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Мишээл ариун” ХХК, “Ногоон нарс” ХХК, “Хярааны хонхор” ХХК зэрэг байгууллагуудаар бэлтгүүлж байна. Давхардсан тоогоор 108 галын түлээний гоожин олгогдсон.

Тус суманд 11 дүгээр сарын 17,18,19-ний өдрүүдэд аймгаас ажлын хэсэг ирж түргэвчилсэн оношлуураар 5 хэсэгт 24 эмч, ажилтан, албан хаагчид ажиллаж, 1703 иргэнийг шинжилгээнд хамруулсан. Сумын 1 өрхийн 1 иргэнээс коронавирусийн түргэвчилсэн оношлуураар 11-р сарын 21-ний өдөр шинжилгээ авч эерэг гарсан учир PCR шинжилгээнд тухайн өрхийн 5 иргэнийг хамруулж, PCR шинжилгээний хариугаар 2 иргэн эерэг гарч Сэлэнгэ аймгийн нэгдсэн эмнэлэгт шилжүүлэн, 3 иргэнийг нь гэрт нь тусгаарлаж ажиллалаа. Ойрын болон дам 30 хавьтагчийг гэрт нь болон сумын “Чандмань”, “Дельфин” зочид буудлуудад хувиарлан тусгаарлан ажиллаж байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор төр, төсвийн 7 байгууллага, худалдаа үйлчилгээний 12 хүнсний дэлгүүрийн нийт 7692.8 м2 талбайд өдөр бүр ариутгал халдваргүйтгэлийг хийн ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 дугаар тогтоолоор коронавирусийн халдварын тархалт дотоодод үүссэнтэй холбогдуулан хорио цээрийн дэглэмийг өндөржүүлэн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн тул 11-р сарын 11-ний өдрөөс эхлэн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр гарсан. Сургуулийн 815 сурагч цэцэрлэгийн өмнөх насны нийт 310 хүүхэд теле хичээлд хамрагдаж байна.

#### **Баруунбүрэн сум:**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаан 11-р сарын 05-ны өдөр хуралдаж Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчөөр сонгогдсон 21 төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрлөө. Хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн 52.3 хувийн саналаар Цэвэгжав овогтой Нямдоржийг сумын Иргэдийн

Төлөөлөгчдийн хурлын даргаар сонгож, 100 хувийн саналаар Цэнд овогтой Сэлэнгээг сумын Засаг даргад нэр дэвшүүлэхээр шийдвэрлэлээ.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь 11-р сард 1 удаа, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлыг 1 удаа хуралдуулж, Төлөөлөгчдийн хурлаас нийт 6 тогтоол, ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас 1 тогтоол гарсан байна.

Сумын Засаг даргын захирамж 13, ЗДТГ-ын даргын тушаал 6 гарч эдгээр захирамж, тушаал тус бүр дээр захиргааны хувийн хэргийн акт нээж ажиллалаа. Сумын Засаг даргад иргэдээс ирүүлсэн 5 өргөдлийг хүлээн авч бүртгэн хугацаанд нь холбогдох мэргэжилтнүүдэд өгч ажиллалаа. 11-р сард албан бичгийн программаар 77 хугацаатай бичиг ирж, 61 хугацаатай бичгийн хариуг хүргүүлж, 7 бичиг хяналтад хугацаа хэтэрсэн 1 албан бичиг байна.

Төрийн санд 11-р сарын байдлаар орон нутгийн төсвийн орлого төлөвлөгөөгөөр 82048.6 мян.төгрөг орохоос гүйцэтгэлээр 415080.4 мян.төгрөг орж биелэлт 506 хувь, төсөвт байгууллагын өөрийн орлого төлөвлөгөөгөөр 32694.9 мян.төгрөг орохоос гүйцэтгэлээр 30340.1 мян.төгрөг орж биелэлт 92.8 хувь, аймгаас авах санхүүгийн дэмжлэг төлөвлөгөөгөөр 663075.5 мян.төгрөг ирэхээс гүйцэтгэлээр 430379.6 мян.төгрөг ирж биелэлт 64.9 хувьтай байна. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт төлөвлөгөөгөөр 1288432.5 мян.төгрөг ирэхээс 1442052.8 мян.төгрөг ирж 100 хувь санхүүжигдсэн. ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилт төлөвлөгөөгөөр 163806.5 мян.төгрөг авахаас гүйцэтгэлээр 107135.4 мян.төгрөгийг олгоод байна. ТЗШ-ийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл 1271049.4 мян.төгрөг орон нутгийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл 553083.1 мян.төгрөг буюу нийт төсвийн гүйцэтгэл 1824132.5 мян.төгрөг байна. Зээлийн хүүгийн авлага 7580.4 мян.төгрөг нийт 152740.5 мян.төгрөгийн авлагатай байна. Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт төлөвлөгөөгөөр 165601.7 мян.төгрөг авахаас гүйцэтгэлээр 131673.2 мян.төгрөгөөр санхүүжиж, гүйцэтгэл нь 83.6 сая.төгрөг байна.

Монгол Улсын Засгийн газар, Улсын Онцгой комиссоос 2020 оны 11 сарын 11-ний өдрөөс хатуу хөл хорио тогтоосонтой холбогдуулан сумын Онцгой комиссыг 11-р сарын 12-ны өдрийн өглөөний 04:10 цагт яаралтай хуралдуулж тусгаарлах байрны бэлтгэл бэлэн байдлыг хангах, эм эмнэлгийн хэрэгслийн нөөцийг нэмэгдүүлэх, сумын хэмжээнд бүх нийтийн хөл хориог тогтоох, сумын хүнсний нөөцийг тогтоох зэрэг асуудлыг хэлэлцэж, сумын Онцгой комиссын дарга үүрэг чиглэл өгч ажилласан. 11-р сард сумын онцгой комисс 5 удаа хуралдаж, сумын хэмжээнд хатуу хөл хорио тогтоон ажиллаж байна.

Сумын Засаг даргын 11-р сарын 12-ны өдрийн “Зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, бүх шатны боловсролын байгууллагын хичээл, сургалтын болон зарим төрийн үйл ажиллагааг түр зогсоож, цагийн хязгаарлалт тогтоох тухай” А/156 дугаар захирамжаар хүнсний дэлгүүрийн цагийн хуваарийг богиносгож 09:00- 20:00 цаг, архи, согтууруулах ундаа худалдан борлуулах цагийг 10:00-15:00 цаг болгож, коронавируст халдварын цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх заавар, зөвлөмжийг дагаж мөрдөх, хүнсний дэлгүүрээр үйлчлүүлж буй иргэдийн гар угаах, ариутгах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг аж ахуйн нэгжийн дарга, эздэд үүрэг болголоо. Захирамжийг 11 хүнсний дэлгүүр, үйлчилгээний байгууллагуудад танилцуулж, үүрэг чиглэл өгөн,

дэлгүүрээр үйлчлүүлж буй иргэдэд байнга маскаа зүүж үйлчлүүлэх зөвлөмж, санамжийг өгч дэлгүүрийн худалдагч нарыг байнгын ариутгал халдваргүйтгэлийг хийх, маск болон нөмрөг, малгай, бээлийг байнга хэрэглэхийг сануулан ажиллаж байна.

Мөн сумын Засаг даргын 2020 оны “Шуурхай штаб байгуулж, ажлын тусгай горимд шилжүүлэх тухай” А/157, “Хяналтын цэгт ажиллах жижүүрийн хуваарь батлах тухай” А/158 дугаар захирамжуудын дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сумыг онцгой комиссын Шуурхай штабаас өгсөн үүрэг чиглэлийн дагуу ЕБС, цэцэрлэг, соёлын төвийн 0-12 насны хүүхэдгүй багш, ажилтан, албан хаагчид хоёр цагаар ээлжлэн сумын төвөөр эргүүл хяналт шалгалтыг хийж, хүмүүс олноор бөөгнөрсөн, маскгүй иргэдэд шаардлага тавьж, тусгай тоноглогдсон автомашинаар зарлан мэдээллийн дуут дохиоллын цагаан хоолойгоор жижүүрүүд иргэдийг гэрээсээ гарахгүй байх, амны хаалтаа зүүж хэвших, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн тухай зарлаж мөн соёлын төвийн гадаа талбайд өсгөгчөөр зарлаж иргэдэд сурталчлан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/141 тоот захирамжийн дагуу сумын хэмжээнд архи, согтууруулах ундааг худалдан борлуулахыг хориглон хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Сумын хэмжээнд УРИАЛГА гарган бие биедээ шаардлага, хяналт тавих, хувь хүний ухамсар, соёлыг дэлгэрүүлэх, амны хаалтыг зүүж хэвших, гэртээ байх дэглэмийг бүх түвшинд чандлан сахихыг уриалж сумын албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ хуудас /baruunburen zdtg/-аар тогтмол мэдээлэл тавьж, зурагт хуудас бэлтгэн, иргэдийн ихээр үйлчлүүлдэг төр төсвийн байгууллага, банк, дэлгүүрүүдээр тараан зурагт хуудсыг зарлалын самбарт байршуулан ажиллаж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн зүгээс тамхи татдаг суралцагчдыг илрүүлэх тандалт судалгааг хийж, “Тамхины хор уршиг түүний үр дагавар” сэдэвт сургалтыг 6-12-р ангийн сурагчдад зохион байгуулсан.

“Гар, шүд угаах” аяны хүрээнд гар угаах дараалал, зөвлөмжийг 15 ангийн эрүүл мэндийн булан, ариун цэврийн өрөөнүүдэд байрлуулсан.

Монгол Улсын Засгийн газраас “Бүх нийтийн бэлэн байдал” зарласантай холбогдуулан ЕБС-ийн дотуур байранд байрлан суралцдаг 87 хүүхдийн халууныг үзэж эцэг, эх, асран хамгаалагчдад нь хүлээлгэн өгч ажиллалаа.

Сургуулийн нийт сурагч 519 хүүхдээс 435 хүүхэд теле хичээл үзэж, 79 хүүхэд теле хичээл үзэх боломжгүй байна. Анги удирдсан багш нар сурагч, эцэг эхчүүдтэй эргэх холбоотой ажиллаж байна.

ЕБС-ийн багш, ажилчид хандиваар сумын хүнсний талонд хамрагдаагүй 3 багийн 4 өрхийн 13 хүүхдэд 244.000 мян.төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн, ахуйн хэрэглэл, 39000 мян.төгрөгийн хичээлийн хэрэгслийг хандивлалаа.

Хараа хяналт сул, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхдийн судалгааг гарган эргүүл хяналтыг зохион байгуулж ажиллаж байна.

Цар тахалтай холбогдуулан багш ажилчдыг ажлын байран дээр бөөгнөрөл үүсгэж ажиллуулахгүйгээр гэрээсээ цахим хэлбэрээр ажил үүргээ гүйцэтгэх чиглэл өгч ажиллаж байна. Үүний дагуу жижүүрүүдийг 24 цагаар ажиллуулж байна. Мөн багш нараас бүлгийн хүүхдүүдийн хоол хүнсний дэмжлэг авах

шаардлагатай болон амь нас, эрүүл мэнд, аюулгүй орчин гэх эрсдэлийн судалгаа, эцэг эх нь орон нутагт хөл хорионд орсон, теле хичээлээ үзэж байгаа, үзэж чадахгүй байгаа хүүхэд гэх мэт нарийвчилсан судалгаануудыг авч холбогдох газруудад мэдээлэл өгч ажиллаж байна.

Теле хичээлээ үзэж чадахгүй байгаа шалтгаан нь нэг айлын хүүхдүүдийн хичээл давхцах 1 телевизортой хүртээмж муу, телевизоргүй хөдөө алслагдсан үзэх боломжгүй гэх шалтгаанууд гарч байна.

2020 оны 11 сарын 20-ны байдлаар 156 хүүхдээс 121 хүүхэд теле хичээлээ үзэж, 35 хүүхэд нь үзэж чадахгүй байна.

“Дэлхийн алхалтын өдөр”-ийг сумын иргэд, албан байгууллагуудын албан хаагчдыг хамруулан зохион байгуулж, 50 гаруй төр, төсвийн байгууллагын ажилтан, албан хаагчид болон иргэд хамрагдлаа. Сумын төв талбайгаас Бургалтайн голын гүүр хүртэл нийт 5 км газар алхаж нийт алхагч нарыг 6 баг болгон хувааж 5 өртөө бүхий буухиа тэмцээн зохион байгуулсан.

Монгол Улсын биеийн тамир, спортын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “СЭЛЭНГЭ-2020” өртөө марафоны тэмцээн Сэлэнгэ аймгийн Буур хээрийн талд зохион байгуулагдаж, залуучуудын ангилалд Х.Нямхүү ахлагчтай Баруунбүрэн сумын баг тамирчид оролцож гутгаар байранд шалгарлаа.

Сумын эмэгтэйчүүдийн төлөөлөлтэй хамтран сумын нийт 18 наснаас дээш эмэгтэйчүүдийн дунд “Волейбол”-ын тэмцээн зохион байгуулж, тэмцээнд 7 багийн 56 эмэгтэй оролцлоо.

11-р сарын 06-ны өдөр Дулаанхан тосгонд зохион байгуулагдсан Сэлэнгэ аймгийн “Бий биелээчдийн анхдугаар чуулга уулзалт”-нд тус сумын Биет бус өв тээгч морин хуурч Ү.Цогбадрах, Бий биелээч Ц.Цолмон, Соёлын төвийн Эрхлэгч З.Задгай, ажилтан С.Бүрэнчимэг, бүжгийн багш Ш.Оюунцэцэг, номын санч Ц.Энхбаяр нар оролцлоо.

Сумын Эрүүл мэндийн төв нь 11 дүгээр сард дараах үзлэг, эмчилгээ, оношилгоо, эргэлтийг хийж ажиллалаа. Амбулаторийн үзлэг 142, урьдчилан сэргийлэх үзлэг 76, осол гэмтлийн өвчлөл 3, эмнэлэгт хэвтсэн 13, жирэмсний хяналтад байгаа 26, пап шинжилгээнд хамрагдсан эмэгтэйчүүд 1, түргэн тусламжийн дуудлага 92, үүнээс алсын дуудлага 16, ойрын дуудлага 76, осол гэмтлийн дуудлага 3 ирсэн. Дархлаажуулалтад 46 хүүхэд, нярай хүүхдийн тоо 46, эх барих эмэгтэйчүүдийн эмч долоо хоног бүр төрсөн 12 эх, нярайг сувилан ажиллаж байна.

Сумын 1 дүгээр багийн “Амарбаясгалант хийд”-ийн лам, өндөр настнуудад урьдчилан сэргийлэх үзлэг хийж, “Гараа угаах, маскаа зүүх” сэдэвт сургалтыг хийж гарын авлага, зөвлөмж тараан ажилласан. Мөн Цагаан-овооны 3-р багийн ахмадуудад “Томуу, томуу төст өвчний шинж тэмдэг, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, гар угаах, халдваргүйтгэл” сэдвээр сургалт зохион байгуулж, “Хөдөлгөөн эрүүл мэнд” хөдөлгөөнт дасгалыг зааж өглөө.

Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх аяны хүрээнд “Томуу, томуу төст өвчний шинж тэмдэг, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, гар угаах, халдваргүйтгэл” сэдвээр ЕБС-ийн дотуур байрны 80 хүүхдэд болон сургуулийн нийт сурагчдын дунд сургалт зохион байгуулж, урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан ажиллалаа.

*Коронавирусын халдварын болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд:* Коронавирусын үед ажиллах эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудыг баг болгон томилсон. КОВИД-19 халдварын тохиолдол хүн амын дунд бүртгэгдсэнтэй холбоотой улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдал зарласны дагуу өдөр бүр эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч нар өглөөний 10:00-21:00 цаг хүртэл хяналтын цэгт /пост/ ээлжлэн ажиллаж, хамгаалах хувцас өмсөх, тайлах дарааллын дагуу дотоодын сургалтыг тогтмол хийж байна.

Өдөр бүр эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлсэн иргэдийн халууныг хэмжиж, маскгүй үйлчлүүлэгчдэд маск өгч, гараа угаах, маскаа зүүх санамж, зөвлөмж өгч ажиллаж байна.

Эрүүл мэндийн төвийн эмч, сувилагч, ажилчдыг нэг удаагийн амны хаалтаар бүрэн хангаж, дархлааг дэмжин витаминд хамруулан ажиллалаа.

Сумын Засаг даргын захирамжаар батлагдсан “Ариутгал халдваргүйжүүлэлтийн баг” болох Эрүүл мэндийн төвийн ариутгал халдваргүйтгэлийн баг өдөр бүр төр, төсвийн байгууллага, аж ахуй нэгж, хүнсний дэлгүүр, хүнсний зах, ШТС, халаалтын төв, худаг ус зэрэг газруудыг хуваарийн дагуу ариутгал халдваргүйтгэлийг хийж нийт 13779 м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийсэн байна.

Тус суманд 2020 оны 11-р сарын 06-ны өдрөөс хойш Улаанбаатар хот болон бусад аймаг, сумаас ирсэн иргэдийн судалгааг гарган тухайн иргэдэд утсаар зөвлөгөө өгч ажиллаж байна.

Мал амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг сумын хэмжээнд 122446 толгой мал, амьтныг хамруулахаас 122446 толгой буюу 100 хувь, паразит өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээ боловсруулалт 100 хувь, туулга бод, бог, гахай 100 хувь, угаалга бод 93 хувь, бог 89.5 хувьтай байна.

Цахим бүртгэлийн нэгдсэн системд хүнсэнд адуу 111, үхэр 247, хонь 542, ямаа 287 толгой, адууны мах 4250 кг, үхрийн мах 12377 кг, сүү 755 литр, хонины мах 5733 кг, ямааны мах 1197 кг, гахайн мах 100 кг бүртгэгдээд байна.

Сумын хэмжээнд 10077 га талбайд улаан буудай тариалснаас цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан 220 га талбай ганд нэрвэгдэж, 2147 га талбайн ургац ногоон тэжээлд шилжиж, 7710 га талбайгаас 10096 тонн улаан буудай буюу нэгж га талбайгаас 13 цн ургац хураан аваад байна.

Тус сумын аж ахуй нэгж, иргэд 2021 оны тариалалтад 605 тонн үрийн улаан буудай, 8700 тонн хүнсний улаан буудайг гурилын үйлдвэрүүд болон тариалан эрхлэлтийг дэмжих санд нийлүүллээ.

Цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан хүнсний улаан буудайн урамшууллын материалыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулаад байна. Тэжээлд шилжсэн 2147 га талбайгаас 1509 тонн ургац хураан авсан.

11-р сарын байдлаар сумын хэмжээнд нөөцөд 63400 боодол ногоон тэжээл, 2200 боодол боосон солом, 5500 боодол рапсны тэжээл, 50 ширхэг соломны рулон, 6 тонн тэжээлийн будаа байна. Эдгээр аж ахуй нэгж, иргэд нь зах зээлд нийлүүлэхээр нөөцлөөд байна. Төмс 100 га-с 1100 тонн, 80,63 га-с 927,4 тонн хүнсний ногоо хураан авсан. Ногоочид өөрсдийн нөөц бололцоог ашиглан 150 гаруй үрийн төмс нөөцөлсөн.



Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд өдөр бүр хүнсний дэлгүүрүүдээс хүнсний нөөцийн мэдээ болон борлуулалт, үнийн мэдээг авч сумын Онцгой комисс, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэн ажиллаж байна.

Сумын 1 дүгээр багийн 2 өрх, Бургалтай 2-р багийн 2 өрх, Цагаан овооны 3-р багийн 1 өрхөд 492 хуц, 340 ухныг хуваарилан олгохоор зөвшилцөн хуц, ухна маллах айл өрхүүд малчидтайгаа уулзаж тохирон цуглуулан авч байна.

Орхон бүсийн сум дундын ойн ангийн дарга Ү.Баян-эрдэнэ сумын цагдаа Б.Хонгорзулын хамт эргүүл хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа.

2020 оны аймгийн ИТХ-аар батлагдсан түлээний модны хуваарийн дагуу Орхон, Сайхан сумын Засаг дарга нартай гэрээ хийж, гэрээний дагуу түлшний модыг иргэдээр бэлтгүүлэн ажиллаж байна. Хушаат, Сант, Орхон, Баруунбүрэн сумын байгаль хамгаалагч нараас мод бэлтгэх эрхийн бичгийн жагсаалтыг авч нэгтгэн ажиллалаа.

#### **Баянгол сум:**

МУ-ын Засгийн газрын 2020 оны 181 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2020 оны А/310, сумын Засаг даргын А/257 дугаар захирамжийн дагуу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунган сумын коронавирус цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

Сумын хэмжээнд Цагдаагийн хэсэг, Гал түймрээс урьдчилан аврах 40-р анги, Улсын нөөц, хүмүүнлэг тусламжийн анги, Ерөнхий боловсролын сургууль, Баянгол цэцэрлэг, Засаг даргын Тамгын газар хамтран 24 цагийн пост 6 цэгт 12 албан хаагч, хөдөлгөөнт хяналтын цэг 3 цэгт 12 албан хаагч үүрэг гүйцэтгэн ажиллаж байна.

Улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдалтай зарласантай холбогдуулан сумын Засаг даргын 2020 оны А\258 дугаар “Архи согтууруулах ундаа, худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох тухай” захирамжийн дагуу сумын хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдан борлуулахыг 11-р сарын 19-ний өдрөөс 12-р сарын 01-ний өдрийг хүртэл хориглож, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн Онцгой комиссын 2020 оны 05 тоот “Бүх нийтийн бэлэн байдлын горимыг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” тогтоолыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сумын нүүрсний нөөц бүрдүүлэх зорилгоор “Шарын гол” ХХК-д хүсэлт гарган нүүрсний нийлүүлэлтийг хийж байна.

Улаанбаатар хот болон бусад аймаг суманд хөл хорионд байгаа 192 иргэдийн судалгаа, мөн эрсдэлт нөхцөлд ажиллаж байгаа нийт 220 ажилтан, албан хаагч, гэрийн тусгаарлалтад байгаа 55 иргэний судалгааг гарган аймгийн онцгой комисст хүргүүлж, эхний түргэвчилсэн оношилгоонд хамруулж, хамрагдсан иргэдийн хариу сөрөг гарсан.

Сэлэнгэ аймгийн онцгой комиссын 2020 оны 184 тоот “Үүрэг хүргүүлэх тухай”, 201 тоот “Чиглэл өгөх тухай” албан бичгийн дагуу зэргэлдээ сумаас түлшний мод бэлтгэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2020 оны Шуурхай штаб байгуулж ажлын тусгай горимд шилжүүлэх тухай А/254 дүгээр захирамжийн дагуу Засаг даргын Тамгын

газрын байранд шуурхай штабыг байрлуулан 24 цагийн хариуцлагатай жижүүрийг томилж, үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээ, мэдээллийг аймгийн онцгой комисс болон холбогдох байгууллагад 99561654 дугаарын утсаар болон цахимаар хаягаар хүргүүлэн ажиллаж байна.

Сумын төвд Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд зохих журмын дагуу 8 хүний ор бэлтгэн тусгаарлах байрны бэлэн байдлыг хангаад байна.

Эрүүл мэндийн төв, ЗДТГ-тай хамтран өдөр бүр худалдаа үйлчилгээний 20 цэгийн 1262 м2, төр төсвийн 12 байгууллагын 23866 м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийж байна.

11-р сарын 11-ний өдрийн байдлаар хоол хүнсэнд 2.915.520, шатахуунд 2.298.800 төгрөг, ариутгал хамгааллын хэрэгсэл тусгаарлах байрны бэлтгэх ажилд 4.395.000 төгрөг нийт 9.253.920 төгрөгийн сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаад байна.

Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 дугаар тогтоолын хавсралтад заагдсан хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааны жагсаалтад багтсан шалтгаанаар 11-р сарын 11-ний өдрөөс эхлэн нийт 53 иргэний хүсэлтийг шийдвэрлэн ажиллалаа.

Соёлын төвөөс 11-р сард соёл урлаг, дугуйлан, номын сангийн үйлчилгээний хүрээнд:

1. “Хөдөлгөөн эрүүл мэнд” уриатай нийтийн бүжиг
2. Ахмадын сувиллын амрагчдад нүүдлийн номын сангийн үйлчилгээ
3. Эрүүл мэндийн төвд хэвтэн эмчлүүлэгчдэд нүүдлийн номын үйлчилгээ
4. Дууны дугуйлан
5. Бүжгийн дугуйлан зэрэг 5 удаагийн арга хэмжээнд 110 хүнийг хамруулан ажилласан.

11-р сарын 06-нд Дулаанхан тосгонд зохион байгуулагдсан “Аймгийн бий биелээчдийн анхдугаар уулзалт, өдөрлөг”-т бүжгийн багш Б.Бадралбуян, хөгжмийн багш Д.Одгарав, соёлын өвлөн тээгч Д.Гэрэлээ нар, Соёлын яамнаас зохион байгуулж буй “Цахим орчинд хөг нэмье” онлайн фестивальд ЕБС-ийн дуу хөгжмийн багш Ё.Ганбаатар, дууны дугуйлангийн суралцагчидтай хамтран найрал дуугаар тус тус оролцлоо.

Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор “Дархлаагаа дасгалаар дэмжье” цахим дуудлагыг бүжгийн дугуйлангаас санаачлан зохион байгуулан ажиллаж байна.

Улсын тэргүүний ЕБС нь тус сард "Хамгаалагдсан хүүхэд" сарын аяныг санаачлан багш, ажилчид, эцэг эхчүүдийн дунд зохион байгуулан ажиллаа. Уг аяны хүрээнд сумын нутаг дэвсгэрт багш, ажилчид, эцэг эхчүүд хамтран эргүүлд 18:00-20:00 цагийн хооронд гарч ажилласан.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Сэлэнгэ аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас зохион байгуулж буй “Гэртээ өөрийгөө хөгжүүлье” цахим уралдаанд тус сургуулийн 18 суралцагч оролцсон.

Улсын онцгой комиссын 2020 оны 04 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын 2020 оны А/304 дүгээр “Маскаа зүүе-Гараа угаая” 2 дугаар аян зохион байгуулах тухай захирамжийг сургуулийн 70 багш, ажилтан, 1-12 дугаар

ангийн 33 бүлгийн 939 суралцагч, 74 эцэг эх, асран хамгаалагчдад танилцуулан аянд нэгдэхийг уриалан, цахим орчинд сурталчлан ажиллаа.

Боловсрол, шинжлэх ухааны яамны 2020 оны 6/1071 тоот “Аян зохион байгуулах тухай” албан бичгийн дагуу “Төрийн дууллаа хүндэтгэн дуулж, Төрт ёсоо дээдэлье” аяныг 09-р сарын 21-ний өдрөөс 11-р сарын 16-ны өдрийг дуустал зохион байгуулж, арга хэмжээний хүрээнд төрийн дууллыг хуульд заасан тэмдэглэлт өдөр, долоо хоног бүрийн эхний өдрийн 1 дүгээр цагийн хичээл эхлэхэд эгшиглүүлэх, анги нийтээр дуулж хэвшсэн, агуулга мөн чанарыг багш, ажилтан суралцагчдад ойлгуулах зорилгоор мэдээлэл өгч, анги кабинетад төрийн дууллыг байршуулан, дуу хөгжмийн хичээлээр дамжуулан Төрийн дууллын үгийг бүрэн тогтоож, зөв дуулах чадвар эзэмшүүлэх зэрэг ажлыг зохион байгуулсан.

Сургуулийн НУЗАН-ийн багш нар “Багш зөвлөж байна” сарын аяныг зохион байгуулж “Covid-19” өвчнөөс сэргийлэн гар угаах, амны хаалт зүүх, гадуур гарахгүй байх, теле хичээлээ цаг хугацаандаа үзэж судлах, хувийн ариун цэврийг сахих, хүүхэд хамгаалал, орчны аюулгүй байдлыг хангах, ахуйн ослоос сэрэмжлэх, дархлааг дэмжих, ЭМЯ, онцгой байдлаас гаргасан зөвлөмж, зөвлөгөөг сахин биелүүлэх, зэрэг мэдээллийг эцэг эх асран хамгаалагч нарт дамжуулан ажиллаж байна.

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж улс даяар хөл хорио тогтоон бүх шатны сургалтын үйл ажиллагааг зогсоосонтой холбогдуулан анги удирдсан багш нараас эрсдэлт нөхцөлд амьдарч буй түлээ нүүрсний хомстолтой 38, хоол хүнсний хомсдолтой 29, гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй 7, ар гэрийн анхаарал халамж сул 8, ар гэр нь архины хамааралтай 10 хүүхдийн судалгааг гарган багийн Засаг дарга нарт хүргүүлэн ажилласан.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны “Хичээл сургалтын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох тухай” А/146 тоот тушаалын дагуу багш нар ажил үүргээ гэрээсээ цахимаар хийж гүйцэтгэж байна. Энэ хугацаанд нийт теле хичээлд хамрагдвал зохих 988 суралцагчдаас 920 суралцагч хамрагдаж, 78 суралцагч сумын төвөөс алслагдмал газар амьдардаг, сүлжээ байхгүй, теле хичээл хуваарийн дагуу гараагүй, нарны зайн хураагуураар үздэг, зурагт эвдэрсэн зэргээр шалтгааны улмаас тогтсон цаг хугацаандаа хамрагдаж чадаагүй, теле хичээлээ огт үзээгүй 16 суралцагч байгаа нь сүлжээгүй газарт оршин суудаг малчин өрхийн хүүхдүүд байна. Эцэг эх нь өөр сум орон нутагт хөл хорионд орсон, ажилдаа явсан шалтгаанаар харгалзах хүнгүй байгаа 4 суралцагчдад анги удирдсан багш нар анхаарал тавин ажиллаж байна.

Хүн бүр гэртээ хөл хорионд орсон энэ цаг үед багш, ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдэх хүнсний хэрэгцээнд нэмэр болох зорилгоор малчинтай гэрээ байгуулж хонины махны нийлүүлэлтийг зохион байгуулж байна.

1-р цэцэрлэгийн “Эцэг, эхийн 10 дугаар чуулган”-ыг тус сард зохион байгуулж 200 гаруй эцэг, эхчүүдийн төлөөллийг хамруулан хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг танилцуулж “Хүүхдийг хүмүүжүүлэх зэрэг арга”, “Гар хэрхэн зөв угаах вэ” зэрэг сэдвээр нийт эцэг, эхчүүдийн дунд сургалт зохион байгуулсан.

Сэлэнгэ аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраас 11 дүгээр сарын 17-25-ны хооронд зохион байгуулж буй “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлье” цахим уралдаанд цэцэрлэгийн авьяаслаг багачуудыг хамруулан ажиллаж байна.

Улс орны хэмжээнд дэгдээд буй цар тахлын аюулыг хамтдаа эрсдэл багатай даван туулахын тулд “FOOD BANK”, “Юу байна түүгээрээ” аяныг байгууллагынхаа ажилтан, албан хаагчдын дунд зохион байгуулж, цугларсан хүнсний бүтээгдэхүүн, нүүрс, түлшний модыг сумын Онцгой комиссоор дамжуулан хүнс, тэжээлийн тусламж шаардлагатай зорилтот бүлгийн өрхүүдэд хүргүүлсэн.

Эрүүлийн мэндийн төвд 11 дүгээр сард Эрүүл мэндийн төвд хэвтэн эмчлүүлсэн хүний тоо 45, нас баралт 2, төрсөн эхийн тоо 4, яаралтай тусламж 16, ойрын дуудлага 48, ойрын дуудлага 54, хөх умайн үзлэг 16, артерийн гипертензи, чихрийн шижин өвчин эрт илрүүлэг үзлэг 23, осол гэмтлийн тусламж, үйлчилгээ 6 иргэнд үзүүлж, томуу, томуу төст өвчний эсрэг вакциныг 2-5 насны 150, товлох вакциныг 0-5 насны 148 хүүхдэд тус тус хийсэн байна.

Сэлэнгэ аймгийн Эрүүл мэндийн газраас 11-р сарын 01-ний өдөр “Коронаврусын үеийн шинжилгээ хийх арга техник” сэдэвт сургалтыг зохион байгуулж тус сургалтад Эрүүл мэндийн төвийн эмч ажилчид төр төсвийн байгууллагын дарга, эрхлэгч нарын 78 ажилтан, албан хаагч, сумын ЭМТ-өөс Төр төсвийн байгууллагын ажилтан албан хаагч, онцгой комиссын гишүүдэд 11-р сарын 12-ны өдөр зохион байгуулсан “Хамгаалах хувцас өмсөх, тайлах дараалал” сэдэвт сургалтад 42 албан хаагч тус тус хамрагдсан.

11-р сарын 08-ний өдөр зохион байгуулагдсан “Хархан нүдэн” тоглолт үзсэн тус сумын 25 иргэн, 11 дүгээр сарын 20-22-ны өдрүүдэд Мандал сумын нэгдсэн эмнэлгийн лаборант эмчтэй хамтран сумын олон нийтийн үйлчилгээнд ажиллаж буй төрийн албан хаагч, худалдаа үйлчилгээний 270 ажилтанд коронавирус илрүүлэх шинжилгээнд тус тус хамруулж ажиллалаа.

Хараа, Баян, Гонир багууд: Ковид-19 цар тахлын улмаас үүсэж буй сорилт, бэрхшээлүүдийг даван туулах, хүнд хэцүү үед нэгэндээ сэтгэлийн дэм өгөх зорилгоор дэмжлэг туслалцаа шаардлагатай өрхийн судалгааг гарган “Сайхан бүсгүй” группийн үүсгэн байгуулагчтай хамтран сайн үйлсийн хандивын аян өрнүүлж, өрх толгойлсон эх, зорилтод бүлгийн өрх, ганц бие ахмад настан зэрэг дэмжлэг туслалцаа шаардлагатай Хараа 1 дүгээр багийн 2, Баян 2 дугаар багийн 8, Гонир 3 дугаар багийн 12 нийт 22 айл өрхөд хоол хүнс тэжээл, түлээ нүүрсний тусламж үзүүлэн ажиллаж байна.

Шимэгчилэх өвчнөөс сэргийлэх боловсруулалтын арга хэмжээнд МЭҮН-үүд бод 9700 толгой, бог 37400 толгойг хамруулж, гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэг тогтоосонтой холбоотой 3 удаа нийт 2650 м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийж ажиллалаа.

Цахим системийн гэрчилгээ бичилтэд цаг тухай бүрд хяналт тавин баталгаажилт хийж байна. Аймгийн хүн амын махны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулж буй “Өвлийн идэш” арга хэмжээний үеэр бүх төрлийн мах 12209 кг, аарц 80 кг, сүү 640 л, тараг 200 литрт цахим гэрчилгээ бичигдсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/304 тоот “Маскаа зүүе, гараа угаая” 2 дугаар аян зохион байгуулах тухай захирамжийг 42 иргэн, ААН байгууллагуудад, Монголын Улаан загалмайн хорооны 2020 оны 178 дугаар тогтоол, аймаг сумын Онцгой комиссын хурлын тэмдэглэлийг 23 иргэн, ААН байгууллагуудад, сумын Засаг даргын 2020 оны А/252 тоот “Зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, бүх

шатны боловсролын байгууллагын хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоож, цагийн хязгаарлалт тогтоох тухай” захирамж, 2020 оны А/258 тоот 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэл “Архи согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг хориглох” тухай захирамжийг архи согтууруулах ундаа борлуулдаг тусгай зөвшөөрөлтэй 14 ААН байгууллагуудад, аймгийн онцгой комиссын 2020 оны 128 тоот “Коронавируст халдвар тархах эрсдэлийг бууруулах талаар” зөвлөмжийг 23 иргэн, ААН байгууллагуудад, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2020 оны 595 тоот Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулдаг “Сэлэнгэ алтан тариа” ХХК нь түгээлт хийх талаарх мэдэгдлийг тус тус хүргүүлж, иргэд аж ахуй нэгж байгууллагыг цаг үеийн мэдээ мэдээллээр шуурхай хангаж, Цагдаагийн байгууллагатай хамтран хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын 2020 оны 590 тоот мэдэгдэл, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/74 дүгээр тушаалын дагуу сумын хүн амын тоонд тулгуурлан өргөн хэрэглээний гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийг 7 хоног бүр тодорхойлж бүтээгдэхүүний хүрэлцээг тогтвортой байлгах, нөөц бүрдүүлэлт, дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт тавих, өргөн хэрэглээний гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгааг 7 хоногт 2 удаа авч аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2020 оны 18/02 тоот “Хяналт шалгалт хийх” тухай байнгын удирдамжийн дагуу Баянгол сумын Хараа 1 дүгээр багийн нутаг дэвсгэр Чонын ам, Нарт, Бор толгой, Баян 2 дугаар багийн нутаг дэвсгэр Нарангийн ам, Шар хөтөл, Буянт, Хар морьт, Тариат гэх газруудаар хууль бус мод бэлтгэл, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор Экологийн байцаагч, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч нарын бүрэлдэхүүнтэй хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар Хараа 1 дугаар багийн Нарт гэх газар зохих зөвшөөрөлгүй бутлагч тээрмийн үйл ажиллагаа явуулж байсан 7 иргэний 13 чулуу бутлагч тээрмийг СЭ-11 улсын дугаартай лацаар лацдаж, лац тавьсан тэмдэглэл үйлдэж хариуцагч иргэдэд лацны бүрэн бүтэн байдлыг хангах заавар зөвлөгөө өгч, зураг дарж баримтжуулан ажилласан. Мөн Бор толгой гэх газар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг ААНБ-ын эвдэрсэн талбайд гар аргаар ашигт малтмал олборлох зорилготой хэсэг бүлэг иргэдийн үйл ажиллагааг зогсоож бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан “ХОРИО ЦЭЭРИЙН” дэглэмийг баримтлах талаар заавар зөвлөгөө өгч, зураг авч баримтжуулж ажиллалаа.

11-р сард 2 аж ахуй нэгжид хог үүсгэсний хураамж болох 259,000 төгрөг, 1 аж ахуй нэгжид түлээний мод бэлтгэх эрхийн бичиг олгож 39,700 төгрөг, ан агнуурын эрхийн бичгийг 1 иргэнд олгож 66,000 төгрөг нийт 364,700 төгрөгийн орлогыг төрийн санд төвлөрүүлж ажилласан.

Халамжийн тэтгэврийг 95 иргэнд 28945.4 мян.төгрөг, нийгмийн халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмжийг 84 иргэнд 8851.6 мян.төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 38 иргэнд 6069.1 мян.төгрөг, жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмжийг 37 иргэнд 1477.3 мян.төгрөг, цалинтай ээж хөтөлбөрт 239 иргэнд 11649.9 мян.төгрөг, алдарт эхийн одонгийн мөнгөн тэтгэмжийг 2 иргэнд 200.0 мян.төгрөг, ахмад настны

хөнгөлөлтийг 10 иргэнд 1336.8 мян.төгрөг, гавьяат цолтон ахмад настан 1 иргэнд 401.2 мян.төгрөгийн тусламж, хөнгөлөлт, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлтийг 26 иргэнд 2800.0 мян.төгрөг, амьжиргааг дэмжих зөвлөлийн мөнгөн урамшууллыг 4 иргэнд 115.2 мян.төгрөг, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнд 163 иргэнд, 3152.0 мян.төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг дэмжлэг үзүүлж нийт 699 иргэнд **64998.5** мян.төгрөгийг олгож “Нийгмийн халамжийн тухай хууль”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль”, “Ахмад настны тухай хууль”, “ЭОХӨТЭЭТ олгох тухай хууль”, Монгол Усын Засгийн газрын 17, 340, 25, 96, 167-р тоот тогтоол бусад холбогдох хуулийн заалтуудын хүрээнд зөвлөгөө зөвлөмж мэдээлэл өгч ажиллалаа.

Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж байнгын асаргааны мөнгөн тэтгэмжид 7 иргэнийг хамруулахаар шийдвэрлэсэн.

Энэ сард газрын харилцааны нэгдсэн системд шинээр 15 өргөдөл, газар хашаа байшин худалдан авахаар 3 иргэн, шинээр эзэмшихээр 4 иргэн 2 ААН-ийн, эрх шилжүүлэхээр 3, хуучин эзэмшиж байсан газраа өмчилж авах 3 нийт 45 өргөдлийг хүлээн авч Газар эзэмших эрхийг баталгаажуулах тухай 2 ААН-д 44,48 га газрыг, 1 иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 0,25 га газрыг, 3 иргэнд өмчлүүлэхээр 0,36 га газрыг, 3 иргэнд өвөлжөөний доорх газрын зориулалтаар 1,78 га газрыг, 1 ААН-д Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2020 оны 09 тоот шийдвэрийн дагуу 11 га газрыг төмс хүнсний ногооны зориулалтаар сэргээн эзэмшүүлсэн, 1 ААН-д тэжээлийн ургамал тарих зориулалтаар 15,8 га газрыг тус тус сумын Засаг даргын шийдвэрээр олгосон. Мөн энэ 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 25 иргэн 3 ААН-ээс саналын хуудсаар санал авч ажиллалаа.

#### **Ерөө сум:**

Тус сард сумын Засаг даргын А захирамж 16, Б захирамж 4, сумын Засаг даргын албан тоот 63, ЗДТГ-ын даргын Б тушаал 5, албан тоот 6 гарч хяналтад авч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Дээд байгууллагаас 69 бичиг ирж, 33 хариутай бичиг бүртгэж хугацаандаа явуулсан хариутай бичиг 31, хугацаа болоогүй бичиг 1, хугацаа хоцорч явсан 1 бичиг байна.

Сумын Онцгой комисс өндөржүүлсэн бэлэн байдал зарласан хугацаанд 5 удаа хуралдаж холбогдох арга хэмжээг цаг тухай бүр авч хэрэгжүүлэн, албан хаагчдад үүрэг даалгавар өгөн ажиллаж байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан төр, төсвийн байгууллагын 48 албан хаагч нийтийн эзэмшлийн зам талбай болон иргэдийн хөдөлгөөн, худалдаа үйлчилгээний газруудын үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Сумын орох, гарах хэсэгт цагдаа, төр, төсвийн байгууллагын эрэгтэй 24 албан хаагч хуваарилагдан 24 цагаар постонд ажиллаж байна. Мөн Бугант тосгоны 3 постод 22 албан хаагч ээлжлэн эргүүл хяналтын ажлыг гүйцэтгэн ажиллаж байна.

Сумын Засаг даргын Тамгын газар, “Лха-Чинбу” мал эмнэлэгийн салбартай нэгжтэй хамтран нийтийн эзэмшлийн зам, талбай, худалдаа үйлчилгээний цэгүүдэд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна.

Сумын хэмжээнд спорт зал, заалны өргөтгөлд 69 ор, сумын Эрүүл мэндийн төвд сэжигтэй тохиолдлын 5 ортой өрөөг бэлдээд байна. Цаашид орны тоо болон байрыг нэмэгдүүлж ажиллах чиглэл хүргүүлэн ажиллаж байна.

Соёлын төвийн цагаан хоолойгоор иргэдэд сэрэмжлүүлэг мэдээллийг өдөр тутам ажлын цагаар тогтмол хүргэн ажиллаж байна.

Сумын ЭМТ нь эм тарианы 2 сарын нөөцтэй, 1 удаагийн халдвар хамгааллын хувцас хэрэглэл 197, маск 1200, бээлий 636 ширхэг байна.

Аймгийн Засаг даргын захирамж, сумын Засаг даргын А/156, А/159 тоот захирамжийн дагуу өндөржүүлсэн бэлэн байдал зарласан хугацаа дуустал архи согтууруулах ундаа худалдан борлуулахыг түр хориглож, 18 ААН, 2 кафе, 4 зочид буудалд захирамжийг танилцуулж, ААНБ-ын архи согтууруулах ундааг хэсгийн төлөөлөгч, хариуцлагатай жижүүрүүдийн хамт тоолж, хураан, агуулахад хийж битүүмжилж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/309 тоот захирамжийн дагуу сумын иргэдийг хүнсний бүтээгдэхүүнээр хангах, нөөц бүрдүүлэлт, дэлгүүрүүдийн борлуулалтын судалгааг өдөр бүрийн 12 цагт аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэн ажиллаж байна.

Сумын онцгой комисст 19 иргэн, 1 холбоо, 1 ХХК нийтдээ 5.000.0 төгрөгийн бэлэн мөнгө, 1.222.7 төгрөгийн хүнс, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн, хонь 8, ямаа 1, адуу 1 хандивласан байна.

Бүх нийтийн хатуу хөл хорионы дэглэм тогтоон ажиллаж байгаатай холбогдуулан сумын онцгой комиссоос 45 өрхөд хүнс тэжээлийн, 13 өрхөд түлээний модны тусламж үзүүлж ажилласан.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Спорт цогцолборт 7.000.0 төгрөгийн урсгал засварын ажил хийгдэж байна.

ЭМТ-ийн дотоод сургалтаар хамгаалалтын хувцас, хэрэглэлийг өмсөж тайлах, гар угаах дараалал зэрэг сэдэвт сургалтыг сумын Онцгой комиссын гишүүд, холбогдох ажилтан, албан хаагчдыг хамруулсан.

“Үжин” төвийг үүсгэн байгуулагч, хамтарсан багийн үндэсний сургагч багш Д.Ундраагийн “Хүүхдийн хөгжил хамгаалалд эцэг эхийн оролцоо” сэдэвт лекцийг 450 гаруй эцэг, эхчүүдэд, “Хүүхдийн хөгжил хамгааллыг сайжруулахад төрийн албан хаагчийн хариуцлага” сэдэвт лекцэд төр, төсвийн байгууллага, аж ахуй нэгжийн 50 гаруй албан хаагчдын хамруулсан.

Бүх нийтийн хөл хорио тогтоосонтой холбогдуулан аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас илгээсэн “Цахим орчин дахь эцэг эхийн хариуцлага”, “Ахуйн осол гэмтлийн талаарх”, “Маскаа зүү, гараа угаая”, “Дэлгэцийн донтолт” зэрэг шторк, видео бичлэг, мэдээ мэдээллийг тогтмол сумын албан ёсны цахим Facebook хуудсаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэн ажиллаж байна.

Сумын Эрүүл мэндийн төв нь 11 дүгээр сард амбулаториор 321 иргэнийг үзлэг шинжилгээнд хамруулж, 18 хүнийг хэвтүүлэн 203.0 мян.төгрөгийн эм тариа, ороох боох материал зарцуулан ажилласан. Түргэн тусламжийн 112 дуудлага хүлээн авснаас, алсын 12 дуудлагад үйлчилсэн.

Аймгийн төв Сүхбаатар суманд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх дайчлан ажиллуулах журмын дагуу бага эмч М.Ганцэцэг, лаборант

А.Даваажаргал, жолооч Ж.Энхбаатар, үйлчлэгч Б.Энх-Амгалан нар ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газраас зохион байгуулсан "[Соёлын Цаг](#)" аяны хүрээнд сумын Соёлын төвийн дэргэдэх Номын сангаас ЕБС-ийн Монгол хэлний заах аргын нэгдэлтэй хамтран ЕБС-ийн 6-12-р ангийн сурагчдын дунд "[Цэвэр монгол бичигтэн](#)" шалгаруулах уралдааныг зохион байгуулж, шагналыг гардууллаа.

"Тавин Ус" өртөөний ажилчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг сагсан бөмбөг, гар бөмбөг, шатар, даам, дартс гэсэн 5 төрлөөр тэмцээн болж, тэмцээнд 7 багийн 40 гаруй тамирчид оролцлоо.

Улс даяар өндөржүүлсэн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Монгол Улсын Соёлын яамнаас зарласан "Цахим орчинд соёл түгээе" уриалгыг орон нутагт хэрэгжүүлэн Ерөө сумын Соёлын төвийн дэргэдэх номын сангаас ЕБС-ийн хүүхэд, багачуудын дунд "Миний сайхан нутаг" цахим уран уншлагын уралдааныг зарлаад байна.

Хужирт, Нарийн хөндий, Шаазгай, Зүүн шинэстэй, Баруун шинэстэй гэх газрын чиглэлд хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эргүүл, хяналт шалгалтын ажлыг тогтмол хийж, хяналт шалгалтаар ойгоос 4 иргэн зөвшөөрөлгүйгээр мод бэлтгэсэн зөрчлийг илрүүлж, холбогдох арга хэмжээг авч ажиллалаа.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд сумын өвс тэжээлийн аюулгүйн фондод бизнесийн хадлан бэлтгэсэн 8 иргэнээс 1500 боодол буюу 30 тн өвс нөөцлөөд байна. Сумын хэмжээнд 624 өрх 20654 тн хадлан бэлтгэсэн байна.

Мөн "Идэш" арга хэмжээний хүрээнд 22 өрх 620 толгой мал худалдан борлуулах /зарах/ хүсэлтээ өгсөн. Үүнээс бод 70, бог 550 байна.

#### **Жавхлант сум:**

Сумын Засаг даргын 2020 оны 01 дүгээр албан даалгавар, 2020 оны "Хариуцлагатай эргүүл жижүүрийг томилон ажиллуулах тухай" А/21 тоот захирамжаар баталсан хуваарийн дагуу төр, төсвийн байгууллагуудын албан хаагчид эргүүл, жижүүрийн үүргийг гүйцэтгэн ажиллаж байна.

Авлигын хор аюулыг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор төр төсвийн байгууллага иргэдийн дунд "Авлигын мөн чанар, шалтгаан, хор хөнөөл" соён гэгээрүүлэх сургалт мөн "Авлигагүй нийгмийн төлөө бид хамтдаа" зохион бичлэгийн уралдааныг зохион байгууллаа.

Улсын Онцгой комиссоос санаачилга гарган хэрэгжүүлж буй "Маскаа зүүж-Гараа угаая" 2 аяныг сумын хэмжээнд өрнүүлж, иргэдэд сурталчилж, мэдээлэл хүргэн ажиллаж байна.

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацааг сунгасантай холбогдуулан иргэд маскаа зүүж, гараа тогтмол угаах, үйлчилгээний газрууд масктай иргэнд үйлчилж байхыг сумын онцгой комиссоос зөвлөн ажиллаж байна.

Улсын хэмжээнд "Гамшгаас хамгаалах тухай хууль"-ийн дагуу, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны А/310, сумын Засаг даргын А/149 тоот захирамжийг хэрэгжүүлэн, хэрэгжилтэд ажиллаж байна.

Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан сумын төв, хөдөөгийн өрхүүдийг сумын шуурхай штаб болон



онцгой комиссын гишүүдэд хуваарилан өгч зөвлөмж, сэрэмжлүүлэг, мэдээ мэдээллийг нийт 401 өрхөд хүргэн ажиллалаа. Мөн сумын онцгой комисс, шуурхай штабаас 24 цагийн эргүүл жижүүрийг Жавхлант 3 замын уулзвар дээр гарган сумаас гарах, орох хөдөлгөөнд хяналт тавьж ариутгал, халдваргүйтгэлийг хийж гэрийн тусгаарлалтад байгаа халдвар авсан иргэнтэй хоёрдогч хавьталтай цуг явсан гэх тус сумын иргэн М-ыг гэрийн хорионд байлгаж, шуурхай штабын гишүүд хуваарийн дагуу өдөр бүр хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд шинэ коронавирус /COVID-19/ цар тахал өвчний халдвар нэмэгдэж байгаатай холбогдуулан сумын онцгой комисс, шуурхай штабын гишүүдэд хамгаалах хувцсыг хэрэглэх дадлага сургалтыг зохион байгууллаа.

“Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал” сэдэвт сургалтыг ЕБС, СӨБ-ын багш нар, “Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсооход эцэг эхийн үүрэг хариуцлага” сэдэвт сургалтыг иргэд төрийн албан хаагчдын дунд зохион байгууллаа.

Соёлын яамнаас Ковид цар тахал, хөл хорионы үед “Цахим орчинд соёл түгээе” уриалгыг орон нутагт хэрэгжүүлэн “Цахим соёл-1” аяныг эхлүүлэн “Бүх нийтийн соёлын боловсрол”, “Жавхлант өв соёл” зэрэг соён гэгээрүүлэх цуврал сургалт, сурталчилгаа, “Хөгжилтэй гэр бүл”, “Үлгэр ярих цаг”, “Соёлын түүх Жавхлант альбом”, Бүх нийтийн бүжгийн боловсрол” зэрэг уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулж эхлээд байна.

Улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин хөл хорио тогтоосон үед 22 өрхөд хоол хүнс, өргөн хэрэглээний барааны тусламж дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Сумын хар тарлан, Монтбиллярд, Алатау үүлдрийн 2 аж ахуйн нэгж, 5 малчин өрхийн 455 үхэрт үзлэг ангилалт хийж, ээмэг зүүлгэн бүртгэл хийж ажиллалаа.

### **Зүүнбүрэн сум:**

11-р сард 53 албан бичиг ирснээс 13 хугацаатай бичиг, үүнээс хугацаандаа явсан 10 хугацаа хоцорсон 3 албан бичиг байна. Сумын Засаг даргын 15 захирамж гарч хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд онцгой комиссын гишүүд сумын Засаг даргын 2020 оны А/182 тоот захирамжийн дагуу 24 цагаар жижүүрлэн ажиллаж байна. Мөн сумын Засаг даргын А/180 тоот захирамжаар архи согтууруулах ундаа худалдан борлуулахыг түр хугацаанд хориглоод байна.

Сумын хэмжээнд ажиллаж буй худалдаа үйлчилгээний 4 дэлгүүрт аймаг, сумын Засаг даргын захирамжийг танилцуулан, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Шаамар сумын гүүр, Зүүнбүрэн сумын Мангирт 3 дугаар багийн худаг, Орос даваа Рашаантын даваа, Орхон голын гүүр зэрэг газруудаар хөдөлгөөнт эргүүлийг ажиллуулж, хөдөлгөөнт эргүүл ажиллах хугацаандаа 350 гаруй км зам туулж, 40 литр шатах, тослох материалыг зарцуулж, 150 гаруй иргэн, 2 аж ахуй нэгж, 28 тээврийн хэрэгсэлд үзлэг шалгалт хийн Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зөвлөмж, онцгой комиссын шийдвэрийг цаг бүрд нь танилцуулан ажиллаж байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилсэнтэй холбогдуулан өөр сум, аймаг, нийслэлээс ирэх 217, нийслэл, аймаг орон нутаг явах 23 иргэний судалгааг гарган аймгийн Онцгой байдлын газарт хүргүүллээ. Мөн мэргэжлийн байгууллагаас гаргасан зөвлөмж, сэрэмжлүүлгийг урсдаг зар болон Zuunburen zar, Зүүнбүрэн сумын онцгой комисс цахим хаягаар дамжуулан иргэдэд тогтмол сурталчлан ажиллаж байна.

Хүдэр сумаас орон нутгийн иргэдээ татан авч ариутгал халдваргүйжүүлэлтэд хамруулж 14 хоногийн хугацаанд гэрийн тусгаарлалтад байх зөвлөгөө өгөн ажиллалаа.

Иргэний бүртгэлийн тухай хуулийн дагуу гэрлэсний бүртгэл 1, шилжин ирсэн бүртгэл 3, лавлагаа олголт 8, гэрчилгээ дахин олголт 4 нийт 19 бүртгэлийн үйлчилгээг иргэдэд үзүүллээ.

“Хүүхэд хамгаалалд эцэг эхийн оролцоо” сэдэвт сургалтыг “Үжин” төвтэй хамтран зохион байгуулж 100 гаруй иргэдийг хамрууллаа.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан "Food bank" аяныг зохион байгуулж хүнс тэжээлийн хомсдол үүсэх магадлалтай эрхэлсэн ажилгүй, өрх толгойлсон олон хүүхэдтэй 40 өрхөд хүнсний дэмжлэг үзүүлэх ажлыг 1.600.0 төгрөгийн тусламж үзүүлж онцгой комисст 700.0 төгрөгийн хүнсний нөөц бүрдүүлэн ажиллалаа.

Улсын Онцгой комиссын 2020 оны 12 дугаар тогтоолын дагуу 11-р сарын 11-ний өдрөөс сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг түр хугацаанд зогсоогоод байна. Тус хугацаанд хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхэд, хараа хяналтгүй буюу эцэг эх, асран хамгаалагч насанд хүрсэн хүнгүй байгаа хүүхэд, теле хичээлтэй холбоотой бусад гомдол мэдээллийг хүлээн авах утасны жагсаалтыг Zuunburen zar цахим хаягаар иргэдэд дамжуулан хүргэж байна.

Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган худалдаа үйлчилгээний газрууд 3400 м2 талбайг ариутгаж ажиллалаа.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан хүнсний нөөцийн хомсдол үүсгэхгүйн тулд мал эмнэлгийн цахим гэрчилгээг 7 хоногийн 24 цагаар олгон амьдаар 99 толгой, махаар 1741 кг мал, маханд цахим гэрчилгээ олгож ажиллалаа.

Сумын ЗДТГ-ын урд байранд тусгаарлах байрыг 6 хүний ортойгоор бэлдэж, 2.000.0 төгрөгийн хамгаалах хувцас хэрэгсэл бусад эд зүйлийг бэлтгэлээ.

Сумын төр, төсвийн байгууллагуудын санхүүгийн анхан шатны баримтыг хянан шалгаж, Санхүүгийн удирдлагыг мэдээллээр хангах системд давхардсан тоогоор 1130 байгууллагын 1.720.262.844.19 төгрөгийн гүйлгээг шивж орууллаа.

Сумын хэмжээнд 13.950.000 төгрөгийн цалингийн урьдчилгааны авлагатай, цалингаас суутгасан нийгмийн даатгалын шимтгэл 3.257.512, НДШ урсгал засвар 286.000, эмийн 11.827.717. нийт 15.371.229 төгрөгийн өглөгтэй байна. ЭМД-ын санхүүжилт тавигдаагүйгээс эхний 7 сард эмийн өр үүссэн байна.

2020 оны өдөр тутмын анхан шатны баримтыг тулган шалгаж, 585 анхан шатны баримтыг баталгаажуулан, 3 боть 1,056 байгууллагын 1.081.087.654 төгрөгийн хадгаламжийн нэгжийг архивлан ажиллалаа.

### **Мандал сум:**

Сумын амьжиргаа дэмжих зөвлөл 2 удаа хуралдаж байнгын асаргаа шаардлагатай ахмад настны сунгалт 7, хөгжлийн бэрхшээлтэй иргэний сунгалт 8, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сунгалт 5 нийт 20 иргэний өргөдлийг шийдвэрлэж ажиллалаа.

УИХ-ын хурлын гишүүн Ч.Ундрам сумын Онцгой комиссоор дамжуулан зорилтот 90 өрхөд хүнсний тусламж үзүүллээ.

Сумын ерөнхий боловсролын 3-р сургуулийн хамт олон нийгмийн хариуцлагынхаа хүрээнд “Хүнс дүүрэн богц” аяныг өрнүүлэн хүнсний бүтээгдэхүүн, ахуйн хэрэглээ, түлээ нүүрс шаардлагатай хүүхдүүдийн судалгааг үндэслэн 35 өрхөд тусламж үзүүллээ.

Тус сард шинээр төрсөн 30 хүүхэд төрж өрхийн мэдээллийн санд бүртгэж ажилласан. 2019 онд өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдахаар шинээр хүсэлт ирүүлсэн 356 өргөдлөөс 351 өргөдлийг шийдвэрлэж 98.6 хувийн гүйцэтгэлтэй байсан бол тайлант сард нийт 94 өргөдөл бүртгэгдсэн байна. Судалгаанд хамрагдах хүсэлт гаргасан 85 өрхийн судалгааг авч өргөдлийг шийдвэрлэн 90.4 хувийн гүйцэтгэлтэй ажиллаж байна.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн мэдээллийн дагуу 10 кейст хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэн, 7 кейсийн асуудлын шийдвэрлэн ажиллалаа. Сум дундын цагдаагийн хэлтсээс ирсэн мэдээллийн дагуу хамтарсан багийн гаргасан шийдвэрийг гүйцэтгэж, үл хайхрах хүчирхийлэлд өртсөн 4 хүүхдийг сургууль хоорондын шилжүүлэг хийн дотуур байранд оруулах ажлыг зохион байгуулж, түр хамгаалах байранд байрлах бэлгийн болон бие махбодын хүчирхийлэлд өртсөн 3 хүүхдэд тогтмол сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг үзүүлэн хүүхэд тус бүрийн асуудалд өөр арга зүйн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Политехник коллежоос холбон зуучлагдаж ирсэн мэдээллийн дагуу үе тэнгийн дарамт шахалт, үл ойлголцолтой холбоотой асуудлаар хяналт хийн ажиллах шаардлагатай гэж үзсэн 1 оюутантай ганцаарчилсан сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.

Ширхэнцэг 2-р багт 40 айлын 2 орон сууц баригдаж ашиглалтад орлоо.

Сумын Засаг даргын Тамгын газрын барилгын дотор сантехник, 1-р давхрын угтах хэсэг, 3-р давхрын хурлын заалыг засварлалаа.

Төмөр замын 1-р багийн Вокзалын гудамжны асфальтан замын 2 талд 1 км авто замын хашлага, явган хүний зам барьж ашиглалтад орууллаа.

Дархан-Улаанбаатарын чиглэлийн авто замаас Сэлэнгэ аймгийн Мандал сум хүртэлх 28,9 км хатуу хучилттай авто замын ажил бүрэн дуусаж Улсын Комисст хүлээлгэн өгөхөд бэлэн боллоо.

Бүх нийтийн цэвэрлээ зохион байгуулж, байгууллага эзэмшил газрынхаа орчны 50 м хүртэлх талбайг цэвэрлэж, сумын төвийн доторх 16 км авто зам болон явган замыг цэвэрлэж, цэвэрлэгээнд 75 ААНБ-ын 680 албан хаагч оролцлоо.

Ковид-19 цар тахлаас хүн амыг урьдчилан сэргийлэх зорилгоор урьдчилан сэргийлэх ариутгалыг нийтийн эзэмшлийн 168.000 м<sup>2</sup> талбайд хийж халдваргүйжүүлж, 50 байрны орц, хонгил нийт 6603 м<sup>2</sup> талбайг гидохлорид кальци ариутгалын бодисоор ариутгал хийсэн. Байгууллага бүр ариутгал халдваргүйжүүлэлт тогтмол хийх, талаар мэргэжлийн байгууллагатай хамтран 82

ААНБ-д үүрэг, чиглэл өгч ариутгал халдваргүйжүүлэлт 12338 м2 нийт 35741 м2 хийж ажиллалаа.

Мал амьтан, тэдгээрийн түүхий эд бүтээгдэхүүний цахим гарал үүслийн гэрчилгээ 242, таримал ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүсэл 15 иргэн, ААНБ-д олгож ажиллалаа.

Хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичгийг 13 ААНБ, 23 нөхөрлөл, 116 иргэнд 1465 м3 түлээ олгож, хол хорионы үед ард иргэдийн түлээний хэрэгцээг хангах ажлыг зохион байгуулж 13 мод бэлтгэлийн аж ахуй нэгж байгууллагууд 992 м3 түлээний эрхийн бичиг авч эхний ээлжид 154 м3 түлээг татаж 22 айлд хөнгөлөлттэй үнээр буулгаж ажиллалаа.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 97 тоот 2305 тонн самар бэлтгэхээр тогтоолын дагуу 13 аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн зориулалтаар 655 тн, 31 иргэнд 7 эрхийн бичгээр 775 кг самар ахуйн зориулалтаар бэлтгэх зөвшөөрөл олгож ажиллалаа. 16 аж ахуй нэгж байгууллагын 252 тээврийн хэрэгсэл буюу ачааны 244, суудлын 8 техник хэрэгсэлтэй гэрээ байгуулж, 3608 хүнийг бүртгэсэн. Үүнээс эрэгтэй 3046, эмэгтэй 477 байна.

Хуш модны самар бэлтгэхээр зөвшөөрөл авсан 136 тээврийн хэрэгслийн жолоочтой гэрээ байгуулж, 1576 иргэн 136 тээврийн хэрэгслээс ойд зорчих тасалбар олгож төлбөр 1.794.0 төгрөгийг хураан авч төрийн санд төвлөрүүлэн ажиллалаа.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2020 оны 92, 18, 29-р тогтоолоор 432.8 га талбайд өөрийн хөрөнгөөр ойжуулалт хийхээр хуваарилсан 2 нөхөрлөл /хавар/, 13 аж ахуй нэгж байгууллага 158.1 га, /намар/ 10 аж ахуй нэгж байгууллага 182 га талбай буюу нийт 340.1 га талбайд ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүний дагуу 14 аж ахуй нэгж байгууллагын 127.5 га ойжуулсан талбайг 80.4 хувьтай хүлээн авсан.

Мандал сумын Байгаль орчин хяналтын тасаг нь байгаль орчны хяналтын улсын байцаагч 3, байгаль хамгаалагч 4 нийт 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”-ийн дагуу иргэдээс ирсэн гомдол мэдээлэл, хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд илрүүлсэн зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйд шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан Сум дундын прокурорын хяналтын прокурорт хянуулан ажиллаж байна.

11-р сард хууль бус мод бэлтгэл, ашигт малтмал олборлох, ан агнуур, хуш модны үр боргоцойг түүж бэлтгэх явдлыг таслан зогсоох чиглэлээр хяналт шалгалтыг 7 хоногийн 4 өдөр тогтмол зохион байгуулж, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль”-ийн хүрээнд 5 зөрчлийн шинжтэй үйлдэл бүртгэж ажиллалаа.

Мөнгөн усны хор хөнөөлийг олон нийтэд ойлгуулах зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвтэй хамтран сумын нутгийн удирдлагын ордны 1-р давхрын дотор танхимд 10-р сарын 27-31-ний өдрийн хооронд 5 хоногийн хугацаанд үзэсгэлэн зохион байгуулж ажиллалаа. Үзэсгэлэнг 150 төрийн байгууллагын ажилтан, албан хаагч, 250 орчим иргэд, 50 ерөнхий боловсролын сургуулийн сурагч, оюутан залуус, 180 алтны бичил уурхай эрхлэгчид, нийт 630 орчим хүмүүс үзэж сонирхсон байна.

Хүүхэд багачуудад байгаль, дэлхийгээ хамгаалах сэтгэхүйг төлөвшүүлэх үүднээс Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Цэнгэг усны нөөц, байгаль

хамгаалах төвтэй хамтран Мандал сумын 1,2,3,4-р ерөнхий боловсролын сургуулийн дунд 400 орчим дунд ангийн сурагчдад “Ногоон паспорт” аяны танилцуулгыг хүргэж, 120 ногоон паспортыг эзэмшүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.

### **Орхон сум:**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 178 тоот тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд сумын Онцгой комисс 11-р сарын 12-ны 05:00 цагт хуралдаж дараах шийдвэрүүдийг гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:

- Онцгой комиссын хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан гаргалаа.
- Сумын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд Covid-19 халдварт цар тахлын /өмнөх үед ажиллах, цар тахлын үед ажиллах, дараах үед ажиллах/ үед хэрхэн ажиллах талаар тодотгол хийж батлуулан ажиллаж байна. Бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан хүнсний худалдаа үйлчилгээ, түгээлтийн үйл ажиллагаа, эмнэлэг, эмийн сан, төрийн банк, шатахуун түгээх станц, харилцаа холбоо, худаг ус хангамж, шуудан холбоо, оршуулга буяны үйл ажиллагаанаас бусад төрийн байгууллагын үйл ажиллагааг тусгай горимоор ажиллуулж төрийн албан хаагчдыг гэрээсээ ажиллах нөхцлийг бүрдүүлэхийг байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг чиглэл болголоо.
- Бэлэндалай өртөөний гарам дээр гарах, орох хөдөлгөөнийг хязгаарласан хөдөлгөөнт эргүүл ажиллуулах,
- Сумын төв рүү орох, хаалга /хоньтой хөшөө/-д байнгын хяналтын цэг ажиллах,
- Хүнсний дэлгүүрүүд маскгүй иргэдэд үйлчлэхгүй байх,
- Төрийн албан хаагчид батлагдсан хуваарийн дагуу 09:00-20:00 цаг хүртэл хугацаанд эргүүл жижүүр хийх,
- Халдваргүйжүүлэлтийн баг, Хангалтын баг, Сэжигтэн тусгаарлах баг, Тусгаарлах баг, Хамгаалах багуудыг тус тус удирдлага зохион байгуулалтаар хангах,
- Хүүхдийн гадагш гарах хөдөлгөөнийг хорих, ЕБС-ийн багш, ажилчид сургуулийн захиргаа, эцэг эхчүүдтэй холбоотой ажиллах,
- Улс, аймаг, сумын Онцгой комиссын шийдвэрийг цахим орчинд шуурхай байрлуулан иргэдэд түргэн шуурхай хүргэх арга хэмжээг авах,
- Бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан дэлгүүр, төрийн болон төрийн бус байгууллага, нийтийн эзэмшлийн газруудад өдөр бүр халдваргүйжүүлэлт хийх,
- Байгууллагуудын дотоод орчинд хийх ариутгал халдваргүйжүүлэлтэд хяналт тавьж мэргэжил арга зүйгээр хангах,
- Байгууллагуудад шаардлагатай байгаа амны хаалт, халдвар хамгааллын хувцас, хэрэгсэл, хоол хүнсний тооцоо судалгааг гарган шаардлагатай тохиолдолд Засаг даргын Тамгын газраас шийдвэрлэх,
- Эм ороох боох материалын тооцоо судалгаа, тусгаарлах байруудын бэлтгэл бэлэн байдлын хангалтын талаар мэдээлэл бэлтгэх, дутагдалтай байгаа материал хэрэгслийг бэлэн болгох,
- Эмч, эмнэлгийн ажилчдын бэлтгэл бэлэн байдал, мэдлэг мэдээллийг сайжруулах, нэмэгдүүлэх зэрэг шийдвэрүүдийг гаргасан.

Мөн тогтмол утас /99411946/-ыг ажиллуулж, мэдээ мэдээлэл хүлээж авах, холбогдох дээд шатны байгууллагад дамжуулах үйл ажиллагааг эхлүүлэн ажиллаж байна.

Сумын Онцгой комиссын шуурхай штабын ажиллах хуваарь, төрийн албан хаагчдын хяналтын цэгт ажиллах хуваарь, байгууллагуудын эргүүл жижүүрээр ажиллах хуваариудыг батлан гаргаж, хяналтын цэгийг Бэлэндалай 42-р зөрлөг /хөдөлгөөнт/, сумын төв рүү орох хаалга /байнгын/-д байрлуулан төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний 1 албан хаагч, цагдаа, ЭМТ-ийн 1 ажилтан гэсэн бүрэлдэхүүнтэй, хоол хүнс, шатах тослох материал байрлах байрыг сумын ЗДТГ-аас шийдвэрлэн ажиллаж байна. Цахим орчинд сумын Онцгой комиссын шийдвэр болон Шуурхай штабын бүрэлдэхүүний утасны дугаар бүхий хуваарийг байрлуулан иргэдэд мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэн ажиллаж байна.

“Дэлхийн алхалтын өдөр”-ийг улс орон даяар зохион байгуулж байгаатай холбогдуулан /КОВИД-19/ цар тахлын үед ард иргэд, төр, төсвийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх дархлааг дэмжих зорилгоор “Алхангаа ярилцъя” арга хэмжээг сумын эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгуулж, төр, төсвийн 7 байгууллага ахмадын хороо, нэгдсэн уурын зуух зэрэг төрийн бус байгууллагууд оролцож удирдамжийн дагуу тэмцээн уралдаан, дасгал хөдөлгөөнийг зохион байгуулж эрүүл агаарт идэвхтэй хөдөлгөөн өрнүүлэн өнгөрүүлсэн.

“Монгол өрх” сэтгэл зүйн хүрээлэнгийн захирал сэтгэл зүйч Баасанбат Хамтарсан багийн гишүүдэд зөвлөгөө өгч, архины хамааралтай 1 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Орхонтуул сумын 3-р багийн нутаг “Хул азарганы тохой” гэх газраас “Эрин эрдэнэс” ХХК нь хууль бусаар газрын хэвлий хөндсөн зөрчилд Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан “Зөрчлийн тухай хууль”-ийн дагуу 1.500.0 төгрөг, Баруунбүрэн суманд үйл ажиллагаа явуулж буй “Шинэ Орос хийц” ХХК-д Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулан “Зөрчлийн тухай хууль”-ийн дагуу 500.0 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тус тус тооцож ажиллалаа.

Өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд Баруунбүрэн сумаас мод бэлтгэсэн 97 тээврийн хэрэгслийн 388 м3 модны тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж, өөрийн сумаас 60 иргэн 240 м3 улиас мод бэлтгэсэн байна.

“Орхон” үүлдрийн хонины 2020 оны хээлтүүлэг зохион байгуулалтын арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд “СҮЦСАА” ХХК-ын 300 толгой эм хонь, “Мангир трейд” ХХК-ий 260 толгой эм хонь бүгд 560 толгой эм хонинд зохиомол хээлтүүлэг явуулж 7 малчин өрхийн 1715 хонийг дур зоригийн хээлтүүлэгт хамруулж, хээлтүүлэгт “Орхон” үүлдрийн 9 хуцыг ашигласан. Зохиомол хээлтүүлгийн ажлыг 10-р сарын 20-ны өдрөөс 11-р сарын 01ний өдрийг хүртэл “СҮЦСАА” ХХК-ын үржлийн төвийн мэргэжилтэн ахмад мал зүйч Ц.Алтанцэцэг, хээлтүүлгийн техникч Ц.Ганцэцэг нар гүйцэтгэж ажиллалаа.

Сумын хэмжээнд 2020-2021 онд адуу 6303, үхэр 12341, хонь 44171, ямаа бүгд 41826 толгой мал өвөлжихөөр бэлтгэл ажлыг хангаж, өвөлжөөндөө буугаад байна. Нийт өвөлжих мал бүхий өрхийн тоо 399, малчин өрхийн тоо 199 байна.

Малын тооны төвшнөөр ангилж үзвэл 500 хүртэлх малтай өрх 322, 500-1000 хүртэл малтай өрх 64, 1000 дээш малтай өрх 13 байна.

Бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан хүнсний худалдаа үйлчилгээ, түгээлтийн үйл ажиллагааг хэвийн явуулах хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор тус суманд үйл ажиллагаа эрхэлж буй хүнсний 8 дэлгүүрийн гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгааг гарган ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/311 тоот “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэхийг түр хугацаанд хориглох тухай” захирамжийн хүрээнд архи худалдан борлуулдаг 3 дэлгүүрийн үйл ажиллагаанд хяналт тавьж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай 178 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг зохион байгуулж, ЗДТГ-ын гадна талбай, ЭМТ, Цэцэрлэг, Сургууль, Хаан, Төрийн банк, Сумын төвийн дэлгүүрүүд нийтийн эзэмшлийн зам талбайн 11610 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийгээд байна.

Орон нутгийн байгууллагуудын төсвийн санхүүжилтийн зарцуулалтын гүйлгээг батлагдсан төсвийн дагуу анхан шатны баримтыг үндэслэн 27912646.25 төгрөгийн гүйлгээг хийсэн. 2020 оны төсвийн гүйцэтгэлийн 10-р сарын мэдээг гаргаж /shilendans.gov.mn/ шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг байршуулан ажиллалаа.

Сумын ерөнхий боловсролын сургуулийн 1-5-р ангийн 5 бүлгийн 129 хүүхэд, 6-12-р ангийн 7 бүлгийн 133 хүүхэд, нийт 12 бүлгийн 262 суралцагчтай хичээл сургалтын үйл ажиллагаа явуулж байна. Байгууллагын ажил үүргийн хуваарийн дагуу ажил төрлийн яриа 1, захирлын дэргэдэх зөвлөл 2, хөл хорио тогтоосонтой холбоотой сургуулийн удирдлагын зүгээс багш ажилчдад цаг үеийн нөхцөл байдлын мэдээлэл хүргэх, ЗДТГ, Сумын онцгой комиссын шуурхай хуралдаанаас гаргасан мэдээлэл, шийдвэрүүдийг хүргэх, теле хичээл үзэж, сурагчидтайгаа эргэх холбоотой ажиллаж буй талаарх мэдээлэл солилцох, хариуцлагатай эргүүл жижүүрүүдэд санамж зөвлөгөө өгөх, онцгой нөхцөл байдалд хэрхэн хариуцлагатай ажиллах талаар үүрэг чиглэл өгөх зорилгоор 2 удаагийн онлайн хурал зохион байгуулж ажиллалаа. Сургалтын үйл ажиллагааны явцад байнгын цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийхэд шаардлагатай Байгаль орчин аялал, жуулчлалын сайд, Хүнс хөдөө аж ахуйн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2020 оны А/125, А-69, А/143 дугаар тушаалаар батлагдсан Монгол Улсад ашиглаж болох ариутгал, халдваргүйжүүлэх бодисын жагсаалтад бүртгэгдсэн гар халдваргүйжүүлэх болон цэвэрлэгээ үйлчилгээнд хэрэглэх бодис, шаардлагатай тохиолдолд хэрэглэх хувийн хамгаалах хувцас, хэрэгсэл (комбинзон, маск, бээлий, малгай, нүүрний хаалт, нүдний шил, гутлын улавч зэрэг), анхны тусламжийн эм, боолтын материал, биеийн халуун хэмжигч зэргийн нөөцийг бүрдүүлсэн. COVID-19 өвчний улмаас улсын хэмжээнд бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, бүх сургуулийн үйл ажиллагааг түр зогсоосонтой холбогдуулан сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн, ахуйн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын зөвлөмж, шторк, “Гараа угаая-маскаа

зүүе” 2-р аяны шторк зургийг сургуулийн нийгмийн ажилтан бэлтгэн олон нийтийн сүлжээнд байрлуулан ажиллаж байна.

1-р цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаанд “Дунд”, “Ахлах”, “Бэлтгэл” гурван бүлэгт 2-5 насны 94 хүүхэд “ТЕЛЕ” хичээл буюу цахим сургалтын үйл ажиллагаанд хамрагдахаас 68 хүүхэд тасралтгүй хамрагдаж, аймгийн Боловсрол, соёл урлагийн газраас зохион байгуулж буй “Гэртээ өөрийгөө хөгжүүлье” цахим уралдаанд нийт 15 хүүхэд оролцож байна. Цэцэрлэгт бүртгэлтэй хөгжлийн бэрхшээлтэй О.Содбаяр, Б.Түмэншагай болон өндөр настан иргэн П.Оюун нарт хоол хүнсний багц бүхий хүнсний дэмжлэг үзүүлж ажилласан.

А аминдэмийн витаминжуулалтад хамрагдах 222 хүүхдээс 150 хүүхэд хамрагдаж 67.5 хувьтай, өмнөх оны 11 сартай харьцуулахад 19.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэрийн эргэлтээр байнгын оршин суудаг 235 ахмад наснаас 95 ахмадыг хамруулж 40.4 хувьтай, өмнөх оны 11 сартай харьцуулахад 22,3 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Алсын дуудлага 18, ойрын дуудлага 47 байгаа нь өмнөх сараас алсын дуудлага багасаж, ойрын дуудлага ихэссэн байна. Сувилахуйн тусламж үйлчилгээг гэрийн асаргаанд байгаа 4 иргэн, ерөнхий сувилахуйн тусламж үйлчилгээг 3 нярай, 54 ахмад настан болон 4 хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ЭМС-ын 2017 оны А/41 тоот тушаалын дагуу 6 төрлийн асаргаа сувилгааг хийж, иргэдэд ээлтэй орчин бүрдүүлэн ажилласан. Хэвтэн эмчлүүлж буй 2, амбулаториор үйлчлүүлж буй 7, нийт 9 хүнд 4 төрлийн эмийн бус эмчилгээний тусламж үйлчилгээг үзүүлж, ЭМД-ын тусламж үйлчилгээнд 8 иргэнийг хамруулан ажиллалаа.

Коронавирусийн халдварын тархалт дэгдсэнтэй холбоотой хууль, тогтоол, тушаалын дагуу Шинэ коронавирусийн халдвараас сэргийлэх ажлын төлөвлөгөөнд 12 ажил арга хэмжээг нэмэлтээр төлөвлөн тодотгол хийж, тусгаарлах өрөө, эм тариа, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас хэрэгслийн бэлэн байдлыг ханган нөөцийг бүрдүүлэн, сумын ажиглах байрны бэлэн байдлыг ханган нөөцийг бүрдүүлэн захиалга хийн татан авалтыг хийн ажиллаж байна.

#### **Орхонтуул сум:**

Монгол Улсын Засгийн газраас гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Сумын Онцгой комиссыг 4 удаа, аймгийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулж буй online хурлыг 3 удаа хуралдуулан Улс орон даяар үүсэж буй цаг үеийн нөхцөл байдлын талаар мэдээлэл хийж, Засгийн газрын хуралдааны шийдвэр, Улс, аймгийн Онцгой комисс, аймгийн Засаг даргын шийдвэрийг тухай бүр танилцуулан ажиллаж байна. Сумын хэмжээнд коронавирус /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор төрийн албан хаагч 45, Эрүүл мэндийн төвүүдэд 33, Цагдаагийн хэсэгт 3, хүнсний дэлгүүрийн 14 худалдагч, банк нийт 13 ажилтан, “Туулын хишиг” ОНӨУҮГ-т 13, БАҮ 1-р ангийн нийт 26, Төмөр замын 4,5-р хэсгүүдэд 25 ажилтан, нийт 172 ажилтан байнгын ажиллагаатай ажиллаж байна.

11-р сарын 11-ний өдөр сумын Онцгой комиссоос гарсан тогтоолын хүрээнд сумын хэмжээнд коронавируст /covid-19/ цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах ажил, арга хэмжээ, 24 цагийн хариуцлагатай жижүүрийн хуваарийг батлан, ажиллуулж, иргэд олон нийтэд зөвлөмж мэдээллийг тогтмол хүргэж, иргэн бүр хариуцлагатай байхыг уриалан



ажиллаж байна. Сумын онцгой комиссыг шийдвэрээр автомашин, иргэдийн хөдөлгөөнийг түр хязгаарласантай холбогдуулан сумын төвд цагдаагийн хяналтын цэгийг тогтоож шуурхай штабын жижүүрийг 24 цагаар ажиллуулан, цагдаагийн постоор нэвтрэн гарч буй тээврийн хэрэгсэл болон иргэдийг бүртгэлжүүлэн ажиллаж байна.

Сумын онцгой комиссыг шийдвэрээр авто машин, иргэдийн хөдөлгөөнийг түр хязгаарласантай холбогдуулан сумын төвд цагдаагийн хяналтын цэгийг тогтоож шуурхай штабын жижүүрийн 24 цагаар ажиллуулан цагдаагийн постоор нэвтрэн гарч буй тээврийн хэрэгсэл болон иргэдийн бүртгэлийг хийж ажиллаж байна. Мөн сумын Онцгой комиссын шийдвэрийн дагуу худалдаа үйлчилгээ эрхлэгч 11 дэлгүүрт амны хаалтгүй иргэнд, сургуулийн насны хүүхдэд үйлчлэхгүй байх, худалдаа эрхлэгчид амны хаалт, нэг удаагийн бээлий, нөмрөгийг тогтмол өмсөж хэвших зэрэг зөвлөмжийг хүргүүлж, үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. Өдөр бүр өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгааг холбогдох газарт мэдээг хүргэж байна.

11-р сарын 16-ны өдөр архи согтууруулах ундааг худалдахыг хориглосон тухай А/116 тоот захирамжийн дагуу архи, согтууруулах ундаа худалдан борлуулдаг аж ахуйн нэгжүүдэд хяналт тавин хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Иргэд олон нийтэд энэхүү цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар мэдээ мэдээллийг тогтмол өгч онцын шаардлагагүй тохиолдолд гэрээсээ гаралгүй, орон гэр өрөө тасалгаандаа ариутгал халдваргүйтгэлийг сайтар хийж, биеийн дархлаагаа дэмжих хоол хүнсийг тогтмол хэрэглэж, улс, аймаг, сумын Онцгой комиссын шийдвэр, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яамнаас гаргасан заавар зөвлөмжийг сайтар хэрэгжүүлэн өөрийгөө болон гэр бүлээ хамгаалах талаар уриалгыг цахим орчноор дамжуулан хүргэж ажиллалаа.

Сумын төр, төсвийн 5 байгууллагын албан хаагчид иргэдэд “Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль”-иар сургалт зохион байгуулж, 62 иргэнийг хамруулан, тараах материал, мэдээлэл хүргэн ажиллалаа.

Нийгмийн даатгалын төвлөрсөн санд 1541.6 мян.төгрөг, ЭМД-ын санд 302.1 мян.төгрөг, Нийгмийн даатгалын СДД-д 3 малчин, 2 ажилгүй иргэн, тэтгэвэр 511 иргэнд 23110.7 мян.төгрөг, жирэмсэн амаржсаны тэтгэмж 1 иргэнд 991.5 мян.төгрөг, ажилгүйдлийн тэтгэмжид 1 иргэнд 619.6 мян.төгрөг олгож ажиллалаа.

Сумын хэмжээнд оны эхэнд 52 татвар төлөгчийн 64.1 сая.төгрөгийн урд оны өрийн судалгаа гарсан. Үүнээс өр барагдуулах шат дараалсан арга хэмжээг авч 42 татвар төлөгчийн 35.4 сая.төгрөгийг барагдуулан ажиллалаа. Татварын тухай хууль, түүнтэй холбогдуулан гарсан хууль, тогтоол, шийдвэрийг тогтмол цахим болон гарын авлага бэлтгэн иргэдэд хүргэн ажиллаж байна.

11-р сарын байдлаар Нийгмийн халамжийн сангийн халамжийн тэтгэврийг 92 иргэнд 26616,5 мян.төгрөг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй 67 иргэнд 6258.2 мян.төгрөг, онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 2 иргэнд 1245.6 мян.төгрөг, ахмад настны хөнгөлөлт тусламжид 4 иргэнд 540.0 мян.төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж хөнгөлөлт 4 иргэнд 560.0 мян.төгрөг, халамжийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлснээр 6 төрлийн үйлчилгээг цахимаар бүртгэсэн ба жирэмсэн

эхийн тэтгэмжид 3 эхийг шинээр хамруулж, нийт 24 эхэд 993.9 мян.төгрөг, цалинтай ээжийн тэтгэмжид 3 эхийг шинээр хамруулж, 154 эхэд 7581.6 мян.төгрөг, Алдарт эхийн 1-р одонгийн тэтгэмж 2 эхэд 200.0 мян.төгрөг, Алдар цолтой 2 ахмад настанд тусламж 300.0 мян.төгрөг олгож ажиллалаа.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 16 өрхийн 91 иргэнд 1792.0 мян.төгрөгийн хүнсний 10 нэр төрлийн бүтээгдэхүүнийг олгоод байна.

Шинэ ажлын байранд 21 иргэнийг бүртгэн, үүнээс байнгын ажлын байранд 7, улирлын чанартай ажлын байранд 1, түр ажлын байранд 13 иргэнийг бүртгэж холбогдох мэдээ тайланг дээд шатны байгууллагад хүргүүлж ажиллалаа.

Хөл хорионы улмаас эцэг, эх нь нийслэл болон өөр аймаг суманд хорионд орсон хүүхдүүдийн судалгааг гаргаж, эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа эцэг эх нь хорионд орсон 8 өрхийн хүүхдэд маск, гар ариутгагч болон хүнсний тусламж, сумын хэмжээнд амьжиргааны баталгаажих төвшнөөс доогуур орлоготой 5 өрхөд хүнс тэжээлийн тусламж үзүүлж ажилласан.

Сумын уугуул иргэн Герман улсад ажиллаж амьдарч буй Д.Хэрлэнцэцэг нь сумын онцгой комисст хүчилтөрөгчийн аппарат 2, халдвар хамгааллын хувцас 30 ширхэг хандивласныг сумын ЭМТ болон Рашаант тосгоны ЭМТ-д хүлээлгэн өгсөн. Сумын болон Рашаант тосгоны Эрүүл мэндийн төвөөс бэлтгэл, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд сумын ЗДТГ-ын буудалд 6 ортой, Рашаант тосгоны Соёлын төвд 8 ортой, ЭМТ-д 2 ортой, тусгаарлах байрыг тохижуулж, хуваарийн дагуу давхардсан тоогоор 50 байгууллагын 42231 м2 талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийж ажиллалаа.

Сумын Засаг даргын 2020 оны А/117 дугаар захирамжийн дагуу өөр аймаг, сумдаас отор нүүдлээр ирсэн малчдын Мал эмнэлгийн гэрчилгээг шалгаж гарал үүслийн бичиггүй ирсэн малчдад холбогдох арга хэмжээг авч ажилласан. Тус суманд Өвөрхангай, Төв, Булган аймгуудын сумдын 14 өрхийн 10484 толгой мал отор нүүдлээр ирээд байна.

11-р сард сумын Тусгай зориулалтын шилжүүлгээр санхүүжилт авдаг 6 байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 245.767.608,5 төгрөгийн төлбөр тооцоог анхан шатны бичиг баримтыг үндэслэн 247 ширхэг төлбөрийн хүсэлтээр 185 удаагийн хандалтаар ЗГУМС-д ажил гүйлгээг шивж баталгаажуулж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулж шуурхай удирдлагаар ханган ажилласнаар төсөвт байгууллагуудын шилэн дансны мэдээлэл цаг хугацаандаа, үнэн зөв, бүрэн мэдээлэгдсэн.

#### **Сайхан сум:**

11-р сарын 24-ний өдрийн байдлаар сумын Шуурхай штабт 5, хяналтын 2 цэгт 8, шуурхай штабын жижүүр 2, нийтийн болон хөдөлгөөнт эргүүлд 2 машин 7 албан хаагч, нийт 22 албан хаагч үүрэг гүйцэтгэн ажиллав. Суманд хөл хориог хатуу тогтоох үүднээс 11 хяналтын цэгт 24 албан хаагчид ажиллаж байна.

Улаанбаатар хот болон бусад аймаг сум руу зорчсон иргэдийн тандалт судалгаанд үндэслэн 11-р сарын 24-ний өдөр 28 иргэнд түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийгдсэн ба нийт 532 иргэнд шинжилгээ хийгдсэн хариу бүгд сөрөг гарсан байна.

Тус сумаас Улаанбаатар хот болон бусад аймаг, сум руу явах хүсэлтэй 69 иргэн, тус суманд ирэх хүсэлтэй 305 иргэдийн судалгааг гарган ажиллаж байна.

Сумын нийтийн эзэмшлийн 2952 м2 зам талбайд, явган хүний зам 3500м2, машины зогсоол 110 м2, хогийн сав 30, сандал 22 ширхэг, явган хүний гарц 14, мөн “Хөтөл өргөө” СӨХ 18 орцны 2800 м2 талбайд угаалга, ариутгал халдваргүйжүүлэлт хийж гүйцэтгэлээ. Хот тохижилтын газар 8 удаагийн ачилтаар 16.7 тонн хог тээвэрлэн, хогийн цэгт хүргэж ажилласан байна.

“Өвлийн идэш” арга хэмжээний хүрээнд өвлийн идэш бэлтгэх иргэдийн судалгааг өдөр бүр авч, эрсдэлт нөхцөлийг судлан, баруун 5 сумын Шуурхай штабтай зөвшилцөн, зохион байгуулалтын арга хэмжээг авч, хэрэгжүүлж байна. 11-р сарын 24-ний өдрийн байдлаар тус сумын 61 өрх, нийт 223 өрх өвлийн идшээ бэлтгээд байна. Мөн өдрийн байдлаар суманд малын мах 1.9 тн, гурил 7.3 тн, гурилан бүтээгдэхүүн 0.5 тн, төрөл бүрийн будаа 5.5 тн, хуурай сүү 0.1 тн, өндөг 9025 ширхэг, ургамлын тос 1.6 тн, төмс 7.5 тн, хүнсний ногоо 4.1 тн, элсэн чихэр 0.8 тн, давс 0.6 тн, савласан цэвэр ус 713л, үхрийн мах 820 кг, адууны мах 210 кг, хонины мах 367 кг, ямааны мах 20 кг нөөцтэй байна.

11-р сарын байдлаар байгаль орчны хяналтын чиглэлээр сум дундын цагдаагийн хэлтэстэй хамтран төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2 удаа, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2 удаа зохион байгуулж ажилласан. Хяналт шалгалтын хүрээнд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй ан амьтан агнасан 2 иргэнд, газрын хэвлийн ашигласан 1 иргэнд “Зөрчлийн тухай хууль”-ийн дагуу торгууль шийтгэлийн арга хэмжээ авч 1.100.0 төгрөгийг сумын хүү торгуулийн дансанд төвлөрүүлэн ажиллалаа.

Сумын өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 77 иргэний 285 м3 түлээний мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээний бичилт хийж, 66 иргэнд мод бэлтгэх эрхийн бичиг өгч ажиллалаа.

11-р сарын төсвийн байгууллагуудын төсвийн хуваарилалтын дагуу санхүүжилт олгогдож сарын төлбөр тооцооны 4413 ширхэг баримтаар 7,625,607,624.8 төгрөгийн гүйлгээг хийж гүйцэтгэсэн байна.

<b>Сайхан сумын Татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл</b>				
	<b>ҮЗҮҮЛЭЛТҮҮД</b>	<b>2020 оны батлагдсан төсөв</b>	<b>2020 оны 11-р сарын 25 байдлаар гүйцэтгэл</b>	<b>Хувь</b>
1	Нийт татварын ба татварын бус орлогын дүн	340,204,000.0	462,196,938.6	135.9
1.1	Хувь хүний орлогын албан татвар	110,000,000.0	156,039,699.76	141.8
1.1.1	Үйл ажиллагааны орлого	15,000,000.0	75,351,230.75	502.3
1.1.2	Хөрөнгө борлуулсны орлого	15,000,000.0	19,205,200	128
1.1.3	Хөрөнгийн орлого	80,000,000.0	67,438,269.01	84.3
1.2	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	3,060,000.0	1,630,250	18.9
1.2.1	Бууны албан татвар	3,060,000.0	1,630,250	18.9
1.3	Бусад нийтлэг татвар хураамж	139,744,000.0	266,258,669.92	148.5
1.3.1	Улсын тэмдэгтийн хураамж	20,000,000.0	28,553,997.72	142.7
1.3.2	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласан хураамж	75,000,000.0	201,164,492.20	268.2

1.3.3	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	44,744,000.0	36,540,180	81.6
1.4	Байгалийн нөөц ашигласны төлбөр	400,000.0	-	-
1.4.1	Ан амьтны нөөц ашигласны хураамж	-		
1.4.2	Байгалын ургамал ашигласны хураамж	-		
1.4.3	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	-		
1.4.4	Ойн нөөц ашигласны төлбөр	400,000.0		-
1.5	Нийтлэг татварын бус орлого	87,000,000.0	135,282,696.56	139.6
1.5.1	Хүү, Торгуулийн орлого	75,000,000.0	121,666,291.4	143.8
1.5.2	Нэр зааж ангилагдаагүй бусад орлого	12,000,000.0	13,616,405.16	113.4
1.5.3	Төсвийн байгууллагын өөрийн орлого	-		
1.6	Газрын төлбөр	-	9,200,000.0	
1.6.1	Газрын төлбөр	-	5,000,000.0	
1.6.2	Газрын дуудлага худалдаа	-	4,200,000.0	

Шилэн данс: Сумын хэмжээнд төр, төсвийн байгууллага, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төлөвлөгөө гүйцэтгэл, татварын орлогын биелэлт, Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийг сар бүрийн 8 дотор /Shilendans.gov.mn/-д шивж баталгаажуулан ажиллаж байна.

Коронавирусын халдварын үед сумын нөөц бүрдүүлэх зорилгоор Засаг даргын нөөц хөрөнгөөс 4.054.5 төгрөгийг гаргаж гамшгаас хамгаалах нөөцөд эмийн хангамж, ариутгал халдваргүйжүүлэлтийн бодис, 1 удаагийн хамгаалах хэрэгслийн татан авалт хийсэн.

Сум хөгжүүлэх сангийн зээл санхүүжүүлэх тухай А/178 захирамжийн дагуу 85.000.0 төгрөгийг 22 иргэнд олгоод байна. Сайхан сум дахь сум дундын шүүхийн эвлэрүүлэн зуучлах хэсэгт 7 иргэний материалыг хүргүүлснээс 1 иргэн зээлээ төлж барагдуулаад байна.

Сумын хэмжээнд 2020 оны 01 сараас 09-н сарын өссөн дүнгээр Нийгмийн халамжийн төсвийн зарцуулалт нийт 2125 иргэнд 748.627.010 төгрөгийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, тусламж хүүхдийн мөнгөнд 2591 хүүхдэд 259.100.0 төгрөгийн дэмжлэг үзүүлж ажиллалаа.

- Нийгмийн Халамжийн тэтгэвэр 115 иргэнд 278.792.490 төгрөг
- Нийгмийн Халамжийн тэтгэмж 116 иргэнд 92.800.730 төгрөг
- Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 49 ахмад настанд 9.998.870 төгрөг
- Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 34 ХБИргэнд 7.145.710 төгрөг
- Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж 21 байнгын асаргаатай хүүхдүүдэд 51.879.910 төгрөг
- Хүнс тэжээлийн дэмжлэг 45 өрхийн 269 иргэнд 41.944.000 төгрөг
- Алдар цолтой ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт 4 ахмадад 7.430.000 төгрөг

- Ахмад настанд үзүүлсэн хөнгөлөлт тусламж 229 ахмадад 29.488.000 төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн хөнгөлөлт тусламж 112 иргэнд 9.115.770 төгрөг
- 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 350 эхэд 123.392.990 төгрөг
- 5 сартайгаас эхлэн авдаг жирэмсэн эхийн тэтгэмж 136 эхэд 20.143.570 төгрөг
- Өрх толгойлсон эцэг, эхийн тэтгэмж 20 эцэг, эхэд 25.724.870 төгрөг
- Насны хишиг нийт 254 ахмадад 38.030.000 төгрөг
- 1, 2-р алдарт эхийн одонтой 429 ээжид 53.300.000 төгрөг
- 0-18 насны хүүхдийн мөнгөнд сумын хэмжээнд 2591 хүүхдэд 259.100.0 төгрөг
- Өрхийн амьжиргааг дээшлүүлэх зорилгоор 4 өрхийн 2.000.0 төгрөгийг олгож ажиллалаа.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Соёлын ордны түр ажиглах байрны бэлтгэл бэлэн байдлын бүрэн хангаж сумын шуурхай штабын зөвлөгөө, шаардлагын дагуу түр тусгаарлах өрөөнд байрлах орыг стандарт шаардлагын дагуу байрлуулан нэмэлтээр 2 өрөө гарган тохижуулан ажиллалаа. Улс орон даяар хөл хорио тогтоосонтой холбоотой багш нар гэрээсээ цахимаар ажиллаж, сурагчид 11-р сарын 11-ний өдрөөс эхлэн теле хичээлд хамрагдаж байна. 1082 сурагчийн 998 сурагч теле хичээлд хамрагдаж байгаа ба багш нар цахимаар сурагчидтай болон эцэг, эх, асран хамгаалагчтай холбогдон сурлагын хоцрогдол үүсгэхгүй байх тал дээр арга хэмжээ авч ажиллаж байна.

Тус сумын 1-р сургуулийн 2-р ангийн 113 сурагчаас 111 сурагч тайлант уншлага өглөө. Минутад уншиж байгаа дундаж үгийн тоо 53 байгаа ба ерөнхий гүйцэтгэлийн хувь 2а анги 96 хувь, 2б анги 93 хувь, 2в анги 92 хувь шалгагдаж дундаж нь 93.6 хувийн гүйцэтгэлтэй шалгагдлаа.

Бага насны хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, жирэмсэн эмэгтэй, хэвтрийн өвчтэй иргэнд тавих хяналтыг сайжруулж өрхийн эмч нар утсаар биеийн байдалд хяналт тавин ажиллаж байна. 11-р сарын 12-ны өдрөөс 349 хүнд зөвлөгөө өгч, /Ковид-19/-ын тухай зөвлөгөө мэдээлэл өгөх зорилгоор 99529237 дугаарыг ажиллуулж 28 хүнд нь гэрийн тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.

Ариутгал халдваргүйтгэлийг 60 байгууллага, аж ахуйн нэгжүүдэд 64 удаа нийт 14057 м.кв талбайд хийгээд байна.

Эмнэлгийн тусламж үйлчилгээг хэвийн явуулахын тулд ээлжийн ажилчдыг хуваарийн дагуу хэвээр нь ажиллуулж байна. Түргэн тусламжийн дуудлагын тоо хэвийн үеийнхээс 2-3 дахин нэмэгдсэн тул их эмч нарыг нэмэлт хуваарь гарган дуудлагад явуулан ажиллаж байна.

Д/д	Үзүүлэлт		11 сарын 20 хүртэлх мэдээ
1	Нийт үзлэг		2251
	Үүнээс	Урьдчилан сэргийлэх үзлэг	1452
		Өвчний учир амбулаторид үзүүлсэн	256

		Идэвхтэй хяналт	360
		Гэрийн үзлэг	183
2	Их эмчийн үзлэг		2037
3	Бага эмчийн үзлэг		224
4	Халдварт бус өвчлөл		37
5	Түргэн тусламжийн дуудлага		177
	Үүнээс алсын дуудлага		43
6	Эмнэлэгт хэвтсэн		74
7	Эмчлэгдэж гарсан		77
8	Ор хоног		514
9	Дундаж ор хоног		6.9
10	Орны фонд ашиглалт		11.6
11	Орны эргэлт		1.71
12	Нийт төрсөн эх		6
	Амьд төрсөн		6
13	Бүгд нас баралт		1
	Гэрийн нас баралт		1
14	Бүгд халдварт өвчин		4
	Гар хөл амны өвчин		4
15	Шинээр жирэмсний хяналтад орсон эх		8
	Нийт хяналтаас эхний 3 сартай орсон эхийн хувь		88 хувь
16	Лабораторийн шинжилгээ бүгд		630
	Үүнээс	Цусны ерөнхий шинжилгээ	213
		Цусны бүлэг тодорхойлох	14
		Шээсний ерөнхий шинжилгээ	229
		Үтрээний наац	49
		Сериологи	59
		Цэрний шинжилгээ	1
		Цагаан хорхойн шинжилгээ	42
		Иммунологи	23
17	Эмийн бус эмчилгээ		112
18	Вакцинжуулалт		33 хувь

### Сувилахуйн тусламж үйлчилгээн тоон үзүүлэлт 2020.11 сар

	Тасаг нэгж	Гэрийн эргэлт	Ерөнхий мэргэжлийн сувилахуйн тусламж үзүүлсэн	Утсаар зөвлөгөө өгсөн
Амбулатори				
1	Амбулаторийн тариа		328/давхардсан тоо/	
2	Амбулаторийн боолт		127 /давхардсан/	18
3	Дархлаажуулалт		60	
4	Яаралтай тусламж Дуудлага		23	
	Сувилахуйн тусламж		16	
5	Шүд кабинет		52	
6	Гэрийн эргэлт 1-р өрх	23		69

7	2-р өрх	9		45
8	3-р өрх	28		94
	<b>Нийт</b>	<b>60</b>	<b>706</b>	<b>226</b>
<b>Стацианор</b>				
		Хэвтэн эмчлүүлсэн	Ерөнхий сувилгаа	Төрөлжсөн сувилгаа
1	Дотрын тасаг	39	135	12
2	Хүүхдийн тасаг	13	92	18
3	Мэс заслын тасаг	5	28	3
4	Хөнгөвчлөх	1	7	1
5	Төрөх тасаг	10	12	10
6	Эмэгтэйчүүд	14		2
	<b>Нийт</b>	<b>82</b>	<b>274</b>	<b>46</b>

### **Сант сум:**

Сумын 2020 оны ургац хураалтын эцсийн мэдээгээр улаан буудай 1181 га-с 1454 тн, овьёос 10.5 га-с 36 тн, тосны ургамал 100 га-с 30 тн, төмс 217 га-с 2691.1 тн, хүнсний ногоо 202 га-с 2481 тн ургац хураан авсан. Үр тарианы тэжээлд шилжсэн 1443 га-с 1047 тн тэжээл хураан авсан байна. Сумын хэмжээнд нөөцлөгдөж байгаа төмс, хүнсний ногооны судалгаагаар төмс 115 тн, лууван 130 тн, байцай 9.5 тн, шар манжин 9 тн, сонгино 1 тн хадгалагдаж байна.

Бог малын хээлтүүлгийн ажлыг технологит хугацаанд нь зохион байгуулж хээлтүүлэгчийг эргүүлэн татан төвлөрүүлж гэрээгээр маллах 2 малчныг шалгаруулан Ивэн багийн малчин Ишжамц, Хушаат багийн малчин Адъяасүрэн нартай гэрээ байгуулан хамтран ажиллаж байна.

Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хурлыг зохион байгуулж 15 иргэний 136.5 сая төгрөгийн төслийг хүлээн авч хэлэлцэж, 10 иргэний 63.0 сая төгрөгийн төсөл дэмжигдэж, гэрээ байгуулан санхүүжилтийг олгож ажиллалаа.

“Дэлхийн алхалтын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Эрүүл мэндийнхээ төлөө-Алхангаа ярилцъя” арга хэмжээг зохион байгуулж, 5 байгууллагын 60 албан хаагч оролцлоо. Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлж, хувь хүн, гэр бүл, хамт олны эрүүл мэнддээ тавих хяналтыг сайжруулж, цар тахлын үед төрийн албан хаагчдыг идэвхтэй хөдөлгөөнд уриалж төрийн байгууллагын албан хаагчдын дархлааг дэмжин аминдэм, витаминжуулалт хийж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 178 дугаар тогтоол “Бүх нийтийг бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” шийдвэр, улс болон аймгийн онцгой комиссын шийдвэр, аймгийн Засаг даргын 2020 оны “Зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, бүх шатны боловсролын байгууллагын хичээл, сургалтын болон зарим төрлийн үйл ажиллагааг түр зогсоож, цагийн хязгаарлалт тогтоох тухай” А/306 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллах, үүрэг даалгаврыг бүх шатны төрийн албан хаагч, аж ахуйн нэгж байгууллагын дарга эрхлэгч нарт өгч ажиллаж байна.

Сумын онцгой комиссоос шуурхай штабын жижүүр, хариуцлагатай эргүүл, хяналтын постыг 24 цагаар ажиллуулж, аймгийн Онцгой комисс, Шуурхай штабт тайлан мэдээг хуваарийн дагуу мэдээллээ ажиллаж байна.

Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд хавьтлыг тусгаарлах байрыг сумын ЕБС-ын байранд 20 хүн тусгаарлах боломжтойгоор тохижуулан халдварын өндөр эрсдэлтэй, халдвартай, аюулгүй бүсээр ангилж бэлтгэсэн. Эмнэлгийн тусгаарлах байрыг улаан /халдвартай бүс/, шар /халдварын эрсдэлтэй бүс/, ногоон /халдварын эрсдэлгүй /бүсээр ангилж бэлэн байдлыг ханган ажиллаж байна. Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг эрчимжүүлж 15 удаагийн ариутгалаар 24 байгууллагын /давтан тоогоор/ 5917 м2 талбайд халдваргүйтгэл хийсэн.

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг өдөр бүр авч холбогдох байгууллагад мэдээлэн ажиллаж байна. Сүүлийн мэдээгээр хүнсний 7 дэлгүүрт мах 70 кг, гурил 190 кг, гурилан бүтээгдэхүүн 33.4 кг, төрөл бүрийн будаа 530 кг, хуурай сүү 41 кг, өндөг 0, ургамлын тос 89 литр, төмс 6760 кг, хүнсний ногоо 7690 кг, элсэн чихэр 130 кг, давс 82 кг, савласан цэвэр ус 257 литрийн нөөцтэй байна.

“Өвлийн идэш” арга хэмжээг хэрэгжүүлэн сумаас гадагш идэш явуулах иргэдийн захиалгыг 22 иргэнээс, мал борлуулах малчид, мал бүхий иргэдийн судалгааг дөрвөн БАХ, 26 малчин, мал бүхий иргэдээс авсан. Үүнд: адуу 31, үхэр 55, хонь 229, ямаа 262 бүгд 577 толгой мал борлуулахаас суман дотроо 2 адуу, 5 үхэр, 30 ямаа зуучлан борлуулаад байна.

Улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж хатуу хөл хорио тавигдсантай холбогдуулан тусламж дэмжлэг шаардлагатай зорилтот 42 өрхийн судалгааг гаргаж сумын эмэгтэйчүүдийн холбооноос санаачилж 83 иргэний тусламжаар бүрдсэн Foodbank хүнсний тусламжийг зорилтот 30 өрхөд хамтран хүргэж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/304 тоот Короновируст халдвар цар тахлаас урьдчилан сэргийлэх “Маскаа зүүцгээе, Гараа угаая” 2 дугаар аян зохион байгуулах тухай захирамжийн хүрээнд бүх төрлийн үйлчилгээний байгууллага, төсвийн байгууллагууд мөрдлөг болгон хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Суманд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын ажилтан албан хаагчийн амны хаалтын хэрэглээ 100 хувь, иргэдийн амны хаалтын хэрэглээ 100 хувьтай байна. Амны хаалтын хэрэглээнд сумын онцгой комисс, хариуцлагатай эргүүлүүд тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Хичээл сургалтын үйл ажиллагааг зогсоосонтой холбогдуулан хүүхдийг хүчирхийлэлд өртөхөөс сэргийлэх, хяналт тавих, хүүхдүүдтэй харилцах, сэтгэл зүйг тандах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг сургуулийн захирал, нийгмийн ажилтан нарт үүрэг болгож, анги удирдсан багш нар зөвлөгөө зөвлөмжийг утсаар болон цахимаар өгч ажиллаж байна.

11-р сарын байдлаар ЕБС-ийн 314 суралцагчаас 240 суралцагч, цэцэрлэгийн 4 бүлгийн 118 хүүхдээс 69 хүүхэд теле хичээлд тогтмол хамрагдаж байна.

Тус сард сумын хэсгийн төлөөлөгчид гэр бүлийн хүчирхийллийн 3 дуудлага ирсэн бөгөөд зөрчил хянан шалгах хугацаанд 3 гэр бүлд гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлын үнэлгээ хийж зөвлөгөө өгөн ажилласан. Мөн үл хайхрах төрлийн хүчирхийлэлд өртсөн 1 хүүхдийн зөрчлийн мэдээллийг хүлээн авч сургуулийн нийгмийн ажилтан, ангийн багш, эцэг эхэд зөвлөгөө өгч сургуулийн нийгмийн ажилтан кейс нээн ажиллаж байна.



Сумын Эрүүл мэндийн төвөөс сумын төвийн болон алслагдсан багийн 56 өрхийн 358 иргэнд үзлэг хийж зөвлөгөө өгч ажилласан. Эрүүл мэндийн яамны зөвлөмжийн дагуу 0-15 хүртэлх насны хүүхдийн товлох вакциныг 25 хүүхдэд гэрээр хийж хяналт тавьж ажиллалаа.

#### **Сүхбаатар сум:**

Аймаг, нийслэл, сум, дүүргийн 2020 оны ээлжит сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаан хуралдаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн бүрэн эрхийг баталгаажуулан, Ганбаатарын Амарбаясгаланг 20 төлөөлөгчийн саналаар буюу сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар сонгогдлоо. Мөн дэгийн дагуу саналыг нууцаар авч сонгуулийн үр дүнд нэр дэвшигч Т.Гантулга 26 санал буюу 86.6 хувь, нэр дэвшигч Л.Ганболд 4 санал буюу 14.4 хувь тус тус санал авч, дарга Г.Амарбаясгалан сумын Засаг даргад Түмэн-Өлзийн Гантулгыг нэр дэвшүүлэхээр тогтоолын танилцуулж Төлөөлөгчид 100 хувийн саналаар баталлаа.

Аймгийн хилийн мэргэжлийн хяналтын албатай хамтран сумын шуурхай хурлыг зохион байгуулж, уг хурлаар ОХУ-д халдварын тархалт ихсэж байгаатай холбогдуулан Олон Улсын транзит тээврээр орж ирж буй Сүхбаатар суманд үйл ажиллагаа эрхэлж байгаа гаалийн хяналтын бүсэд гуалин, зүсмэл мод, модон материал болон ачаа барааг сэлгэн ачиж буулгах компани үйл ажиллагаа эрхэлж байна эдгээр газруудад хяналт шалгалт хийх талаар хэлэлцлээ.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан 11-р сарын 12-ны өдрөөс эхлэн сумын шуурхай штабт 24 цагаар 13, нийт 58 ажилтан албан хаагчид ажиллаж байна.

Тусгаарлах 11 байранд нийт 264 иргэн байрлаж байна. Үүнээс зөөврөөр 5 байранд хоол хүргэлт хийж байна. 6 байр нь дотроо гал тогоотой үйл ажиллагаа явуулж байна. Нөөцөд тусгаарлах 16 байр байна. Тусгаарлах байруудад ариутгал халдваргүйтгэлийг тогтмол хийн ажиллаж байна.

Сумын хэмжээнд 22626 хүн шинжилгээнд хамрагдахаас өнөөдрийн байдлаар 85 хувийн хамрагдалтай байна.

Нийтийн эзэмшлийн 72 байрны 144 орц, нийтийн эзэмшлийн зам талбайн нийт 95000 м2 талбайд бүрэн ариутгал халдваргүйтгэл хийж ажиллалаа.

Сүхбаатар сумын албан ёсны цахим хаягаар 764 удаагийн давтамжтай мэдээ мэдээлэл, зөвлөмж, сэрэмжлүүлгийг ард иргэдэд хүргэж ажиллаж байна.

Холбогдох мэдээ мэдээлэл болон судалгааг тогтмол авч, дээд шатны байгууллагад хүргэн ажиллаж байна.

#### **Түшиг сум:**

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаан 10-р сарын 30-ны өдөр болж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар төлөөлөгчдийн дийлэнх олонхын саналаар С.Түвшинбаяр сонгогдож, төлөөлөгчдийн 80 хувийн саналаар Г.Батболдыг сумын Засаг даргад нэр дэвшүүлж аймгийн Засаг даргад уламжиллаа.

2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд иргэдээс санал авах үйл ажиллагааг зохион байгуулж, нийт 80 гаруй иргэнээс санал авч ажиллалаа.

Соёлын төвтэй хамтран малчин залуучуудын дунд “Адуучин” морь уургалах, бугуйл шүүрэх, эмнэг сургах тэмцээнийг зохион байгуулж, 25 иргэн

оролцож, малчин болон мал бүхий иргэдийн адууны тамганы хэвийг “Орон нутаг судлах танхим”-д хадгалах, иргэдэд таниулах зорилготойгоор зохион байгууллаа.

Сумын Улаан Загалмайн анхан шатны хорооны ээлжит хуралдааныг зохион байгуулж, 2016-2020 онд хийсэн ажлын тайлан мэдээллийг сонсож хэлэлцлээ.

Дэлхийн алхалтын өдрийг тохиолдуулан “Эрүүл мэндийнхээ төлөө-Алхангаа ярилцъя” уриа дор төрийн байгууллага, иргэдийн дунд буухиа тэмцээнийг явуулж, нийт 53 иргэн оролцлоо.

Улаанбаатар хотод Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хамтарсан багаар 3 хоногийн хугацаатай ажиллаж, 1 иргэнийг авчирч, ар гэрт нь хүлээлгэж өгөх, тусламж үзүүлэх ажлыг зохион байгууллаа. Тайлант сард хамтарсан багийн хурлыг 3 удаа зохион байгуулсан байна.

Шинэ төрлийн коронавирусээс урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг сумын хэмжээнд төлөвлөж, сумын Засаг даргын 98 тоот захирамжаар Бүх нийтийн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, сумын Онцгой комиссоос шуурхай штабыг 24 цагаар ажиллуулж, 36 төрийн албан хаагч ажиллаж байна.

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй МЭҮН-үүд өдөр бүр худалдаа үйлчилгээний байгууллагууд, Төрийн болон Хаан банк, нийтийн эзэмшлийн гудамж талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийн ажиллаж байна.

Сумын төв руу орох Үзүүр хошуунд хяналтын цэгийг ажиллуулж өдөр бүр 2 албан хаагчийг 24 цагаар ээлжээр ажиллуулж, сумын төв рүү орох, гарах хөдөлгөөнийг бүрэн хязгаарлаж, Улаан-Овоо нүүрсний уурхайгаас нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулж буй “Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ-ын тээврийн хэрэгслийн ариутгал халдваргүйтгэлийг хийн явуулж байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж байгаатай холбогдуулан төрийн байгууллагуудыг тусгай горимд шилжүүлэн ажиллуулж, албан хаагчдыг гэрээсээ ажиллах нөхцөлийг ханган ажиллаж байна.

Сумын Засаг даргын 2020 оны А/99 тоот захирамжаар сумын хэмжээнд архи, согтууруулах ундаа худалдан борлуулах үйл ажиллагааг хязгаарлаж, хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Орон нутгийн худалдааны байгууллагуудын өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний нөөцийн судалгааг өдөр бүр авч, хүнс татан авалтыг Дархан-Уул аймгаас зохион байгуулж байна. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар суманд мах тээвэрлэлтийн эрх бүхий 2 иргэний үйл ажиллагаанд хяналт тавьж, сумаас нийт 74 толгой малыг нийлүүлэн ажиллалаа.

Сумын эрүүл мэндийн төв нь амбулатороор 185, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэгт, гэрийн идэвхитэй эргэлт 82 буюу 44.3 хувь байна. Эмнэлэгт 5 хүнийг хэвтэн эмчлүүлж, нарийн мэргэжлийн эмчийн хяналтад 1 эхийг шилжүүлэн төрүүлж, жирэмсний хяналтад 4 эхийг шинээр авсан. Алсын 6, ойрын 45 дуудлагад үйлчилж, 20 гаруй иргэнд утсаар зөвлөгөө өгсөн.

0-5 насны хүүхдийн заавал хамрагдвал зохих дархлаажуулалтыг гэрийн эргэлтээр үзүүлж товлох дархлаажуулалтад 52 хүн тун хамрагдаж, урвал хүндрэл гараагүй.

### **Хушаат сум:**

Орхон голын гүүрэн дээрх хяналтын цэг, шуурхай штабын жижүүрийн хуваарь, Ишгэнт постын жижүүрийн хуваарь, бүх нийтээр бэлэн байдалд шилжих үед сумын Онцгой комиссоос хийх ажлын төлөвлөгөө, сумын төвийг 4 хэсэгт хуваан ажиллах ажлын төлөвлөгөө, захирамж 3, төсөв зардалтай холбоотой 2, Коронавируст халдвараас хамгаалах бэлэн байдал хариу арга хэмжээ төлөвлөлт 1, албан тоот 8, тодорхойлолт 6 болон бусад үүрэг чиглэлүүдийг өгч удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаж байна. Сумын Засаг даргын А/ 127 тоот “Коронавирусын халдварын тархалтыг зогсоох ажиллагаанд төсвийн зохицуулалт хийх, дэмжлэг үзүүлэх тухай” тоот захирамжийг батлан гаргаж санхүүгийн зохицуулалтыг хийлээ. Сумын нутаг дэвсгэрт хүнсний нөөц бүрдүүлэлт, эрүүл ахуй, үйлчилгээ, үнэ ханшид хяналт тавих ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, 5 дэлгүүрээр орж үнийн судалгаа хийж ажиллалаа.

Багийн Засаг дарга нар хөл хорионы үеэр түлээ, хүнсний хомсдолд орж болзошгүй өрхийн судалгааг гарган комиссын хурлаар хэлэлцүүлж хямдралтай үнээр 5 тн нүүрс, хандиваар ирсэн мал, махыг 42 өрхөд 126 шуудай нүүрсийг хөнгөлөлтэй үнээр олголоо.

Хөл хорионы дэглэмийн үеэр сумын 3 байгууллага, 1 малчны бүлэг, 11 иргэн 10 хонь, 10 ямаа, 2 үхэр, 50 литр сүү, 20 кг аарц, 3 кг чацаргана, 1 кг улаалзгана, 40 кг лууван, 50.000 төгрөгийн үнэ бүхий сироп, 1.200.0 төгрөгийг сумын Онцгой комисс, ЭМТ, Цагдаагийн хэсэг болон олон хүүхэдтэй, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрх, ахмад настнуудад хандивлалаа.

Хушаат сумын Онцгой комиссоос авч хэрэгжүүлэх коронавируст халдварын цар тахлын хариу арга хэмжээний төлөвлөгөөтэй холбогдуулан нийтийн эзэмшлийн зам талбай, худалдаа үйлчилгээ эрхэлдэг аж ахуй нэгж, ШТС-ын гадна талбай, төсвийн байгууллагууд нийт 14 хоногийн хугацаанд 24281.6 м<sup>2</sup> талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийгээд байна.

“Ард иргэдийн анхааралд” санамж хуудсыг 8 байгууллага, 10 самбар, 32 иргэнд, “Хайртай хүмүүсийнхээ төлөө гэртээ байцгаая” “Иргэн та хүнс, эм, эрүүл мэндийн үйлчилгээ бусад тохиолдолд гэрээ гарахгүй байна уу”, “Бүхний төлөө гэртээ байцгаая” 3 цуврал зэрэг нийт 6 төрлийн сурталчилгааны хуудсыг нийт 24 хуудас, ЭМЯ-аас бэлтгэн гаргасан “Ковид-19 өвчнөөс урьдчилан сэргийлье” 2 төрлийн сурталчилгааны хуудсыг 6 хуудас нийт 30 хуудас сурталчилгааны хуудсыг 13 байрлалд байрлуулж иргэдэд сурталчлан ажиллаж байна.

Орхон голын хяналтын постод 14 албан хаагч, Ишгэнт дэх постод 8 албан хаагчийг томилон хуваарийн дагуу 24 цагаар, хариуцлагатай жижүүрээр 6 албан хаагч, эргүүл хийх 9 албан хаагчийг томилон хуваарийн дагуу ажиллаж мэдээ цуглуулж мэдээлэх, сумын төвийн хэв журмыг сахиулах ажлыг гүйцэтгэж байна.

Ургац хураалт, хадлан тэжээлийн эцсийн мэдээ 11-р сарын 25-ны өдрийн байдлаар сумын хэмжээнд улаан буудай 12634.5 тн, арвай 424 тн, овьёос 1057 тн, гурвалжин будаа 467 тн, таримал тэжээл /ногоон тэжээл 2040.5 тн, бусад 17 тн/ техникийн ургамал буюу тосны ургамал 1359 тн, бэлтгэсэн өвс 12885 тн, төмс 3273 тн, хүнсний ногоо нийт 1977.002 тн/ үүнд байцаа 165.7 тн, лууван 1303.6 тн, шар манжин 178.4 тн, хүрэн манжин 19.4 тн, сонгино 104.4 тн, сармис 0.7 тн, өргөст хэмс /урт/ 18.78 тн, өргөст хэмх /давжаа/ 10.6 тн, улаан лооль 3.57 тн,

тарвас 168.6 тн, хулуу 0.65 тн, брокли 0.052 тн, бууцай 0.03 тн, юуцай 0.04 тн, бусад ногоо 2.48 тонны хураалтыг 381 өрх, 30 ААНБ-аас мэдээг авч хугацаанд нь программд шивж ажилласан.

Шинээр 2 иргэн галт зэвсгийн албан татвар төлөгчөөр нэмж бүртгүүлж, төлөвлөгөөний гүйцэтгэл 2020 оны 11-р сард өссөн дүнгээр улс 30.689.0-68305.2 189.8 хувь, аймаг 202.005.8-129.189.8 буюу 64 хувь, сум 36.630.3-88.530.8 буюу 223.4 хувийн биелэлттэй байна. 7 аж ахуй нэгжид татварын өр төлүүлэх мэдэгдэл хүргүүлж, 3 аж ахуй нэгж бүрэн барагдуулж ажиллалаа.

Орон нутгийн татварын ба татварын бус орлогын 11-р сарын орлогын төлөвлөгөө нь өссөн дүнгээр 55383.4 мян.төгрөг, гүйцэтгэл нь өссөн дүнгээр 74825.3 мян.төгрөг нийт гүйцэтгэлийн хувь 135.1 хувьтай байна.

Коронавирусын цар тахлын үед бөөгнөрөл үүсгэхгүй байх зорилгоор 7 хоногт 2 удаагийн давтамжтайгаар төсөвт байгууллагын төлбөр тооцоог гүйцэтгэн ажиллаж байна. Төсөвт байгууллагын хүнсний нөөцийг тодорхойлж тооллого хийхэд цэцэрлэг 1427170 төгрөгийн хүнс, ЕБС 460000 төгрөгийн хүнсний үлдэгдэлтэй байсныг тоолж, холбогдох баримтыг бүрдүүлж ажиллалаа.

Нийгмийн даатгалын шимтгэлд 5 байгууллага, 29 аж ахуйн нэгжийн 356887.9 мян.төгрөг, нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч 127 иргэний 28106.4 мян.төгрөг шимтгэл, эрүүл мэндийн заавал даатгалд 141 иргэний 8751.7 мян.төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэн ажиллалаа. Шинээр тэтгэвэр тогтоолгохоор 40, шилжиж ирсэн 2иргэний материалыг хүлээн авч баталгаажуулан олгож, шилжин явсан 5 иргэний материалыг шилжүүлсэн. Тэтгэвэр тогтоолгох талаар зөвлөгөөг 256 иргэнд, эрүүл мэнд болон нийгмийн даатгалд сайн дураар даатгуулах зөвлөгөөг 686 хүнд өгч ажиллалаа.

Хамтарсан багийн хурлыг 2 удаа хуралдуулж, 3 кейст хувийн хэрэг нээн холбогдох арга хэмжээг авч, архины хамааралтай 1 иргэний ар гэрийн байдалд нөхцөл үнэлгээ хийж, хууль эрх зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн Хүдэр суманд хөл хорионд орсон 1 иргэний эцэг эхийн хараа хяналтгүй үлдсэн сургуулийн насны 4 хүүхдүүдийг ойрын хамаатан, садан төрлийн айлд нь хүлээлгэн өгч гадуур гарахгүй байх талаар зөвлөмж өгч ажиллалаа.

Шинэ ажлын байранд байнгын 23, улирлын 9, түр 8 нийт 40 иргэнийг хамруулж, ажлын байр зуучлалд 34 иргэн хамрагдсан байна.

Халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 11-р сард 182 иргэнд 19.778.500 төгрөгийг олгож ажиллалаа.

Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яамнаас гаргасан “Маскаа зүүе-Гараа угаая” 2 аяны хүрээнд бүлгийн хүүхдүүд аянд нэгдэж, өглөө бүр багш нар эцэг, эх, асран хамгаалагчдад маскаа зүүхийг зөвлөж “Угтах үйлчилгээ”-г явуулан ажиллаж байна.

11-р сард хамран сургалт 2100 хүүхэд хүлээн авахаас эхний 7 хоногийн байдлаар бүлгүүд:

№	Бүлэг	Ирвэл зохих	Ирсэн	Хувь
1.	Бага	525	172	33%
2.	Дунд	525	88	17%
3.	Ахлах	525	67	13%
4.	Бэлтгэл	525	102	19%
5.	Нийт дүн	2100	429	20%

Хичээл сургалтын үйл ажиллагааг танхимын бус хэлбэрээр цахимаар явуулах, хуваарийн дагуу теле хичээлд хамруулах талаар багш, эцэг, эх холбогдон ажиллаж байна. Мөн хүүхдээ аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хараа хяналтгүй орхихгүй байх талаар зөвлөмж, анхааруулга өгөн ажиллаж байна.

Цэцэрлэгийн багш нар нэгдэн нийгмийн хариуцлагын хүрээнд ахмад настан 4, зорилтот бүлгийн 4 айлын 8 хүүхэд, 2 иргэнд аарц, чацарганы шүүс, төмс хүнсний ногоо, сүү зэрэг 150.0 төгрөгийн хандив тусламж өгсөн.

Сум хөгжүүлэх санд 11-р сард 1050,000 төгрөгийн эргэн төлөлт хийгдэж, эргэн төлөлт хийгдэхгүй байгаа иргэдэд утсаар болон мэдэгдэл хүргэж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 178 тоот тогтоол, Мал эмнэлгийн Ерөнхий газрын 01/1205 албан тоотын дагуу мал эмнэлгийн гэрчилгээг цагийн хязгаарлалтгүй, түргэн шуурхай олгон ажиллаж байна. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн 11-р сарын 12-ны өдрөөс хойш 22 гэрчилгээ бичигдэж адуу 11, хонь 200, ямаа 517 толгой малд, мал амьтны бүтээгдэхүүн үхрийн мах 2000 кг, хонины мах 80 кг, 10.000 литр сүүнд мал эмнэлгийн гэрчилгээ бичиж ажиллалаа.

#### **Хүдэр сум:**

Сумын Онцгой комиссын хурлыг 11 дүгээр сарын 9-ний өдрөөс хойш 17 удаа хийж, Улсын Онцгой комисс, аймаг, сумын албан даалгавар, тогтоол, захирамж, шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, зохион байгуулалтын арга хэмжээг авч, гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг гарган, үүрэг өгч ажиллаж байна. Сумын Онцгой комиссын гишүүдийн Хариуцлагатай жижүүрүүд хуваарийн дагуу 24 цагаар ажил үүргийг гүйцэтгэж байна.

Тус суманд өөр аймаг сумдаас нийт барагцаалсан тоогоор ууланд самар түүхээр 600-700 орчим иргэд байна. 11-р сарын 13-ны өдөр 3 албан хаагчийг самар түүж буй иргэд рүү явуулж зохих мэдээллээр хангаж, зохих шаардлага тавьж нөхцөл байдалтай танилцаж, хатуу хөл хорионы үед улнаас иргэдийг бууж ирэхгүй байх талаар анхааруулга, зөвлөмж өгч, өнгөрсөн өдрүүдэд 12 машинаар хоол хүнсний материалыг хүргэж ажиллаад байна.

Хатуу хөл хорио тавих талаар худал мэдээллээр уулнаас хүмүүс бөөнөөр орж ирсний улмаас сумын төвд иргэдийн бөөгнөрөл үүсэж, суманд буудал, байр савны нөөц хангалтгүй, таних айл хүнгүйгээс айлын өвөлжөө, зуны сараа зэрэгт иргэд байрлаж байна.

Сумын Онцгой комисст иргэн В.Цэрэнсүрэн 50 ш маск, 2 хайрцаг ариутгагч бодис, иргэн н.Гандэлгэр нүүрэвч маск 15ш, “Хүдэр од” маркет 192.200 мян.төгрөгийн хүнс, аймгийн ИТХ-ын төлөөлөгч П.Батсайхан 200.0 мянган төгрөг, Сумын бөхийн холбоо 1 хонь, 1 ямаа, иргэн А.Хүдэрхуяг, н.Цогтжаргал нар 1 гулууз хонины мах, иргэн Д.Наранчимэг 1 өдрийн хоол, Хөдөлмөрийн баатар С.Ганболд 500.0 мян.төгрөг, иргэн Г.Энхтайван 100.0 мян.төгрөг тус тус хандивласан байна.

Худалдаа үйлчилгээний газрууд, нийтийн эзэмшлийн зам, буудал, хүнсний дэлгүүр, мини маркет, зоогийн газар, мах сүү цагаан идээний дэлгүүр, ундны ус түгээх худаг, банк зэрэг нийт 19 цэгт 1870 м<sup>2</sup> талбайд ариутгал

халдваргүйжүүлэлт хийж, нүхэн гүүрний постоор орж, гарч буй тээврийн хөдөлгөөнийг ариутгах ажлыг хийж гүйцэтгэж байна.

Онцгой комиссын шийдвэрээр сумын онцгой комиссын гишүүдэд амны хаалт 160, резинэн бээлий 25 ширхэг, жавелин 2 хайрцаг, ЭМТ-д нэг удаагийн маск 3000, хос бээлий 850, нэг удаагийн хувцас 18, хормогч 40, нүдний шил 11, нүүрний хаалттай маск 31 ширхэг, ариутгалын бодис 1.2 литр, усны гутал 18 хос өгч нөөц бүрдүүлэн ажиллалаа.

11-р сарын 17-ны өдрийн хуралдаанаар Хамгаалалтын хувцас, маск, ариутгалын бодисын нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, холбогдох байгууллагатай хамтран санхүүжилтийг шийдвэрлэх шийдвэр гарсны дагуу нэг удаагийн хувцас 60, маск /нэг удаагийн/ 4500, N25 шүүлтүүртэй маск 20, малгай 50, нүдний шил 9, бээлий 2000 ширхгийг тус тус авч 2.500.0 мян.төгрөг, эргүүл шалгалт постын зардалд 1.300.0 мян.төгрөг тус тус зарцуулсан байна.

Төр, төсвийн албан хаагчид цахим хэлбэрээр төрийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Төрийн үйлчилгээний Хур системээр 11-р сард 27 иргэнд цахим үнэмлэхийн лавлагаа 18, жолоодох эрхийн лавлагаа 3, даатгал 3, хууль сахиулах 2, бүртгэл 1 иргэнд лавлагаа өгч ажилласан байна.

Энэ сарын татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл 11-р сарын 23-ний өдрийн байдлаар нийт сарын дүнгээр 556669.6 мян.төгрөг төвлөрүүлэхээс гүйцэтгэл 78455.8 мян.төгрөг төвлөрсөн байна. Урд оны өртэй 2 татвар төлөгчөөс 1158.0 мянган төгрөгийн өр барагдуулж ажиллав.

Орон нутгийн орлогын төлөвлөгөө 11-р сарын байдлаар 19938.6 мян.төгрөг батлагдсанаас 23108.9 мян.төгрөг орж орлогын төлөвлөгөө өссөн дүнгээр 115.9 хувь биелсэн байна.

Ковид-19 вирустэй холбоотойгоор ариутгал, халдваргүйжүүлэлт, постын хоол, шатахууны зардалд нийт 1200.0 мянган төгрөг зарцууллаа. Сум хөгжүүлэх сангаас зээл эргэн төлөлтийг 11-р сарын байдлаар 3 иргэнээс зээлийн хүү, алданги тооцож 1800.0 мян.төгрөгийн орлого орсон дүнтэй байна.

Сумын хүн амд эмнэлгийн тусламж үйлчилгээг стандартын дагуу чанартай үзүүлж иргэдээс гомдол санал гаргалгүй ажиллаж байна. Тус сард Эрүүл мэндийн төвөөр 11 төрлийн шинжилгээнд 318 иргэн хамруулж, давхардсан тоогоор 545 иргэн үйлчлүүлсэн байна.

Дархлаажуулалтад хамрагдвал зохих 62 хүүхдийг, түр оршин суугчдын 3 хүүхдийг бүртгэн авч дархлаажуулалтад хамрууллаа.

Вакцины нэр	Хийсэн хүн тун			Бүгд
	I	II	III	
Саа өвчний эсрэг уудаг вакцин	11	8	11	30
Тавт вакцин	9	7	9	25
Хатгалгааны эсрэг вакцин	11	8	11	30
Идэвхгүйжүүлсэн саа өвчний эсрэг вакцин	13			13
Улаан бурхан,гахайн хавдар,улаануудын вакцин	13	2		15
Гепатит “А” вакцин	15	2		17
БЦЖ	0			0
Гепатит “В” вакцин	0			0
Галзуугийн эсрэг вакцин		1	1	2
Сахуу,татрангийн вакцин	6	4		10

Эмч эмнэлгийн ажилчдыг улирлын томуу өвчний вакцинд 17 хүнийг хамрууллаа.

“Боловсролын салбарын хүүхэд хамгаалал- эцэг эхийн оролцоо” сургалтад 22 багш ажилтныг хамрууллаа.

Тус сард халамжийн сангаас 8 төрлийн үйлчилгээгээр 161 иргэнд 179251720 төгрөгийн санхүүжилт олгоод байна. 09,10,11-р сард банкны данс зөрүү, ХУР системээс зогсоосон, бусад шалтгааны улмаас нөхөн олголт хийх боломжгүй байсан нийт 19 иргэний 1194.665 мянган төгрөгийг нөхөн олгохоор болсон.

Амьжиргааг дэмжих зөвлөл 2 удаа цахимаар хуралдаж, 6 төрлийн үйлчилгээнд 9 иргэний асуудлуудыг шийдвэрлэж ажиллалаа.

11-р сард төр, төсвийн байгууллагад ажилд зуучлагдан орсон 1, шинэ ажлын байранд 1, ажилд орохыг хүссэн 2 иргэний бүртгэлийг хийж холбогдох байгууллагад хүргүүлж ажиллалаа.

Тайлант хугацаанд хяналт шалгалтыг 2 удаа хийж,8 иргэнд зөвлөн туслах мэдээлэл хүргэж ажилласан. Хяналт шалгалтын явцад Зохих зөвшөөрөлгүй бэлтгэгдсэн эзэн холбогдогчгүй 40 м3 нарсан гуалин бэлтгэсэн байсныг холбогдох байгууллагад хүлээлгэн өгсөн. Сумын Засаг даргын захирамжийн хүрээнд “Дуудлага худалдаа”-г зохион байгуулж орон нутгийн төсөвт 4.200.0 төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.

Байгаль хамгаалагч нар өөрсдийн хариуцсан газар нутагт хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх эргүүл шалгалтын ажлыг хуваарийн дагуу хийж гүйцэтгэн ажиллаж байна. Энэ сард ан амьтан агнах гахайн зөвшөөрөл 14, бор гөрөөс агнах эрхийн бичиг 2, Соёр шувуу 7 ширхэг, загас 60 кг бичигдэж 2.149.0 төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

Сумын Засаг даргын захирамжийн хүрээнд Тарвагатай 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах “Нүхэн гүүр” хяналтын цэгт батлагдсан хуваарийн дагуу байгаль хамгаалагч, аймгийн ОБГ-ын салбар эрэн хайх аврах анги, цагдаагийн хэсэг хамтран хяналтын цэгт зайлшгүй шаардлагатай зөвшөөрлийн бичигтэй дамжин өнгөрөх тээврийн хэрэгслийг бүртгэлжүүлэн ажиллаж байна.

Хүдэр сумын Тарвагатай 1-р багийн нутаг дэвсгэрт байрлах 4 га талбайн ил задгай ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгийг “Дархан төмөрлөг” ХХК-тай хамтран түрж цэвэрлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.

#### **Цагааннуур сум:**

“Дэлхийн алхалтын өдөр”-ийг тохиолдуулан идэвхтэй хөдөлгөөн, алхалтын ач холбогдлыг сурталчлан таниулахаар “Эрүүл мэндийнхээ төлөө-Алхангаа ярилцъя” өдөрлөгийг сумын Засаг даргын Тамгын газар, Спорт цогцолбор, Соёлын төв хамтран зохион байгууллаа.

Сумын хэмжээнд золбин нохой устгалын ажлыг 11-р сарын 02-06-ны өдрүүдэд зохион байгуулж 39 нохой устгасан.

Сумын Онцгой комисс 11 дүгээр сарын 04-ний өдөр “Маскаа зүүе-Гараа угааа” аяныг эрчимжүүлэх, өвөлжилтийн бэлтгэл ажил, галын аюулгүй байдлыг хангуулах талаар хуралдаж холбогдох байгууллагуудад үүрэг чиглэл өгч ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэн тухай 178 дугаар тогтоолын дагуу “Хатуу хөл хорио тогтоосон тухай” Улсын болон аймгийн Онцгой комиссын шийдвэр, холбогдох захирамж шийдвэрийг иргэдэд чанга яригч, сумын албан ёсны цахим хуудсаар дамжуулан мэдээлэл хүргэж ажиллаж байна. Өдөр бүр 13-15 төрийн албан хаагч батлагдсан хуваарийн дагуу эргүүл, хяналтын ажлыг хийж, “Бүдүүний гүүр” дээр хяналтын пост, ГХШШ-ын хариуцлагатай жижүүрийг 24 цагаар ажиллуулж байна.

Бага насны хүүхдэд тавих хараа хяналтыг сайжруулах зорилгоор сумын хамтарсан баг тандалт судалгааг хийж хоол, хүнсний дэмжлэг шаардлагатай 34 өрхөд хүнс, ахуйн хэрэглээний барааны дэмжлэг, хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, түлээ түлш нэн шаардлагатай 14 өрхөд түлээний модны дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Суманд үйл ажиллагаа явуулдаг ойн мэргэжлийн байгууллага болох “Шинэ бадрах” ХХК, “Бүтээлийн нуур” ХХК, ойн нөхөрлөлүүдээр түлшний мод бэлтгүүлэн борлуулахаар хамтран ажиллах гэрээг СДОА-тай байгуулсан. Мөн Түшиг сумын “Улаан овоотын нүүрсний уурхай”-аас нэгдсэн журмаар нүүрс татан иргэдээс захиалга авч хүргэлтээр худалдан борлуулах ажлыг зохион байгуулж байна.

Спорт цогцолборт эмчийн болон хувцас солих өрөө, 10 ортой тусгаарлах байр, ЭМТ-д 3 ортой тусгаарлах тасгийг бэлтгэн бэлэн байдлыг ханган ажиллаж байна.

Ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг сумын нийтийн эзэмшлийн зам талбай, худалдаа үйлчилгээний газрууд, худгууд, шатахуун түгээх станцуудад батлагдсан хуваарийн дагуу хийж байна.

Сүхбаатар сумын 1 дүгээр сургууль, спортын сургуулийн дотуур байранд амьдардаг 15, МСҮТ-ийн 10 хүүхдийг нэгдсэн журмаар татан авч эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч ажиллалаа.

Иргэний бүртгэлийн чиглэлээр төрсний бүртгэл 6, эцэг тогтоолтын бүртгэл 1, гэрлэсний бүртгэл 1, нас барсны бүртгэл 4, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 13, иргэний үнэмлэх дахин авах бүртгэл 3, иргэний үнэмлэх олголтын бүртгэл 18, лавлагаа олголт 9 хийж ажиллалаа.

Нийгмийн даатгалын үйлчилгээ 11-р сард тэтгэврийн даатгалын сангаас 741 иргэнд 260162.2 мян.төгрөг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 4 иргэнд 1417.6 мян.төгрөг, халамжийн сангаас 1712 иргэнд 588786.0 мян.төгрөг олгоод байна.

Сумын татварын орлого 11-р сард 146994.4 мян.төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 23-ны өдрийн байдлаар 161497.9 мян.төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 109.9 хувийн биелэлттэй байна.

Орон нутагт аймгаас 11-р сард 800762.2 мян.төгрөгийн санхүүгийн дэмжлэг ирэхээс 598123.6 мян.төгрөгийн санхүүгийн дэмжлэг ирж, орон нутгийн байгууллагуудын санхүүжилт олгогдсон. ОНХС-ийн санхүүжилт 143858.5 мян.төгрөгийн санхүүжилт ирж 113498.8 мян.төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Төрийн сангийн дансаар 705.591.8 мян.төгрөгийн 302 гүйлгээ хийгдсэн байна.

“Өвлийн идэш-2020” арга хэмжээний хүрээнд Сүхбаатар сумын 11 иргэнд өвлийн идэш хүргэх ажил зохион байгуулж, Улаанбаатар, Дархан-Уул, Орхон, Төв аймагт өвлийн идэш хүргэх 31 иргэний судалгааг гаргаж ажиллалаа. 11-р



сарын 24-ний өдрийн байдлаар Сүхбаатар сумын 6 иргэн 12 үхэр, 150 хонь бэлтгэх захиалга ирүүлээд байна.

**Шаамар сум:**

11-р сард сумын Засаг даргын А захирамж 10 , Б захирамж 1, сумын Засаг дарга, Тамгын газрын даргаас явсан бичиг 40, аймгийн Засаг даргын Тамгын газраас 10 бичиг ирснээс хариутай 4 бичигт хяналт тавьж хариуг хүргүүлэн ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын 178 тогтоол, аймгийн Засаг даргын А/306, А/310 захирамж, аймгийн Онцгой комиссын 05 тогтоолын дагуу зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, бүх шатны боловсролын байгууллагын хичээл, сургалтын болон зарим төрлийн үйл ажиллагааг түр зогсоож цагийн хязгаарлалт тогтоож, бүх нийтийн бэлэн байдлын горимыг хэрэгжүүлж тусгаарлах болон ажиглах байр, шуурхай штабыг 24 цагаар тасралтгүй ажиллуулж байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдах 29 өргөдөл хүлээн авч холбогдох баримт бичгийг бүрдүүлэн шаардлагатай материалуудыг амьжиргааг дэмжих зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэж, дээд шатны байгууллагад уламжлан тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжид байнгын асаргаа 10, цалинтай ээж 2, жирэмсэн эх 2, ахмадын амралт, сувилал 4, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт 1, түлээний хөнгөлөлтөд 4, шинэ төрсөн хүүхдийн мөнгөнд 3, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэврийн сунгалт 3, тэжээгчээ алдсаны тэтгэмжийн сунгалт 1 иргэний асуудлыг шийдвэрлэж ажиллалаа. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдсан зорилтот бүлгийн 12 өрхөд цахим картыг олгож, 89 гишүүнд 11-р сарын хүнсний тэтгэмж болох 1.600.0 төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг гэрээт байгууллагаар дамжуулан олгож ажиллалаа.

Нийгмийн даатгалын сангаар 23 ажил олгогч, сайн дурын даатгалд 1 иргэнийг хамруулж нийт 28750.55 сая төгрөг төвлөрүүлж ажиллахаас 11-р сард 33648,0 сая төгрөг төвлөрсөн байна. Тэтгэврийн даатгалын сангаас 347 өндөр настанд 131906503 сая төгрөг, 94 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 30137562 сая төгрөг, 26 тэжээгчээ алдсан иргэнд 8500000 сая төгрөг, 5 цэргийн өндөр настанд 3277589 сая төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас жирэмсний амаржсаны 1 иргэнд 12636700 төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 1 иргэнд 2148237 мян.төгрөг, жирэмсний амаржсаны 1 иргэнд 12636700 мян.төгрөгийг тус тус олгоод байна.

Мал эмнэлгийн Ерөнхий газрын 01/1205 албан тоотын дагуу мал эмнэлгийн гэрчилгээг цагийн хязгаарлалтгүй, түргэн шуурхай олгон ажиллаж байна. Мал эмнэлгийн нийт 97 төрлийн гэрчилгээ бичигдсэнээс адуу 26, үхэр 202, хонь 50, ямаа 70 толгой малд, мал амьтны бүтээгдэхүүн үхрийн мах 1510 кг, ямааны мах 60 кг байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 122 тогтоолын дагуу үндэсний үйлдвэрт хонины ноос бэлтгэн тушааж байна. Сумаас гадагш мах бэлтгэх Дэлгэрхаан багаас 55, Охь хөндий багаас 46, Дулаанхаан багаас 39 толгой бод мал, 59 толгой бог малын судалгааг явуулсан. Сум хөгжүүлэх сангийн 10 сарын эргэн төлөлт 705000 төгрөгийг нэгтгэлийн программд төлөлт хийсэн.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:  
МЭРГЭЖИЛТЭН

Д.АЛТАНТУЯА